



ХҮЧИРХИЙЛЛИЙН НҮЦГЭН ҮНЭН

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН
ХҮЧИРХИЙЛЛИЙН СУДАЛГААНЫ
ТАЙЛАН – 2017

УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

Судалгааны тайлан хянасан:

А.Ариунзаяа	ҮСХ–ны дарга, Зөвлөлдөх хорооны дарга
Наоми Китахара	Монгол дахь НҮБХАС–гийн суурин төлөөлөгч
Ч.Баянчимэг	ҮСХ–ны дэд дарга
А.Дэмбэрэл	ҮСХ–ны ҮТШСГ–ын дарга
А.Амарбал	ҮСХ–ны ХАНСГ–ын дарга
Хенриттэ Янсэн	НҮБХАС–гийн АНДБ–ийн зөвлөх
Жессика Гарднер	НҮБХАС–гийн АНДБ–ийн зөвлөх
Кларе Хоениг	НҮБХАС–гийн АНДБ–ийн төслийн ажилтан

Судалгааны тайлан бичсэн:

Н.Должинсүрэн	ҮСХ–ны ХАНСГ–ын ахлах статистикч
З.Хандармаа	Судалгааны үндэсний зохицуулагч
Ш.Ариунболд	ҮСХ–ны ҮТШСГ–ын ахлах статистикч
С.Дарьмаа	ҮСХ–ны ХАНСГ–ын статистикч
С.Болормаа	ҮСХ–ны ХАНСГ–ын статистикч
О.Норовсамбуу	ҮСХ–ны ХАНСГ–ын шинжээч
Т.Оюунсүрэн	ҮСХ–ны ХАНСГ–ын шинжээч

Тайлбар: Судалгааны үндсэн үр дүнгийн энэхүү тайлан нь англи хэлээр мөн хэвлэгдсэн бөгөөд тайланд гарч байгаа үнэлэлт, дүгнэлтүүд нь зөвхөн бичсэн хүмүүсийн санал болно.

Үндэсний Статистикийн Хороо нь 2017 онд Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааг НҮБ–ын Хүн амын сан болон Швейцарийн Хөгжлийн Агентлагийн техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр анх удаа зохион байгуулж явуулсан.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу
Засгийн газрын III байр
Утас: (976–11–326414)
Факс: (976–11–324518)
Цахим хуудас: www.nso.mn
И–мэйл: international@nso.mn

Үндэсний Статистикийн Хорооноос эрхлэн гаргав.
Улаанбаатар хот, Монгол улс, 2018 он

ӨМНӨХ ҮГ

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалыг ашиглан, улс орон даяар анх удаа зохион байгуулсан жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайланг танилцуулж байгаадаа бид баяртай байна. Үндэсний статистикийн хороо энэхүү судалгааг хийсэн. Судалгааны сэдэв, агуулга нь хүний амьдралын эмзэг сэдвийг хөнддөг тул энэхүү судалгааг “Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлагын судалгаа” (ЭЭМАТС) нэрээр зохион байгуулж явуулсан.

Судалгаагаар Монголд эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийн хэлбэр, тархалт, шалтгаан, үр дагаврыг тодорхойлж, Тогтвортой хөгжлийн зорилтууд, ялангуяа жендэрийн тэгш байдлыг хангах 5 дугаар зорилтын шалгуур үзүүлэлт, үр дүнг тооцох, олон улсын түвшинд харьцуулагдахуйц чанарын болон тоон мэдээ, мэдээллийг цуглуулахыг хичээсэн болно. Энэхүү судалгааны дүн нь үндэсний бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нар, олон улсын байгууллага болон бусад хэрэглэгчдэд бодлого, хөтөлбөр тодорхойлоход ашиглах суурь мэдээлэл болохын зэрэгцээ эрдэмтэн, судлаачдад гүнзгийрүүлсэн судалгаа, шинжилгээний ажил хийхэд чухал эх үүсвэр болох юм.

Судалгаа, асуулгыг боловсруулахад үнэтэй санал, зөвлөгөө өгч, хамтран ажиллаж, дэмжсэн судалгааны Зөвлөлдөх хороо, Удирдах зөвлөлд гүнээ талархаж байгаагаа илэрхийлье. Мөн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Швейцарийн хөгжлийн агентлаг, Австралийн Засгийн газарт гүн талархлаа илэрхийлье.

Энэхүү томоохон хэмжээний судалгааг нарийвчлан төлөвлөж, гардан зохион байгуулсан судалгааны үндсэн багийн гишүүдийн нэр их хүчин зүтгэлийг зориуд тэмдэглэхийг хүсч байна. Өрх болон эмэгтэйчүүдээс мэдээлэл цуглуулах амаргүй ажлыг хийж гүйцэтгэсэн ярилцлага авагч судлаачдаас гадна Үндэсний статистикийн хорооны төв, орон нутгийн удирдлага, аймаг, сум, багийн удирдлага, хамт олон бодлого, техник арга зүйн болон бусад шаардлагатай дэмжлэгүүдийг үзүүлсэн бөгөөд тэдний сэтгэл зүтгэл, тууштай хөдөлмөр, манлайллыг онцлохгүй байх аргагүй юм.

Судалгаанд оролцож, өөрсдийн туулсан амьдралаасаа илэн далангүй хуваалцаж, үнэтэй мэдээлэл өгч хамтран ажилласан нийт эмэгтэйчүүдээ онцгойлон талархаж байгаагаа илэрхийлье. Бид бүгд хамтдаа Монголдоо охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын төлөө ажиллаж байгаа бөгөөд хүчирхийллийг устгахгүйгээр Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх боломжгүй юм. Монгол Улсын хүн амын эрх тэгш байдлыг хангаж, хүчирхийллээс ангид нийгмийг цогцлооход энэхүү судалгаа жинтэй хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА



А.АРИУНЗАЯА

НҮБ–ЫН ХҮН АМЫН САНГИЙН
СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ



НАОМИ КИТАХАРА

АГУУЛГА

Өмнөх үг	5
Талархал	6
Хүснэгтийн жагсаалт	7
Зургийн жагсаалт	7
Товчилсон үгийн жагсаалт	12
Судалгааны товч хураангуй	13
Бүлэг 1. ТАНИЛЦУУЛГА	19
1.1 Оршил	20
1.2 Монгол Улсын хүн ам, газар зүйн байршил	21
Бүлэг 2. СУДАЛГААНЫ ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ	25
2.1 Судалгааны зорилго, зохион байгуулалт	26
2.2 Тоон судалгаа	28
2.3 Чанарын судалгаа	33
Бүлэг 3. СУДАЛГААНД ХАМРАГДАЛТ, ХАРИУЛТЫН ТҮВШИН	35
3.1 Хариултын түвшин	37
3.2 Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн шинж байдал	38
3.3 Түүврийн төлөөлөх чадвар	40
3.4 Хамрагдалтын түвшин	42
3.5 Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн сэтгэл ханамж	42
Бүлэг 4. ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭЖ БУЙ ХҮЧИРХИЙЛЭЛ	43
4.1 Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэл	46
4.2 Хамтрагчийн зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэл	51
4.3 Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэл	53
4.4 Сэтгэл санааны хүчирхийлэл	54
4.5 Хянах зан үйл	58
4.6 Эдийн засгийн хүчирхийлэл	61
4.7 Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн байдал	66
4.8 Эмэгтэйчүүдийн зүгээс эрэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн хүчирхийлэл	67
Бүлэг 5. БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛ	69
5.1 Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэл	72
5.2 Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэл	75

5.3 Хүүхэд насанд буюу 15 хүртэлх насандаа хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд	79
5.4 Анхны бэлгийн харьцаа	80
5.5 Хамтрагч болон бусдын зүгээс үйлдсэн хүчирхийллийн харьцуулалт	81
Бүлэг 6. ЖЕНДЭР БОЛОН ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ХАНДЛАГА	85
6.1 Жендэр болон хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн талаарх эмэгтэйчүүдийн хандлага	86
6.2 Жендэр болон хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн талаарх эрэгтэйчүүдийн хандлага	91
Бүлэг 7. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД ХАМТРАГЧИЙН ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨЛӨӨЛӨЛ	95
7.1 Биеийн ерөнхий эрүүл мэнд	96
7.2 Амиа хорлох тухай бодох, оролдлого хийх	97
7.3 Эрүүл мэндийн санаа зовоосон бусад асуудлууд	99
7.4 Эмийн хэрэглээ	100
7.5 Архи, тамхины хэрэглээ	101
7.6 Бэртэл, гэмтэл	102
7.7 Нөхөн үржихүйн эрүүл мэнд	105
Бүлэг 8. ХАМТРАГЧИЙН ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	109
8.1 Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлийн хүүхдийн зан байдал, эрүүл мэндэд үзүүлсэн нөлөө	110
8.2 Хүчирхийлэл үйлдэж буйг харж, сонссон хүүхдүүд	112
8.3 Үе дамжсан хүчирхийлэл	112
Бүлэг 9. ХҮЧИРХИЙЛЛИЙГ ДАВАН ТУУЛЖ БУЙ БАЙДАЛ	115
9.1 Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн үедээ эмэгтэйчүүд хаана, хэнд ханддаг вэ?	116
9.2 Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хандсан байгууллага, үйлчилгээ	118
9.3 Хүчирхийллээс зугтаж гэрээсээ дайжиж байсан эсэх	121
9.4 Хүчирхийлэлд өртсөн эмэгтэй хариу үйлдэл үзүүлсэн эсэх	122
9.5 Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах хүчин зүйлсийн талаарх эмэгтэйчүүдийн санаа бодол	123
Бүлэг 10. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	125
10.1 Ерөнхий дүгнэлт	126
10.2 Олон улсын харьцуулалт	126
10.3 Бодлогын зөвлөмж	128
10.4 Цаашид хийх шинжилгээ, судалгааны зөвлөмж	128
Хавсралт 1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НЭР	129
Хавсралт 2. АСУУЛГЫН ХУУДАС	132
Хавсралт 3. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	176
Хавсралт 4. ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД	181
Хавсралт 5. ТҮҮВРИЙН БОЛОН ТҮҮВРИЙН БУС АЛДАА	204

ТАЛАРХАЛ

Маш нуугдмал шинжтэй хүчирхийллийн хэлбэрийн тухай үг нээн, өөрсдийн туршлагаа хуваалцахад цаг хугацаа зарцуулан хувь нэмрээ оруулсан эмэгтэйчүүдгүйгээр уг судалгааны ажлыг хэрэгжүүлэх боломжгүй байсан. Эдгээр эмэгтэйчүүдийн өгсөн мэдээлэл нь Монголчуудын хувьд, тухайлбал ирээдүйд жендэрт суурилсан хүчирхийлэлгүй нийгэмд амьдрахыг эрмэлзэж буй хэн бүхний хувьд маш үнэ цэнэтэй. Иймд мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагаанд идэвхийлэн оролцож 7300 гаруй эмэгтэйчүүдтэй ярилцлага зохион байгуулсан бүх эмэгтэй судлаачид, ахлагчид, мөн урт замыг туулсан жолооч нарт онцгойлон талархаж байна.

Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааг зохион байгуулах болон үр дүнгийн тайланг бичих ажлуудыг Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны (ҮСХ) судалгааны баг нь Монгол дахь төслийн үйл ажиллагааны зохицуулагчийн тусламжтайгаар хэрэгжүүлсэн. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, нийгмийн цөөнхийн эсрэг хүчирхийллийн талаарх чанарын судалгааг “ММСГ” ХХК зохион байгуулсан ба үр дүнг энэхүү тайланд мөн тусгасан болно. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сангийн (НҮБХАС) олон улсын зөвлөхүүд, мөн Ази Номхон Далайн Бүсийн Байгууллага (АПРО), Авсртали Улсын Худалдаа Гадаад Хэргийн Яам (DFAT) зэрэг байгууллагууд нь “kNOwVAWdata” төслийг дэмжин ажиллаж, судалгааны ажлын үйл явцад өндөр ач холбогдолтой техникийн туслалцааг үзүүлсэн юм.

Судалгааг Монгол Улсад Жендэрт Суурилсан Хүчирхийлэлтэй Тэмцэх Төслийн удирдах зөвлөлийн удирдлаган дор зохион байгуулсан бөгөөд нийт үйл ажиллагааг уялдуулах зорилгоор оролцогч байгууллагуудын гишүүдээс бүрдсэн Зөвлөлдөх Хороог байгуулж ажилласан. Зөвлөлдөх Хорооны гишүүд нь судалгааны асуулгыг боловсруулах, турших, урьдчилсан үр дүн болон эцсийн тайланг хянах зэрэг үйл ажиллагаанд өөрсдийн үнэтэй хувь нэмрийг оруулав.

НҮБХАС нь ҮСХ-той хамтран Швейцарийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр уг судалгааг хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү харамгүй тусламж нь өргөн уудам нутгийг хамарсан судалгааг зохион байгуулах боломжийг олгон, улмаар жендэрт суурилсан хүчирхийлэлд автсан гэр бүлүүдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, уг асуудалд арга хэмжээ авахыг сурталчлахад хэрэгцээтэй баримт, нотолгоог бүрдүүлэх үндсийг тавьсан билээ.

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Монгол Улсын хүн ам зүйн үндсэн үзүүлэлт	23
Хүснэгт 3.1. Хувь хүний асуулгад хариулсан түвшин	37
Хүснэгт 3.2. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд, байршил, насны бүлэг, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт болон хамтрагчийн хамаарлын байдлаар	39
Хүснэгт 3.3. Түүвэрт багтсан судалгаанд оролцогчдын мэдээлэл (жинлэсэн, жинлээгүй) болон нийт хүн ам дахь 15–49 насны эмэгтэй хүн ам (2017 оны Хүн ам, өрхийн бүртгэлийн сан)	41
Хүснэгт 5.1 Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (15–аас дээш насандаа) өртсөн эмэгтэйчүүд, хүчирхийллийн хэлбэр, үйлдлээр, 2017 он (N=7319)	76
Хүснэгт 5.2 Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэл, үйлдсэн газар (байршлыг хувиар илэрхийлэв), хүчирхийллийн хэлбэрээр, 2017 он	77
Хүснэгт 5.3 Одоогийн болон өмнөх хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэлд сүүлийн 12 сарын хугацаанд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлгээр, 2017 он	83
Хүснэгт 5.4 Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд сүүлийн 12 сарын хугацаанд өртсөн 15 болон түүнээс дээш насны охид эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлгээр, 2017 он	84
Хүснэгт 6.1. Тодорхой нөхцөлд бэлгийн харьцаанд орохоос татгалзаж болно гэж үзсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2017 он	90
Хүснэгт 7.1. Амиа хорлох бодол төрж байсан хамтрагчтай байсан/ эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийнхаа бэлгийн болон/эсвэл бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, насны ангиллаар, хувиар, 2017 (N=4739, N=2109, N=498, N=432)	98

ЗҮРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Монгол Улсын газрын зураг	21
Зураг 1.2. Монгол Улсын хүн амын нас, хүйсийн суварга, 2017 он	22
Зураг 1.3. Монгол Улсын хүн амын нягтрал (1 км ² нутаг дэвсгэрт ногдох хүний тоо) 2017 он	23
Зураг 2.1. Монгол дахь жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт	27
Зураг 2.2. Судалгааны мэдээлэл цуглуулах багийн хуваарь, чиглэл	31
Зураг 2.3. Зорилтот бүлгийн ярилцлагын оролцогчид	36
Зураг 3.1. Судалгаанд оролцогчдын насны тархалт (жигнэсэн болон жигнээгүй), түүвэрт сонгогдсон өрхөд байсан судалгаанд хамрагдах боломжтой 15–64 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	40
Зураг 4.1. Хамтрагчийн үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийллийн хэлбэр, хугацаагаар, 2017 он (N=6914)	44
Зураг 4.2. Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймаг, нийслэл, хугацаагаар, 2017 он (N=6914)	45
Зураг 4.3. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, хугацаагаар, 2017 он (N=6914)	46
Зураг 4.4. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлэг, хугацаагаар, 2017 он (N=6914)	46
Зураг 4.5. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, хүчирхийллийн үйлдэл, хугацаагаар, 2017 он (N=6914)	47
Зураг 4.6. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, хүчирхийллийн зэрэг,	

	хугацаагаар, 2017 он (N=2109)	48
Зураг 4.7.	Бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, давтамж, хугацаагаар, 2017 он	48
Зураг 4.8.	Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, боловсролын түвшинээр, 2017 он (N=6914)	49
Зураг 4.9.	Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хугацаагаар, 2017 он (N=6914)	49
Зураг 4.10.	Бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн статус, хугацаагаар, 2017 он (N=6914)	50
Зураг 4.11.	Хамтрагчийн зүгээс бие махбодын хүчирхийлэл үйлдэх болсон шалтгаан, уг хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2017 он (N=2109)	50
Зураг 4.12.	Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, хугацаагаар, 2017 он (N=6914)	51
Зураг 4.13.	Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, бэлгийн хүчирхийллийн хэлбэр, хугацаагаар, 2017 он (N=6914)	52
Зураг 4.14.	Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, давтамж, хугацаагаар, 2017 он (N=498)	52
Зураг 4.15.	Хамтрагчийн үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, бүс нутаг, хугацаагаар, 2017 он (N=6914)	53
Зураг 4.16.	Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлэг, хугацаагаар, 2017 он (N=6914)	54
Зураг 4.17.	Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, бүс нутаг, хугацаагаар, 2017 он (N=6914)	54
Зураг 4.18.	Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлэг, хугацаагаар, 2017 он (N=6914)	55
Зураг 4.20.	Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, боловсролын түвшин, хугацаагаар, 2017 он (N=6914)	56
Зураг 4.21.	Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хугацаагаар, 2017 он (N=6914)	56
Зураг 4.22.	Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн дүнд эзлэх хувь, хамтрагчийн статус, хугацаагаар, 2017 он (N=6914)	57
Зураг 4.23.	Хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, бүс нутаг, хугацаагаар, 2017 он (N=6914)	58
Зураг 4.24.	Хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлэг, хугацаагаар, 2017 он (N=6914)	59
Зураг 4.25.	Хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, боловсролын түвшин, хугацаагаар, 2017 он (N=6914)	59
Зураг 4.26.	Хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хугацаагаар, 2017 он (N=6914)	60
Зураг 4.27.	Хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн статус, хугацаагаар, 2017 он (N=6914)	60
Зураг 4.28.	Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, бүс нутаг, хугацаагаар, 2017 он (N=6914)	62
Зураг 4.29.	Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлгээр, хугацаагаар, 2017 он	62
Зураг 4.30.	Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн дүнд эзлэх хувь, боловсролын түвшин, хугацаагаар, 2017 он (N=6914)	63
Зураг 4.31.	Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хугацаагаар, 2017 он (N=6914)	64
Зураг 4.32.	Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн статус, хугацаагаар, 2017 он (N=6914)	64
Зураг 4.33.	Хамтрагчийн үйлдсэн хүчирхийллийн аливаа хэлбэрт өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, бүс	

	нутаг, хугацаагаар, 2017 он (N=6914)	65
Зураг 4.34.	Хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймаг, нийслэлээр, хугацаагаар, 2017 он (N=6914)	66
Зураг 4.35.	Хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлэг, хугацаагаар, 2017 он (N=6914)	67
Зураг 4.36.	Өөрт нь гар хүрээгүй байхад хамтрагчаа цохиж, зодсон эмэгтэйчүүд, байршил, бүс нутгаар, 2017 он	67
Зураг 4.37.	Өөрт нь гар хүрээгүй байхад хамтрагчаа цохиж, зодсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь, давтамжаар, 2017 он (N=609)	68
Зураг 5 а.	Бусдын зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймаг, нийслэл, хугацаагаар, 2017 (N=7319)	70
Зураг 5 б.	Бусдын зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймаг, нийслэл, хугацаагаар, 2017 (N=7319)	71
Зураг 5.1	Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, байршлаар, 2017 он (N=7319)	72
Зураг 5.2	Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, насны бүлгээр, 2017 он (N=7319)	73
Зураг 5.3	Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн мэдээлснээр, хүчирхийлэл үйлдэгчид болон хугацаагаар, 2017 он (N=7319)	73
Зураг 5.4	Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, үйлдлээр, 2017 он (N=7319)	74
Зураг 5.5	Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, боловсролын түвшин, хугацаагаар, 2017 он (N=7319)	75
Зураг 5.6.	Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хугацаагаар, 2017 он (N=7319)	75
Зураг 5.7	Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (5–аас дээш насандаа) өртсөн эмэгтэйчүүд, насны бүлэг, хүчирхийллийн хэлбэрээр, 2017 он (N=7319)	76
Зураг 5.8	Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (15–аас дээш насандаа) өртсөн давтамж, хүчирхийллийн хэлбэрээр, 2017 он (N1=723, N2=234)	77
Зураг 5.9	Бусдын зүгээс үйлдсэн хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүд уг хүчирхийллийг цагдаад мэдээлсэн байдал, 2017 он (N=234)	78
Зураг 5.10	Хүүхэд (15 хүрэлх) насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг тэмдэглэх карт, 2017 он	79
Зураг 5.11	Хүүхэд насандаа (15 хүртэлх насандаа) бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хот, хөдөөгийн байршлаар, 2017 он (N=7319)	79
Зураг 5.12	Хүүхэд насандаа (15 хүртэлх насандаа) бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж судалгааны үед мэдэгдсэн эмэгтэйчүүд, үйлдэгчээр, 2017 он (N=265)	80
Зураг 5.13	Эмэгтэйчүүд анх бэлгийн харьцаанд орсон нас, байршлаар, 2017 он (N=7232)	80
Зураг 5.14	Анх бэлгийн харьцаанд орохдоо хүсэж байсан эсэх, анх бэлгийн харьцаанд орсон насны бүлгээр, 2017 он (N=6814)	81
Зураг 5.15	Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь (N1=7319), хамтрагчийн үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь (N2=6914), хугацаагаар, 2017 он	81
Зураг 5.16	Бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүчирхийлэл үйлдэгч болон насны бүлгээр, 2017 он (N1=7319, N2=6914)	82
Зураг 5.17	Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь (N1=7319), хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь (N2=6914), хугацаагаар, 2017 он	82
Зураг 5.18	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, үйлдэгч, насны бүлэг, хугацаагаар, 2017 он	83
Зураг 6.1.	Тодорхой шалтгаанаар нөхөр нь эхнэрээ цохиж, зодох нь зөв гэж үзсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N1=5144, N2=2175)	86

Зураг 6.2.	“Сайн эхнэр, нөхөртэйгээ санал нийлээгүй ч үгийг нь дагадаг” гэсэн ойлголттой санал нийлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, боловсролын түвшнээр, 2017 он (N1=5144, N2=2175)	87
Зураг 6.3.	“Сайн эхнэр, нөхөртэйгээ санал нийлээгүй ч үгийг нь дагадаг” гэсэн ойлголттой санал нийлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, насны бүлгээр, 2017 он (N1=5144, N2=2175)	88
Зураг 6.4.	“Сайн эхнэр, нөхөртэйгээ санал нийлээгүй ч үгийг нь дагадаг” гэсэн ойлголттой санал нийлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, 2017 он (N1=5144, N2=2175)	89
Зураг 6.5.	“Гэр бүлд нөхөр нь илүү эрх мэдэлтэй байх ёстой” гэсэн ойлголттой санал нийлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, суурьшлаар, 2017 он (N1=5144, N2=2175)	89
Зураг 7.1.	Эрүүл мэндийн ерөнхий байдлаа үнэлсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2017 он (N=7319)	96
Зураг 7.2.	Хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал, хамтрагчийнхаа бэлгийн болон/эсвэл биеийн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N=4739, N=2109, N=498, N=432)	97
Зураг 7.3.	Сүүлийн 4 долоо хоногт хүнд буюу маш хүнд өвдөлттэй байсан хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N=4739, N=2109, N=498, N=432)	97
Зураг 7.4.	Амиа хорлох бодол төрж байсан, амиа хорлох оролдлого хийсэн, амиа хорлох оролдлого хийснийхээ дараа эмнэлгийн тусламж авч байсан хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N=4739, N=2109, N=498, N=432)	98
Зураг 7.5.	Хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн биеийн байдалтай нь холбоотой сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын тархалт, бэлгийн болон биеийн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=4739, N=2109, N=498, N=432)	99
Зураг 7.6.	Сүүлийн 12 сард мэс засалд орсон болон эмнэлэгт хэвтсэн хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, сүүлийн 12 сард бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N=4739, N=2109, N=498, N=432)	100
Зураг 7.7.	Сүүлийн сард эм хэрэглэсэн хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, эмийн төрлөөр, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=4739, N=2109, N=498, N=432)	100
Зураг 7.8.	Согтууруулах ундаа хэрэглэдэг хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хэрэглээний давтамжаар, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=4739, N=2109, N=498, N=432)	101
Зураг 7.9.	Тамхи хэрэглэдэг хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хэрэглээний давтамжаар, бэлгийн болон/эсвэл бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017	101
Зураг 7.10.	Хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртсөний улмаас бэртэл, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2017 он (N=2174)	102
Зураг 7.11.	Хамтрагчийнхаа бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн гэмтэл авсан давтамжийн хувь, 2017 (N=911)	102
Зураг 7.12.	Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь, гэмтлийн төрлөөр, 2017 (N=911)	103
Зураг 7.13.	Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь, гэмтлийн хүндрэлийн зэргээр, 2017 (N=911)	103
Зураг 7.14.	Хамтрагчийн бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж, гэмтсэн эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусламж авсан тохиолдол, 2017	104
Зураг 7.15.	Хамтрагчийнхаа хүчирхийллийн улмаас гэмтэл авч, эмнэлгийн тусламж авсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өөрийн бэртэл, гэмтлийн жинхэнэ шалтгаанаа эмнэлгийн ажилтанд хэлсэн эсэхээр, 2017 он (N=288)	105
Зураг 7.16.	Сүүлийн 5 жилд жирэмсэлсэн хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамгийн сүүлийн	

	хүүхдээ төрүүлэхдээ хүсч байсан эсэхээр, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N=1717)	105
Зураг 7.17.	Сүүлийн 5 жилийн хугацаанд жирэмсэн байхдаа согтууруулах ундаа хэрэглэж байсан хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=1717)	106
Зураг 7.18.	Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн асуудал, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=6621)	106
Зураг 7.19.	Сүүлийн 5 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн хамгийн сүүлийн хүүхдийн хүйс, хамтрагчийн хүссэнээр, хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=1717)	107
Зураг 7.20.	Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэдэг болон хамтрагч нь жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглэхийг нь хориглодог хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он	107
Зураг 8.1.	Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн, өртөөгүй 6–12 настай хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хүүхдүүдийнхээ зан байдалд хийсэн ажиглалт, 2017 он (N=1595), (N=985)	110
Зураг 8.2.	Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн, өртөөгүй анги улирсан болон сургууль завсардсан нэг болон түүнээс дээш хүүхэдтэй (6–12 насны) эмэгтэйчүүдийн хувь, 2017 он (N=1595), (N=985)	111
Зураг 8.3	Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн, өртөөгүй, хүүхдүүд нь (6–12 насны) гэрээсээ зугтсан эмэгтэйчүүдийн хувь 2017 он (N=1595), (N=985)	111
Зураг 8.4	Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хүүхдүүд нь ээжийгээ хүчирхийлэлд өртөж буйг харсан, сонссон (хэдэн удаа) гэж мэдүүлсэн эмэгтэйчүүдийн хувь 2017 он	112
Зураг 8.5.	Өөрсдийн болон хамтрагчийн хүүхэд байхдаа өссөн гэр бүлийн орчинд хүчирхийлэлтэй байсан гэж мэдүүлсэн эмэгтэйчүүдийн хувь, амьдралдаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн болон өртөөгүй байдлаар, 2017 он (N=6914)	113
Зураг 9.1.	Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн хамтрагчийнхаа зан авир, үйлдлийн талаар хэн нэгэнд хэлж, мэдэгдсэн хувь, 2017 он (N=2175)	116
Зураг 9.2.	Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдэд тусламж үзүүлсэн хүмүүс, хот, хөдөө, хувиар, 2017 он (N=2175)	117
Зураг 9.3.	Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн тусламж хүсэхээр хандсан байгууллага, үйлчилгээ, хувиар, 2017 он (N=2175)	118
Зураг 9.4.	Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн ямар нэгэн байгууллага, үйлчилгээнд хандсан шалтгаан, хувиар, 2017 он	119
Зураг 9.5.	Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн байгууллага, үйлчилгээнд сэтгэл хангалуун байдал, үйлчилгээгээр, 2017 он (N=647)	120
Зураг 9.6.	Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн ямар нэгэн байгууллага, үйлчилгээнд хандаагүй шалтгаан, хувиар, 2017 он	120
Зураг 9.7.	Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн гэрээ орхиж явсан давтамж, 2017 он (N=2175)	121
Зураг 9.8.	Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн гэрээ орхиж явах болсон шалтгаан, хувиар, 2017 он (N=1008)	121
Зураг 9.9.	Хамтрагчтай байсан/ байгаа эмэгтэйчүүдийн хамтрагчийнхаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийллийн улмаас гэрээсээ дайжсан эмэгтэйчүүдийн хувь, очсон газраар нь, 2017 он (N=1008)	122
Зураг 9.10.	Хамтрагчтай байсан/ байгаа, хамтрагчийн зүгээс үзүүлсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хариу эсэргүүцэл үзүүлснээр гарсан өөрчлөлт, 2017 он (N=1249)	123
Зураг 10.1	Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, судалгаа хийгдсэн орноор, хугацаагаар	127
Зураг 10.2	Хамтрагчийн зүгээс үйлдэж буй сэтгэл санааны хүчирхийлэл, улс орнуудаар, хугацаагаар	128

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ДХХ	Дотны хамтрагчийн хүчирхийлэл
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗБЯ	Зорилтот бүлгийн ярилцлага
ГЯ	Гүнзгийрүүлсэн ярилцлага
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ЛГБТ	Лесбиян, гей, бисексуаль, трансжендэр
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБЕЭЗК	Нэгдсэн үндэстний байгууллагын Европын Эдийн засгийн комисс
НҮБСК	Нэгдсэн үндэстний байгууллагын Статистикийн комисс
НҮБХАС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн Амын сан
НҮБХС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТХШН	Түүврийн хоёр дахь шатны нэгж
УБ	Улаанбаатар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАЗЭМС	Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаа
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЭМАТС	Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлага судалгаа
ЭЭҮБХ	Эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийлэл
ДЕФФ	Дизайн эффект

СУДАЛГААНЫ ТОВЧ ХУРААНГУЙ

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь газар зүйн байршил, соёл, шашин шүтлэг, нийгэм, эдийн засгийн байдлаас үл хамааран бүхий л хүрээг хамарсан дэлхий нийтийн тулгамдсан асуудал бөгөөд хүний эрхийн хамгийн түгээмэл зөрчлүүдийн нэг юм. Хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүд нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох эрхээ бүрэн эдэлж чадахгүй байна. Энэ нь бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, зарим тохиолдолд амь насаа алдахад хүргэдэг байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн цар хүрээ, шалтгаан, үр дагавар, чиг хандлага, онцлогийн талаарх ойлголт улс орнуудад хомс байгаа нь уг асуудлыг шийдэх хүчин чармайлтад саад бэрхшээлийг учруулсаар байна.

Өнөөг хүртэл Монгол дахь эмэгтэйчүүдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийллийн тархалт, хэв шинжийн талаар мэдээлэл хомс байсан нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох бодлогын чиглэлийг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл, нотолгоог гаргаж авах бодит хэрэгцээ шаардлага байсан юм. Тоо мэдээ, мэдээлэл хангалтгүй байгаатай холбоотойгоор Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн суурин төлөөлөгчийн газар жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх төслийг санаачилж, 2016 онд уг төслийг хэрэгжүүлэхээр Швейцарийн хөгжлийн агентлаг болон НҮБХАС–гийн техник, санхүүгийн дэмжлэгт үндэслэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн талаарх үндэсний хэмжээний судалгааг зохион байгууллаа. Энэ судалгаа нь Монгол Улсад уг сэдвээр хийсэн тоон болон чанарын анхны томоохон хэмжээний судалгаа юм.

Судалгааны зорилго

“Жендэрт суурилсан хүчирхийлэл” сэдэвт үндэсний хэмжээний судалгаа нь тоон болон чанарын гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд тоон судалгаанд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд ба эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн олон улсын судалгааны аргачлалыг, чанарын судалгаанд бусад орнуудын аргачлалыг авч ашиглав. Тоон болон чанарын судалгаа нь судалгааны үр дүнг харилцан нягтлах, баталгаажуулах зорилготой байлаа.

Үндсэн зорилт:

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн төрөл бүрийн хэлбэрүүд, тэдгээрийн тархалтын талаарх мэдээллийг ДЭМБ–ын аргачлалыг ашиглан дэлхий дахинд хийсэн бусад судалгаатай харьцуулахуйц байдлаар гарган авах (мөн НҮБ–аас гаргасан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх шалгуур үзүүлэлтүүд болон Тогтвортой хөгжлийн зорилтуудын 5.2.1 болон 5.2.2 дахь үзүүлэлтийг тооцох),
- Хамтрагчийн үйлдсэн хүчирхийлэл нь эмэгтэйн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж буй байдал, түүнчлэн ямар үр дагавартайг үнэлж тооцох,¹
- Эмэгтэйчүүдийг хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллээс хамгаалах/эрсдэлд оруулж байгаа/болзошгүй хүчин зүйлсийг судлах,
- Эмэгтэйчүүдэд хамтрагчаас нь учруулж буй хүчирхийллийг даван туулахад ашиглаж буй арга стратеги, үйлчилгээнүүдийг тодорхойлж, харьцуулах.

Судалгаагаар эмэгтэйчүүдийн өнөөгийн болон өмнөх хамтрагчдын зүгээс үйлдсэн бие махбод, бэлгийн хүчирхийллийн мэдээллийг цуглуулахад голлон анхаарсан ч, хамтрагчийн зүгээс үйлдсэн сэтгэл зүйн хүчирхийлэл, хамтрагч бус бусад этгээдийн зүгээс үйлдсэн бие махбод, бэлгийн хүчирхийлэл түүний дотор 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдлыг судлав. Эдгээр мэдээллийг Монгол Улсад үндэсний болон бүс нутгийн түвшинд хот, хөдөөд насны бүлэг, боловсролын түвшин, нийгэм, эдийн засгийн статусаар ангилан цуглуулав.

¹ Энэ судалгаанд “хамтрагч” гэдэгт одоогийн болон өмнөх нөхөр, хамтран амьдрагч, найз залуу зэрэг дотно харилцаатай байсан болон байгаа эрэгтэйчүүдийг хамруулна.

Судалгааны зохион байгуулалт

Үндэсний статистикий хороо энэхүү судалгааг НҮБХАС–гийн Ази, номхон далайн бүсийн олон улсын зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр удирдан, зохион байгууллаа. Олон улсын зөвлөхүүд судалгааны бүх үе шатанд буюу судалгааны бэлтгэлийг хангаж, төлөвлөхөөс эхлээд судлаачдыг сургах, тоон мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тайлан бичихэд туслаж ажиллав. Судалгааны үйл ажиллагааг хууль, эрх зүйн дагуу явуулахад дэмжлэг үзүүлж, нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын яамдын удирдах албан тушаалтнууд, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллагуудын төлөөлөөс бүрдсэн Судалгааны зөвлөлдөх хороог байгууллаа. Төслийн удирдах зөвлөлийн удирдлага дор уг зөвлөлдөх хорооны гишүүд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх бодлого боловсруулахад чиглүүлэх, судалгааны дүнг тараахад тусламж, дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаанд оролцов.

Тоон судалгааны хүрээнд хүн амд суурилсан өрхийн судалгаагаар Монгол Улсын бүх 21 аймагт мэдээлэл цуглууллаа. Ингэхдээ олон шатлалт түүврийн аргыг ашиглан 7860 өрхийг сонгосон бөгөөд өрхөөс судалгаанд хамрагдах шалгуурт нийцсэн 15–64 насны нэг эмэгтэйг санамсаргүйгээр сонгон нийт 7319 эмэгтэйтэй ярилцлага хийв (хамрагдалтын түвшин 98.0 хувь). Судалгааны мэдээллийг 2017 оны 5–6 дугаар сард цуглуулж, хувийн нууцлалыг бүрэн хангасан, ганцаарчилсан ярилцлагуудыг хийлээ. Ярилцлага авагч эмэгтэйчүүдийг нарийн шалгуураар сонгож, мэдээллийг аюулгүй, болгоомжтой цуглуулахад 21 хоногийн турш сургаж бэлтгэв.

Хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн хүчирхийлэл

Өрхөд суурилсан судалгаагаар: бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийлэл болон хянах зан үйл гэсэн хүчирхийллийн 5 хэлбэрийг судалсан бөгөөд эдгээр хүчирхийллийн хэлбэр тус бүрийн тодорхойлолтыг 2 дугаар бүлэгт танилцуулав. Монгол эмэгтэйчүүдийн талаас илүү хувь (57.9) нь хүчирхийллийн энэхүү 5 хэлбэрээс аль нэгд эсвэл хэд хэдэн хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн байна.

Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийллийг олон улсад харьцуулж ашиглах хандлагатай байдаг бөгөөд хүчирхийллийн эдгээр төрлүүдийн тодорхойлолт нэлээд тодорхой, түгээмэл байдаг. Монголд эмэгтэйчүүдийн 31.2 хувь нь амьдралдаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн байгаа нь олон улсын дундаж түвшин болох 30.0 хувьтай² ойролцоо байна. Энэ үзүүлэлт нь аймаг, нийслэлээр ялгаатай байгаа бөгөөд амьдралдаа бие махбодын болон/эсвэл хамтрагчийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Дархан–Уул (41.0%), Өмнөговь (39.7%), Говьсүмбэр (39.1%), Булган (35.7%), Ховд (32.9%) аймагт хамгийн их байна. Улаанбаатар хотод өмнө нь хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн 31.7 хувь нь амьдралдаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Улаанбаатар хотын хувьд хүчирхийллийн тархалтын хувь улсын хэмжээнд хамгийн өндөр биш байгаа ч бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын тоогоор хамгийн их буюу 140,000 орчим эмэгтэйчүүд хүчирхийллийн хохирогч болсон байна.

Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэл

Судалгаанд хамрагдсан өмнө нь хамтрагчтай байсан болон одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн 29.7 хувь нь амьдралдаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн бол 11.9 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна. Бие махбодын хүчирхийлэл нь хамтрагчийн хайр дурлалын харилцааны эхэн үед харьцангуй их үйлдэгддэг бөгөөд 20–34 насны залуу эмэгтэйчүүд бие махбодын хүчирхийлэлд илүүтэй өртөж байгааг судалгааны дүн харуулж байна. Хамтрагчийн статусаар авч үзвэл гэрлэж байгаад салсан, тусгааралсан арван эмэгтэй тутмын зургаа нь (64.0%) өмнөх хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртөж байсан бөгөөд таван эмэгтэй тутмын нэг нь буюу 21.0 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд хүчирхийлэлд өртсөн байна.

Бүс нутгийн болон боловсролын түвшнээр авч үзвэл ялгаа харагдаж байна. Боловсролын түвшин бага эмэгтэйчүүдийг боловсролын түвшин өндөр эмэгтэйчүүдтэй харьцуулбал бие махбодын хүчирхийллийн тохиолдлыг илүүтэй мэдээлэх хандлагатай байна. Хүчирхийллийн талаар олон дахин мэдээлсэн эмэгтэйчүүдийн хувьд хүчирхийллийн ноцтой хэлбэрт илүүтэй өртсөн байна.

Хүчирхийлэлд ихээр өртдөг гэж хариулсан эмэгтэйчүүд мөн хүнд хэлбэрийн хүчирхийллийн талаар түлхүү мэдээлсэн байна.

² ДЭМБ, Нөхөн үржихүйн эрүүл мэнд, судалгааны газар, Лондонгийн эрүүл ахуй, халуун орны анагаах ухааны сургууль, Өмнөд Африкийн анагаах ухааны судалгааны зөвлөл, 2013 он. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх дэлхий дахины болон бүс нутгийн тооцоолол: Дотно хамтрагчийн хүчирхийлэл, хамтрагч бус этгээдийн бэлгийн хүчирхийллийн тархалт, эрүүл мэндэд үзүүлсэн нөлөө. ДЭМБ: Женев хот

Хамтрагчийн зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэл

Бие махбодын хүчирхийлэлтэй харьцуулахад бэлгийн хүчирхийлэлд өртсөнөө мэдээлэх нь эмэгтэйчүүдийн хувьд илүү хүнд байдаг. Ялангуяа гэрлэсэн хосуудын хүрээнд үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн талаар ярих нь Монголын нийгэмд тийм ч тохиромжтой биш гэж үздэг. Гэвч өмнө нь хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн 8.0 хувь нь амьдралынхаа туршид, наад зах нь нэг удаа, хамтрагчийн зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн, 3.0 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд хамтрагчийн зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухайгаа мэдээлжээ.

Хамтрагчийн зүгээс үйлдсэн сэтгэл санаа, эдийн засгийн хүчирхийлэл, хянах зан үйл

Сэтгэл санаа, эдийн засгийн хүчирхийлэл нь бие махбод, бэлгийн хүчирхийллээс дутуугүй ноцтой бөгөөд хүчирхийллийн бусад хэлбэрээс илүүтэйгээр эмэгтэйчүүдэд нөлөөлдөг. Гэвч эмэгтэйчүүдийн эсрэг энэ төрлийн хүчирхийллийн цөөн тооны үйлдлийг асуулгад тусгасан бөгөөд энэ хэлбэрийн хүчирхийллийг судалгааны мэдээллээр хэмжихэд хүндрэлтэй байдаг. Гэвч судалгааны дүнгээс үзэхэд сэтгэл санааны хүчирхийллийн түвшин маш өндөр буюу эмэгтэйчүүдийн 40.3 хувь нь амьдралдаа сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн гэж хариулсан бол 22.4 хувь нь сүүлийн 12 сард сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн гэж хариулсан байна.

Монгол Улсын хувьд хянах зан үйлийн тархалтыг насны бүлгээр авч үзэхэд эрс ялгаатай байна. Тухайлбал, өмнө нь хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн 41.6 хувь нь амьдралдаа хамтрагчийн зүгээс тэдний зан үйлийг хянахыг оролддог гэж хариулсан бол 15–19 насны охидын 54.7 хувь нь өмнөх болон одоогийн хамтрагчийн зүгээс хянах зан үйлд өртсөн гэж хариулжээ.

Өмнө нь хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай таван эмэгтэй тутмын нэг нь (19.9%) амьдралдаа эдийн засгийн хүчирхийлэлд өртжээ. Энэ нь хөдөө, орон нутаг болон бусад бүстэй харьцуулахад Улаанбаатар хотод өндөр (22.9 хувь) байна. Улсын дунджаар сүүлийн 12 сарын байдлаар эмэгтэйчүүдийн 12.0 хувь нь эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байхад энэ үзүүлэлт Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 13.2 хувь байна.

Бусдын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн хүчирхийлэл

Энэхүү судалгаагаар хамтрагч бус бусад этгээдийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн гурван хэлбэрийг судалсан. Үүнд: 15 наснаас хойших хугацаанд бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал, 15 наснаас хойших хугацаанд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл (15 наснаас өмнө). Хүчирхийллийн эдгээр төрлүүдийн тодорхойлолтыг Бүлэг 2–т оруулсан болно.

15 наснаас хойш бусдын (хамтрагч бус) зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 17.3 хувь нь 15 нас хүрснээсээ хойш, 4.5 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна. Хүчирхийлэл үйлдэгчид нь ихэвчлэн эцэг эх, ах, дүү зэрэг гэр бүлийн гишүүд болон найз нөхөд, танилууд байна.

15 наснаас хойш бусдын (хамтрагч бус) зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал

Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн долоон хүн тутмын нэг (14.0 хувь) нь 15 наснаасаа хойш бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд 2.6 хувь нь сүүлийн 12 сард бэлгийн хүчирхийлэлд өртжээ.

Бэлгийн хүчирхийллийг дунд болон хүнд гэсэн хоёр хэлбэрт ангилсан. Дунд хэлбэрийн хүчирхийлэлд хүсээгүй байхад бэлгийн хавьталд хүчээр оруулахыг завдах, хүсээгүй байхад биед нь хүрэх, биеийн нууц хэсэгт хүчээр хүрэх зэрэг үйлдлүүдийг хамааруулсан. Хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд хүчээр бэлгийн харьцаанд оруулах, архи, мансууруулах бодис хэрэглэсэн үед хүчээр бэлгийн харьцаанд оруулах, нэгээс дээш хүнтэй хүчээр бэлгийн харьцаанд нэг дор оруулах зэрэг үйлдлүүдийг хамааруулсан. Амьдралдаа дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд нийт эмэгтэйчүүдийн 12.5 хувь нь өртсөн байхад хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд 3.1 хувь нь өртсөн байна. Хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн ердөө 10–хан хувь нь тухайн хэргийг цагдаад мэдэгдсэн байна.

15 наснаас өмнө бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал

Арван эмэгтэй тутмын нэг нь (10.7 хувь) 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж мэдээлжээ. Хүчирхийлэл үйлдэгч нь гэр бүлийн бусад гишүүд (29.5 хувь), найз нөхөд, танилууд (19.0 хувь), танихгүй хүн (18.7 хувь) байсан гэж ихэнх эмэгтэйчүүд хариулсан байна.

Хамтрагчийн болон бусдын зүгээс үйлдсэн хүчирхийллийг харьцуулах нь

Хамтрагчийн болон бусдын зүгээс үйлдсэн хүчирхийллийг харьцуулахад Монголд эмэгтэйчүүд бусдын зүгээс үйлдсэн хүчирхийлээс илүүтэйгээр хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртөх явдал 2 дахин их байна.

Хүчирхийлэлд хандах хандлага

Хамтрагчтай байсан болон байгаа эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь (55.4 хувь) гэр бүлд нөхөр нь илүү шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх буюу “сайн эхнэр нөхөртэйгөө санал нийлэхгүй байсан ч үгийг нь дагадаг” байх гэсэн үзэлтэй байна. Харин боловсролын түвшин өндөр эмэгтэйчүүдийн хувьд дээрх үзэлтэй санал нийлэх нь бага байна.

Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагүй дөрвөн эмэгтэй тутмын нэг нь буюу 22.2 хувь нь хэрэв эхнэр нь үнэнч бус байвал нөхөр нь цохиж, зодож болно гэж үзсэн байхад хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн 35.5 хувь нь үзэж байна.

Үүнээс харахад Монгол орны хувьд жендэрийн дүр төрх, нийгмийн хэм хэмжээ өөрчлөгдөж байгаа нь харагдаж байна. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагүй 15–19 насны эмэгтэйчүүдийн дөрөвний нэг буюу 25.6 хувь нь, харин 60–64 насны эмэгтэйчүүдийн гуравны хоёр нь буюу 65.9 хувь “сайн эхнэр нөхөртэйгөө санал нийлэхгүй байсан ч үгийг нь дагадаг” гэсэн итгэл үнэмшилтэй байна.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үр дагавар**Хүчирхийллийн улмаас авсан бэртэл, гэмтэл**

Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 42.8 хувь нь хүчирхийллийн улмаас бэртэл, гэмтэл авчээ. Эмэгтэйчүүдийн бараг гуравны нэг (32.1 хувь) нь нэг удаа, таван хүн тутмын хоёр (41.6 хувь) нь 2–5 удаа, дөрөвний нэгээс илүү (26.3 хувь) нь 5–аас олон удаа хүчирхийллийн улмаас бэртэл, гэмтэл авсан байна.

Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж бэртэл, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн ихэнх (71.6 хувь) нь хүнд буюу ноцтой бэртэж, таван эмэгтэй тутмын хоёр (21.0 хувь) нь хөнгөн гэмтэж, 5.0 хувь нь дунд зэрэг гэмтжээ. Гэмтэж, эмнэлгийн тусламж авсан эмэгтэйчүүдийн тал хүрэхгүй хувь (43.2 хувь) нь гэмтлийн бодит шалтгаанаа эмнэлгийн ажилтанд мэдээлсэн байна.

Бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн эрүүл мэндэд үзүүлсэн нөлөө

Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүд биеийн ерөнхий байдал, сэтгэцийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэд хэдэн асуултад хариулав. Судалгааны дүнг хамтрагчийн бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн ба өртөөгүй эмэгтэйчүүдийн хувьд харьцуулж үзэхэд хамтрагчийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд илүүтэйгээр өөрийн эрүүл мэндийг муу, маш муу гэж дүгнэжээ. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд сэтгэцийн эрүүл мэндийн өөрчлөлтийн хэд хэдэн шинж тэмдэг илэрч, амиа хорлох бодол төрөх явдал түлхүү тохиолдсон байна.

Хүчирхийлэл нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд нөлөөлдөг болохыг судалгааны дүн харуулсан. Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тал хувь нь (50.8 хувь) амьдралынхаа аль нэг мөчлөгт үр хөндүүлж байсан байхад хүчирхийлэлд өртөж байгаагүй гэж мэдүүлсэн эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт 29.5 хувь байна.

Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн хүүхдэд үзүүлсэн нөлөө

6–12 настай хүүхэдтэй, хамтрагчийн хүчирхийлэлд өртөж байсан болон өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн хүүхдүүдийн зан байдлыг харьцуулж үзэхэд хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хүүхдүүд илүү аймхай, зожиг, түрэмгий ааштай, хар дарж зүүдэлдэг гэж мэдээлсэн байна.

Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдээс тэдний хүүхдүүд уг хүчирхийллийг харсан, сонссон эсэх, ийм явдал хэдэн удаа тохиолдсоныг асуухад судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн ихэнх (91.6 хувь) нь хүүхдүүд хүчирхийллийг харж, сонсож байгаагүй гэжээ.

Хүүхдүүдийн эсрэг хүчирхийлэл, үе дамжсан хүчирхийлэл

Хүүхэд насандаа хүчирхийлэлд өртөх нь ирээдүйд хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлөх хүчин зүйл болж байна. Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бараг гуравны нэг (32.4 хувь)–ийнх нь хамтрагч бага байхдаа цохиулж, зодуулж байсан бол хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн хамтрагчийн 16.3 хувь нь бага байхдаа цохиулж, зодуулж байжээ.

Хамтрагчийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн ээж нь нөхөртөө цохиулж, зодуулж байсан тохиолдол (22.2 хувь) хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдтэй (12.6 хувь) харьцуулбал өндөр байна. Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн 3.4 хувь нь өөрийн хамтрагчийн ээж нь нөхөртөө цохиулж, зодуулж байсан гэж хариулсан байхад хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн ихээхэн хувь нь (17.3 хувь) ийнхүү хариулсан байна.

Хамтрагчийн хүчирхийллийг даван туулах арга, хүчирхийлэлд үзүүлсэн хариу үйлдэл

Дөрвөн эмэгтэй тутмын нэг (26.5 хувь) нь хамтрагчийнхаа үйлдсэн бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн талаар тухайн ярилцлагаас өмнө хэнд ч хэлж байгаагүй гэж хариулжээ. Хүчирхийлэлд өртсөн тухайгаа хэн нэгэнд хэлсэн хүмүүсийн хувьд ихэвчлэн гэр бүлийн гишүүддээ хэлдэг гэж хариулсан байна. Арван эмэгтэй тутмын нэг нь буюу 8.3 хувь нь хүчирхийллийн талаар цагдаад мэдэгддэг гэжээ.

Хүчирхийлэлд өртсөн үедээ тусламж эрэлхийлж, ямар байгууллагад хандсан эсэхийг асуухад бараг дөрвөн эмэгтэй тутмын нэг нь (23.9 хувь) нь цагдаад хандсан гэжээ. Арван эмэгтэй тутмын нэг (13.2 хувь) нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад, 12.5 хувь нь лам, шашны тэргүүнд хандсан гэж хариулсан бол хамгаалах байр болон бусад тусламж, үйлчилгээний байгууллагад маш бага буюу 1.5 хүрэхгүй хувь нь ханджээ.

Хүчирхийллийг тэвчих аргагүй болсон (эмэгтэйчүүдийн 68.6 хувь нь эрх мэдэл бүхий байгууллагаас тусламж хүсч), ноцтой бэртэл, гэмтэл авсан (42.7 хувь) нь бусдаас тусламж хүсэх гол шалтгаан болжээ. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн талаас илүү хувь (51.2 хувь) нь ямар нэгэн байдлаар гэрээ орхин багадаа нэг хоног явж байжээ.

Гэвч тэдгээр эмэгтэйчүүдийн бараг дөрөвний гурав нь хамтрагчаа уучилсан, гэр бүлийнхээ төлөө гэх шалтгаанаар гэртээ эргэн очсон байна.

ДҮГНЭЛТ

Үндэсний хэмжээнд хийгдсэн энэхүү судалгаагаар хохирогчдод үзүүлэх үйлчилгээг сайжруулах, хууль эрх зүйн болон сэтгэлгээний өөрчлөлт хийх ухуулга нөлөөллийн үйл ажиллагаанд ашиглах Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлийн талаарх тоон болон чанарын мэдээллийг бий болгосон. Энэ судалгаа нь ихэнх тохиолдолд хаалттай хаалганы цаана үйлдэгдэн нууц хэвээр үлддэг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үйлдлүүдийг олж илрүүлснээрээ онцлог юм. Олон эмэгтэйн хувьд хамтрагчийнх нь зүгээс үйлдсэн хүчирхийлэл тэдний амссан цор ганц хүчирхийлэл биш байлаа. Тэд 15 наснаасаа хойш эцэг, эх, ах дүүс, гэр бүлийн бусад гишүүд эсвэл огт танихгүй этгээдийн зүгээс үйлдсэн бие махбодын эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна.

Судалгааны үндсэн үр дүн:

- Эмэгтэйчүүдийн 29.7 хувь нь хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байхад 17.3 хувь нь бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байгаагаас үзвэл хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртөх нь илүүтэй байгааг харуулж байна.
- Урьд өмнө хамтрагчтай байсан болон одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн 14.0 хувь нь бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байгаа нь Ази, номхон далайн бүсийн бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна.
- Эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 42.8 хувь хүчирхийллийн улмаас бэртэл, гэмтэл авсан бөгөөд тэдгээр эмэгтэйчүүдийн 71.6 хувь нь хүнд буюу ноцтой бэртсэн байна. Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд өөрсдийнхөө эрүүл мэндийн байдлыг ихэвчлэн муу хэмээн дүгнэж, сэтгэцийн өөрчлөлтийн хэд хэдэн шинж тэмдэг тэдэнд илэрсэн тухай мэдээлжээ.

- Гэр бүлийн хүчирхийлэл нь хүүхдүүд болон гэр бүлийн бусад гишүүдэд нөлөөлдөг. Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хүүхдүүд нь хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн хүүхдүүдээс илүү зан харьцааны доголдолтой байна. Хүүхэд насандаа гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсвэл хүчирхийллийг харж байсан хүүхдүүд насанд хүрэхээрээ хүчирхийлэгч хамтрагчтай дотно харьцаанд орох магадлал өсөж байгаа хандлага байна.
- Хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийн хувьд нас, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт, байршилын онцлог ялгаа ажиглагдахгүй байна.

БҮЛЭГ 1.

ТАНИЛЦУУЛГА



1.1 ОРШИЛ

Өнөөдөр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялангуяа жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ) нь эрүүл мэнд, хүний эрх, үндэсний хөгжилд өргөн хүрээнд нөлөөлсөн нийгмийн хамгийн том тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх мэдлийн тэнцвэртэй бус байдлаас үүдэлтэй бөгөөд энэ нь уг тэгш бус байдлыг улам даамжруулдаг. Эмэгтэйчүүд, тэдний гэр бүл, хамт олны эрүүл мэнд, аж байдалд сөргөөр нөлөөлж буй энэхүү эмзэг асуудлыг сөхөн гаргах нь асуудлын учир шалтгааныг тодорхойлж, хүчирхийллийг таслан зогсоох шийдлийг олоход чухал ач холбогдолтой.

Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл нь хамгийн түгээмэл тохиолддог боловч хамгийн цөөн мэдээлэгддэг хүний эрхийн зөрчил юм. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэг хязгаарлагдмал, Монголын нийгэмд жендэрт суурилсан хүчирхийллийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөгийн улмаас хүчирхийллийн талаарх баримт нотолгоо хангалтгүй байна. Хүчирхийлэлд өртөгсдийн ихэнх нь хүчирхийллийг мэдээлэхгүй байгаа нь тэдэнд үзүүлэх тусламж үйлчилгээний хувилбар, боломж хязгаарлагдмал, хүчирхийлэл үйлдэгчийг бус хүчирхийлэлд өртөгчийг буруутгах хандлага бүхий нийгэм, соёлын хэм хэмжээ давамгайлж байгаатай холбоотой³.

Хүчирхийлэл нь охид, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас 2013 онд хийсэн судалгаагаар бие махбодын эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд нь хамтрагчийн хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад бэлгийн замын халдвар авах магадлал 1.5 дахин, үр хөндүүлэх магадлал 2 дахин их байна⁴. Жирэмсэн байх үед нь хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл нь үр зулбах, амьгүй хүүхэд төрүүлэх, дутуу төрөх эсвэл бага жинтэй хүүхэд төрүүлэх магадлалыг нэмэгдүүлдэг. Харамсалтай нь хамгаалах, урьдчилан сэргийлэх тогтолцооны хүрээнд хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээгээр өнөөг хүртэл хангаж чадахгүй байна⁵. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг бүрэн эмчлэхэд эрүүл мэндийн үйлчилгээний өнөөгийн хэлбэр, зохион байгуулалт хангалтгүй байна.

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаас гадна ЖСХ нь хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, тэдний хүүхдүүдийн бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд урт, богино хугацаанд ноцтой хохирол учруулдаг. Хүчирхийлэл нь мөн эдийн засгийн томоохон сөрөг үр дагавартай. Тухайлбал гэмтэл, бэртлийг эмчлэх эмчилгээний зардлаас эхлээд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн бүтээмж буурах, эсвэл хөдөлмөрийн чадвараа алдаж, ажил хийх боломжгүй болох гэх мэт. Мөн хүчирхийлэлтэй гэр бүлд өссөн хүүхдүүд эрсдэлтэй зан үйл гаргах, сэтгэл санааны гүн хямралд орохоос гадна насанд хүрсэн үедээ өөрсдөө хүчирхийлэл үйлдэх юмуу эсвэл хүчирхийлэлд өртдөг нийгмийн сөрөг үр дагавартай⁶.

Иймд дэлхийн улс орнууд түүний дотор Монголд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн цар хүрээ, тархалтын талаарх мэдээлэл, нотолгоо бий болгох шаардлага тулгараад байна. Үүнийг НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд хөрөнгө нөөц дайчлах, стандарт боловсруулах, техник арга зүйн тусламж үзүүлэх замаар дэмжиж байна.

Монгол Улсад “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” тухай хуулийг анх 2004 онд баталсан бөгөөд 2016 оны 12 дугаар сард уг хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2017 оны 2 дугаар сарын 1-нээс мөрдөж байна. Энэ хууль нь Эрүүгийн хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиудтай уялдан хэрэгжих цогц хууль болсон. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2004 онд батлагдсанаас хойш Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр⁷ 2007 онд батлагдан, хэрэгжив. Улсын Дээд шүүхээс уг хуулийн зарим зүйл заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэх тухай тайлбар⁸ гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой

³ Freedom House (2014). Freedom in the World: Mongolia. <https://freedomhouse.org/report/freedom-world/2014/mongolia>

⁴ Violence against women: Intimate partner and sexual violence against women. (2014). World Health Organization. <http://www.who.int/mediacentre/factsheets/fs239/en/>

⁵ Violence against women: Intimate partner and sexual violence against women. (2014). World Health Organization. <http://www.who.int/mediacentre/factsheets/fs239/en/>

⁶ Violence against women: Intimate partner and sexual violence against women. (2014). World Health Organization. <http://www.who.int/mediacentre/factsheets/fs239/en/>

⁷ Засгийн газрын 2007 оны 255 дугаар тогтоол.

⁸ Улсын дээд шүүхийн 2006 оны 47 дугаар тогтоол.


журмуудыг⁹ батлан гаргав.

Хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах байруудыг байгуулж, хүчирхийлэлд өртөгсдөд зөвлөгөө өгөх тусламжийн утасны үйлчилгээг нэвтрүүлж, эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, нийгмийн халамж, хамгаалал, хууль зүйн дэмжлэг үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний 3 төвийг 2009 онд Улаанбаатар хотод байгуулав. Улмаар Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймгуудад 2013–2014 онд нэг цэгийн үйлчилгээний гурван төв нэмж байгуулав. Гэвч ЖСХ–д өртөгсдийн хэрэгцээг хангах, үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх байгууллагын тоо хангалтгүй хэвээр байна. Иймд энэхүү судалгааны урьдчилсан үр дүнд үндэслэн Монгол Улсын долоон аймаг, Улаанбаатар хотын гурван дүүрэгт нэг цэгийн үйлчилгээний 10 төвийг шинээр байгуулахаар төлөвлөж байна.

1.2 МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ, ГАЗАР ЗҮЙН БАЙРШИЛ

Монгол Улс зүүн Азийн зүүн хойд хэсэгт нийт 1564.1 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутгийг эзлэн оршдог бөгөөд хойд хэсгээрээ Оросын Холбооны Улс, өмнөд хэсгээрээ Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хиллэдэг. Улсын хилийн нийт урт 8252.7 километр.

Зураг 1.1. Монгол Улсын газрын зураг



Монгол Улс нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ дэлхийд 19 дүгээр байранд ордог, далайн түвшнээс дээш дунджаар 1580 метр өндөрт өргөгдсөн, хамгийн өндөр цэг нь Хүйтэн уулын оргил 4374 метр, хамгийн нам цэг нь Хөх нуурын хотгор 532 метр, далайд гарцгүй орон юм. Нутгийн баруун болон хойд хэсэгт нь уулархаг, ойн бүс, зүүн хэсэгт тал хээрийн бүс, өмнөд хэсэгт говийн бүс зонхилдог.


Хавар, зун, намар, өвөл гэсэн жилийн 4 улиралтай, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Хамгийн их салхи шуургатай үе дөрөв, тавдугаар сард тохиодог. Нэгдүгээр сард хамгийн хүйтэн (-10° –аас -30°C), долоодугаар сард хамгийн халуун ($+10^{\circ}$ –аас $+27^{\circ}\text{C}$) байдаг.

Монгол Улс нь засаг захиргааны нэгжийн хувьд 21 аймаг, нийслэлд, аймгууд нь 330 сумдад, сумдууд нь 1613 багт, нийслэл нь 9 дүүрэгт, дүүргүүд нь 152 хороодод хуваагддаг. Монгол Улсын албан ёсны хэл нь монгол хэл бөгөөд Монголчууд

⁹ “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” ХЗДХ, НХХ–ийн сайдын хамтарсан тушаал. 2009 он. “Гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн нөхцөл байдлыг тодорхойлох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулын түвшингийн зэргийг тодорхойлох” заавар 2009 он. “Цагдаагийн ажилтнаас хохирогчийг төлөөлөн эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах заавар. ХЗДХ, НХХ–ийн сайдын хамтарсан тушаал. 2009 он

үндэсний бичиг, үсэг, соёлын өв баялагаа хадгалж үлдсэн ард түмэн юм. Хүн амын олонх буюу 53.0 хувь нь буддын шашин шүтдэг. Монгол Улсын хүн ам 2017 оны байдлаар 3.2 сая болж жилийн дундаж өсөлт 1.9 хувь болсон байна.

Зураг 1.2. Монгол Улсын хүн амын нас, хүйсийн суварга, 2017 он



Эх сурвалж: Хүн ам, өрхийн мэдээллийн сан (2017)

Нийт хүн амын 49.2 хувийг эрэгтэйчүүд, 50.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. (Зураг 1.2). Монгол Улсын хүн ам харьцангуй залуу бүтэцтэй бөгөөд хөдөлмөрийн насны (15–64 насны) хүн амын эзлэх хувь (65.7%) өндөр, хөдөлмөрийн насны 100 хүнд ноогдох хөдөлмөрийн бус насны хүн ам 52 байна.

Монгол Улс хүн амын хамгийн бага нягтралтай орны тоонд ордог бөгөөд 2017 оны байдлаар 1 км² нутаг дэвсгэрт 2.0 хүн ногдож байна. Зураг 1.3–т Монгол Улсын хүн амын нягтралыг газар зүйн байршлаар харуулав.

Зураг 1.3. Монгол Улсын хүн амын нягтрал (1 км² нутаг дэвсгэрт ногдох хүний тоо) 2017 он



Хүснэгт 1.1. Монгол Улсын хүн ам зүйн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	1979	1989	2000	2010	2015	2017
Нийт хүн ам (мян.хүн)	1595.0	2044.0	2374.0	2761.0	3057.8	3177.9
Эрэгтэй (нийт хүн амд эзлэх %)	50.1	49.9	49.6	48.6	49.2	49.2
Эмэгтэй (нийт хүн амд эзлэх %)	49.9	50.1	50.4	51.4	50.8	50.8
0–14 нас (нийт хүн амд эзлэх %)	44.2	41.9	35.8	28	30.1	30.4
15–64 нас (нийт хүн амд эзлэх %)	50.8	54.1	60.8	68.2	66.1	65.7
65+ нас (нийт хүн амд эзлэх %)	5.0	4.0	3.5	3.8	3.8	3.9
15–49 насны эмэгтэйчүүд (%)	21.2	23.5	27.2	30.5	28.1	27.2
Хүйсийн харьцаа (100 эмэгтэй тутамд)	100.3	99.7	98.5	94.6	96.7	96.7
Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь	2.9	2.5	1.4	1.6	2.1	1.9


Эх сурвалж: Хүн ам, орон сууцны тооллого (1979, 1989, 2000, 2010, 2015), Хүн ам, өрхийн мэдээллийн сан (2017)



БҮЛЭГ 2.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлгээр



Амьдралдаа хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийллийн улмаас бэртэл, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн бэртэл, гэмтэлийн түвшин, дүнд эзлэх хувиар



2.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлийн талаарх энэхүү үндэсний хэмжээний судалгаа нь НҮБ-ын Хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр 2016 оны 6 дугаар сараас 2020 оны 5 дугаар сар хүртэл хэрэгжих Монгол дахь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Хууль зүй, дотоод хэргийн яам, НҮБ-ын Хүн амын сан хамтран ахалдаг төслийн удирдах хорооны удирдлага, хяналтын дор хэрэгждэг энэхүү төсөл нь хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн цар хүрээ, мөн чанар, ерөнхий нөхцөл, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх тоо мэдээ, мэдээллийг цуглуулах чадавхийг дээшлүүлэх, хохирогчдыг үр дүнтэй хамгаалах орчныг дэмжих, олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах замаар жендэрт суурилсан хүчирхийлэл ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх зорилготой.¹⁰ Энэхүү төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын аргачлалыг ашиглан хийлээ. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх тоон мэдээ, мэдээллийг үндэсний түвшинд цуглуулж, цаашид энэ төрлийн статистик мэдээллийг боловсруулах Үндэсний статистикийн хорооны чадавхийг хөгжүүлэхэд энэ судалгаа үнэтэй хувь нэмрээ оруулсан.

Судалгаа тоон болон чанарын судалгаа гэсэн хоёр хэсгээс бүрдсэн. Судалгаагаар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр, тархалт, нөлөө, шалтгааныг нотлох баримт, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллага, Тогтвортой хөгжлийн зорилтын холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг тооцож, олон улсад тайлагнаж, харьцуулах тоон, мэдээ, мэдээллийг бий болгох зорилготой.

Судалгааны зорилго

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндэсний хэмжээний статистик тоо мэдээ, мэдээллийг энэхүү судалгаагаар бий болгох, мэдээллийн эх үүсвэртэй болох зорилготой.

Зорилтууд:

- Одоогийн болон/эсвэл өмнө нь байсан хамтрагч болон/эсвэл бусдын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн хүчирхийллийн олон хэлбэрийн тархалт, тохиолдлын талаарх бодит тоон мэдээ, мэдээллийг (Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх шалгуур үзүүлэлт, Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ын 5.2.1 болон 5.2.2 үзүүлэлтүүдийг тооцох) ДЭМБ-ын аргачлалыг ашиглан дэлхийн бусад орнуудад хийгдсэн судалгааны үр дүнтэй харьцуулах боломжтой байдлаар гаргах;
- Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүдийн бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, гэр бүл, хөдөлмөрийн чадварт учирсан нөлөө, үр дагавар, тэдгээрийн уялдаа холбоог илрүүлэх;
- Эмэгтэйчүүдийг хамтрагчийн зүгээс үйлдэх хүчирхийллээс урьдчилан сэргийлэх эсвэл хүчирхийллийн эрсдэлд оруулж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлох;
- Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийг даван туулж, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор эмэгтэйчүүдийн ашиглаж байгаа буй арга, стратеги, үйлчилгээнүүдийг тодорхойлж, баримтжуулах, харьцуулах;

Энэхүү судалгаа нь

- Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх шалгуур үзүүлэлт, Тогтвортой хөгжлийн зорилт(ТХЗ)-ын 5.2.1 болон 5.2.2 үзүүлэлтүүдийг тооцож, тайлагнах зорилгоор эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар олон улсад харьцуулахуйц статистик тоон мэдээ, мэдээллийг бий болгох чадавхийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах юм.

Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт

Судалгааны бэлтгэл хангах ажлыг 2016 оны 6 дугаар сараас эхэлсэн. Төслийг бүхэлд нь стратеги удирдлага, зохицуулалтаар хангах Удирдах Хорооны дор Зөвлөлдөх хороог байгуулав. (1) Асуулга, түүврийн дизайн; (2) сургалт, чадавхи бэхжүүлэх;

¹⁰ Project Proposal Combatting Gender-based Violence in Mongolia, 2016–2019. Prepared by UNFPA for SDC, 17 May 2016

(3) орон нутагт томилолтоор ажиллах явдлыг зохицуулах; (4) чанарын судалгааны бүрэлдэхүүн хэсэг; (5) ухуулга нөлөөлөл, үйл ажиллагаа; (6) ёс зүй, аюулгүй байдал хариуцсан зургаан дэд хороогоор дамжуулан судалгааны ажлыг зохион байгууллаа. Зөвлөлдөх хорооны удирдамжид уг хорооны гүйцэтгэх үйл ажиллагаа, үүрэг, чиглэлийг тодорхойлов. Зөвлөлдөх хороо нь дараах байгууллагын төлөөллөөс бүрдсэн. Үүнд:

- Үндэсний статистикийн хороо
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан
- Швейцарийн хөгжлийн агентлаг
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
- Хууль зүй, дотоод хэргийн яам
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Эрүүл мэндийн яам
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
- Цагдаагийн ерөнхий газар
- Хүний эрхийн үндэсний комисс
- Монголын эмэгтэйчүүдийн сан
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- “Гал голомт” Үндэсний хөдөлгөөн
- Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
- Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо
- Монголын эрэгтэйчүүдийн холбоо
- Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн
- ЛГБТ Төв

2016 оны 6 дугаар сараас 2018 оны 5 сар хүртэлх хугацаанд судалгааны ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх бүх үе шат, үйл явцыг чиглүүлэхэд Зөвлөлдөх хороо идэвхитэй оролцлоо.

Зураг 2.1. Монгол дахь жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт



2.2 ТООН СУДАЛГАА

Түүврийн дизайн

Судалгааны түүврийн дизайныг Үндэсний статистикийн хорооны Шинжилгээ судалгаа, түүврийн алба боловсруулав. Судалгаанд олон шатлалт түүврийн стратегийг ашигласан бөгөөд эхлээд зорилтот түүврийн хэмжээг 7145 өрх байхаар тооцож байв. Гэвч судалгаа нь маш эмзэг асуудлыг хөндөж байгаа учраас судалгаанд оролцогч нэгж хариулахгүй байх түвшинг хамгийн бага буюу 10.0 хувь байхаар тооцож түүврийн хэмжээг 7860 болгож нэмэгдүүлэв.

Үндэсний түвшинд бодит тооцоо хийх зорилгоор түүврийн хэмжээг тогтоосон бөгөөд ингэхдээ харьцангуй алдааны түвшинг хот, хөдөөд 10.0 хувь, аймагт 20.0 хувийн хязгаараас хэтрэхгүй байхаар тооцоолов.

Судалгааны түүвэрт 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийг хамруулж, түүврийн анхан шатны нэгж /ТАШН/ буюу кластераар нийслэлд дүүргийн хорооны хэсгүүд, аймагт засаг захиргааны хамгийн бага нэгж болох багийг сонгов. Судалгаагаар Улаанбаатар хотын 104 хэсэг, аймгийн 420 баг, нийт 524 нэгжид мэдээлэл цуглуулж, нэг нэгжээс 15 өрхийг сонгож судалгаанд хамруулав.

Түүврийн дизайныг дараах үе шаттайгаар боловсрууллаа:

Түүврийн бүлэг

Хүн амыг нийт 29 бүлэгт хуваасан бөгөөд 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэг тус бүр нэг бүлэг, нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай дүүргүүдийг нэгтгэн нэг бүлэг болгов.

1 дүгээр үе шат – ТАШН-ийн сонголт

21 аймаг тус бүрээс 20 ТАШН (нийт 420) болон Улаанбаатар хотын дүүрэг бүрээс 13 ТАШН (нийт 104) сонгогдсон. Түүврийн бүлэг бүрээс сонгох ТАШН-ийн тоог тогтооходоо пропорциональ магадлалт түүврийн аргыг ашиглав.

2 дугаар үе шат – Өрхийн сонголт

ТАШН-ийг сонгосны дараа ТАШН тус бүр дэх өрхийн жагсаалтыг гаргаж, системчилсэн түүврийн аргыг ашиглан ТАШН тус бүрээс 15 өрхийг сонголоо.

3 дугаар үе шат – Өрх тус бүрээс зөвхөн нэг эмэгтэй ярилцлага өгөхөөрсонгогдов

Судалгаанд 15–64 настай, тухайн өрхөд амьдардаг (тухайн өрхөд 4 долоон хоногоос дээш хугацаагаар амьдарсан) эсвэл 7 хоногийн 5 шөнийг тухайн өрхөд өнгөрүүлсэн эмэгтэйчүүдийг хамруулна. Өрхөд судалгааны шалгуурыг хангасан 1–ээс олон эмэгтэй байгаа тохиолдолд Кишийн хүснэгтийн аргыг ашиглан судалгаанд хамрагдах эмэгтэйг сонгож авсан.

Судалгааны асуулга

Судалгааны асуулга, нөхөх заавар болон бусад удирдамж (Багийн ахлагчийн удирдамж, заавар, ярилцлага авагчийн заавар, сургагч багшийн заавар)-ийг ДЭМБ-ын стандарт, аргачлалд нийцүүлэн боловсруулав¹¹. Судалгааны асуулга, зааврыг орчуулж, өөрчилж, батлуулах ажлыг судалгааны Зөвлөлдөх хорооны гишүүд, Олон улсын зөвлөх болон ҮСХ-ны судалгааны багийн хамт олон хийж гүйцэтгэсэн.

Асуулгыг эцэслэхийн өмнө асуулга, зааврын боловсруулалт, программ хангамжийн ажиллагааг 2017 оны 2 дугаар сард Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн нийт 36 өрхөд, 2017 оны 3 дугаар сард Дундговь аймгийн Гурвансайхан, Сайнцагаан сум, Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын нийт 60 өрхөд туршилтын судалгаа хийж шалгав.

Туршилтын судалгааны дүнд үндэслэн асуулт нэмж, асуулгын найруулга, асуултуудын хоорондын уялдааг сайжруулж, судалгааны үйл ажиллагааг дахин төлөвлөв. Өөрчилж, боловсронгуй болгосон асуулгыг холбогдох яамд, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд, судалгааны зөвлөлдөх хорооны гишүүдэд түгээж, тэдний саналыг авч тусган, асуулгыг эцэслэв. Туршилтын судалгаа, холбогдох байгууллагуудын санал зөвлөмжид үндэслэн асуулга авахад зарцуулах дундаж хугацаа, ярилцлага авагчийн өдрийн ачааллыг тодорхойлов.

Судалгааны асуулга (Хавсралт 2) нь дараах 5 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

¹¹ Судалгааны асуулгын 12 дахь хувилбарыг (2015.06.20) ашигласан.

1. Ерөнхий асуулга
2. Өрхийн сонголтын маягт
3. Өрхийн асуулга
4. Эмэгтэйчүүдийн зөвшөөрлийн хуудас
5. Эмэгтэйчүүдийн асуулга

Хэсэг 1. Хариулагчийн амьдарч буй орчин /Лавлах хуудас/

Хэсэг 2. Эрүүл мэнд

Хэсэг 3. Нөхөн үржихүйн эрүүл мэнд

Хэсэг 4. Хүүхэд

Хэсэг 5. Одоогийн эсвэл хамгийн сүүлийн нөхөр/хамтран амьдрагч

Хэсэг 6. Хандлага

Хэсэг 7. Хариулагч ба түүний нөхөр/хамтран амьдрагч

Хэсэг 8. Бэртэл, гэмтэл

Хэсэг 9. Үр дагавар ба даван туулах чадвар

Хэсэг 10. Бусад тохиолдол

Хэсэг 11. Санхүүгийн хараат бус байдал

Хэсэг 12. Ярилцлагыг дуусгах

Хавсралт 2–т ДЭМБ–ын стандарт асуумжийн 12 дахь хувилбарт оруулсан өөрчлөлтүүдийг тусгасан хувилбарыг оруулав.

Хүчирхийллийн хэлбэрүүд, тэдгээрийн тодорхойлолт

Ярилцлагад “хүчирхийлэл” гэсэн үгийг ашиглаагүй бөгөөд доор дурдсан үйлдлүүдээс дор хаяж нэгд нь өртсөн бол хариулагчийг тухайн төрлийн хүчирхийлэлд өртсөн гэж тооцлоо.

Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэл

- а) Алгадах, эсвэл өөрийг нь гэмтээж болохуйц зүйл шидэх
- б) Түлхэх, үснээс зулгаах
- в) Гараараа эсвэл гэмтээж болохуйц зүйлээр цохих
- г) Өшиглөх, чирэх, зодох
- д) Хоолой боох, юмаар түлэх
- е) Өөрийнх нь эсрэг хутга, мэс эсвэл бусад зэвсэг хэрэглэсэн эсвэл хэрэглэхээр заналхийлэх
- ё) Машин эсвэл мотоциклоор хөөх
- ж) Мориор хөөж, ташуур, уургаар ороолгох
- з) Сур, суран бүсээр ороолгох

Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэл

- а) Хүсээгүй байхад хүчээр бэлгийн харилцаанд оруулах
- б) Хамтрагч бэлгийн харилцаанд орохдоо хийх зүйлээс эмээсэн үед нь хүчээр харилцаанд орох
- в) Бэлгийн харилцаанд орж байх үедээ эмэгтэйн хувьд гутамшигтай, зүй бус үйлдэл хийхийг шаардах

Хамтрагчийн хянах, хориглох үйлдэл

- а) Найзуудтайгаа уулзахыг хориглох
- б) Төрсөн ар гэрийнхэнтэйгээ харилцах, холбогдох боломжийг хаах
- в) Хаана байгааг нь байнга асуух, мэдэх гэж оролдох
- г) Өөр эрэгтэй хүнтэй ярилцахад уурлах
- д) Өөрт нь итгэхгүй, байнга сэжиглэх
- е) Эмнэлгийн тусламж авахаасаа өмнө өөрөөс нь зөвшөөрөл авахыг шаардах

Жирэмсэн үед өртсөн бие махбодын хүчирхийлэл

- а) Жирэмсэн үед нь түлхэх, алгадах, цохих, өшиглөх, зодох
- б) Жирэмсэн үед нь хэвлий рүү цохих, өшиглөх

15–аас дээш насныханд (хамтрагч бус) бусдын үйлдсэн бие махбодын хүчирхийлэл

Бусдын 15–аас дээш насны эмэгтэйн биед ямар нэг байдлаар халдсан, зодсон

Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэл

- а) Хэл амаар доромжлох
 б) Бусдын дэргэд дорд үзэх, гутаан доромжлох
 в) Хамтрагч нь эвгүй харах, орилох, юм цохиж хагалах гэх мэт үйлдлээр айлган сүрдүүлэх
 г) Хамтрагч нь тухайн эмэгтэйг эсвэл түүний асарч халамжилдаг хүнийг хохирооно гэж сүрдүүлэх

15-аас дээш насныханд (хамтрагч бус) Бусдын үйлдсэн бэлгийн хүчирхийлэл

хамтрагч бус этгээд 15-аас дээш насны эмэгтэйг хүсээгүй байхад нь хүчээр ямар нэгэн бэлгийн үйлдэл хийлгүүлсэн

Хүүхдэд (15 хүртэлх насныханд) үйлдсэн бэлгийн хүчирхийлэл

Хэн нэгэн этгээд 15 хүртэлх насны хүүхдэд ямар нэгэн бэлгийн чанартайгаар халдах эсвэл хүсээгүй байхад нь ямар нэг бэлгийн үйлдэл хийлгүүлсэн байх.

Судалгаанд ашигласан хугацаа

Хамтрагчийн хүчирхийллийн бүх үйлдлийг судалгаанд оролцогчоос тодруулахдаа тухайн үйлдэлд амьдралдаа өртөж байсан эсэх, эсвэл сүүлийн 12 сарын хугацаанд өртсөн эсэх, ямар давтамжтай өртсөнийг (нэг удаа, 2–5 удаа, 5–аас дээш удаа гэх зэргээр) асуув. Энэ хугацаануудыг “амьдралынхаа туршид” болон “сүүлийн 1 жилийн хугацаанд” хүчирхийлэлд өртсөн байдал гэсэн хоёр мэдээллийг тооцоход ашиглав.

Дээрх хоёр хугацаагаар ангилах нь асуудлын олон талыг илрүүлэхэд ач холбогдолтой. “Амьдралдаа” хүчирхийлэлд өртсөн байдал нь тухайн эмэгтэй амьдралынхаа туршид дор хаяж нэг удаа хүчирхийлэлд өртсөн эсэхийг илэрхийлдэг бөгөөд нас ахих тусам тохиолдол нэмэгдэж, хуримтлагдах магадлалтай. Үүгээр хэдэн эмэгтэй амьдралдаа хүчирхийлэлд өртсөнийг илрүүлнэ. Энэ үзүүлэлт нь олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, ухуулга нөлөөлөлд чухал ач холбогдолтой.

Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд гарсан хүчирхийллийн тархалтаар өнгөрсөн 12 сард гарсан хүчирхийллийн хэлбэр (“одоогийн хүчирхийлэл”)–ийг илрүүлнэ. Ойрын хугацаанд гарсан хүчирхийллийн тохиолдлыг авч үздэг учраас энэ үзүүлэлт нь амьдралдаа хүчирхийлэлд өртсөн тохиолдлоос бага байдаг. Өнгөрсөн 12 сард хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тархалтыг олж тогтоох нь өнөөгийн нөхцөл байдлыг ойлгоход чухал төдийгүй арга хэмжээний хөтөлбөр (тухайлбал, өнөөгийн нөхцөлд хэдэн эмэгтэйд үйлчилгээ үзүүлэх шаардлагатай зэрэг)–ийг боловсруулахад чухал ач холбогдолтой. Мөн энэ үзүүлэлтээр хөтөлбөрүүдийн үр дүнг тодорхойлж, өөрчлөлтийг хянадаг.

Хамтрагчийн тодорхойлолт

Энэ судалгаанд “одоо хамтрагчтай байгаа/ урьд нь хамтрагчтай байсан эмэгтэйчүүд” гэдэгт эрэгтэй хүнтэй гэрлэсэн эсвэл гэрлээгүй ч хамтран амьдардаг, хамтран амьдарч байсан буюу салсан, тусгаарласан, бэлэвсэн эмэгтэйчүүдийг хамааруулна. Энэхүү судалгааны тайланд дурдагдах “хамтрагч” гэсэн нэр томъёо нь дотно харилцаатай эрэгтэй хамтрагч буюу нөхөр, салсан нөхрийг багтаана. Хавсралт 3 нь судалгаанд ашигласан ойлголт, тодорхойлолтуудыг багтаасан болно.

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, СУРГАЛТ

Олон улсын зөвлөмжийн дагуу мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийг сонгож, мэдээлэл цуглуулагчаар ажиллуулсан. Мэдээлэл цуглуулагчийг сонгохдоо дараах шалгуурыг тавьсан. Тухайлбал, 28-аас дээш насны, архаг хууч өвчингүй, харилцааны чадвар сайтай, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, хүний эрхийн асуудлаар ажиллах сонирхолтой, судалгааны мэдээлэл цуглуулж байсан туршлагатай, дээд боловсролтой, компьютерийн хэрэглээний программын мэдлэгтэй, 3 хүртэлх сарын хугацаанд хөдөө орон нутагт ажиллах боломжтой эмэгтэйчүүдийг сонгов. Мэдээлэл цуглуулагчаар ажиллахаар нийт 150 эмэгтэй бүртгүүлснээс ерөнхий шаардлагад нийцэж, компьютерын хэрэглээний шалгалтад тэнцсэн 120 эмэгтэйг сургалтад хамруулав.

Сургалтыг ҮСХ–ны ажлын хэсэг, олон улсын зөвлөхүүдтэй хамтран Улаанбаатар хотод 2017 оны 4 дүгээр сарын 6–наас 5 дугаар сарын 1–ний хооронд 3 долоо хоногийн хугацаанд зохион байгуулсан. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу багийн ахлагч, мэдээлэл цуглуулагч нарт зориулсан сургалтын хөтөлбөрт жендэр, жендэрт суурилсан

хүчирхийлэлтэй холбоотой ойлголт, тодорхойлолт, судалгааны асуулгын хэсгүүд, таблет ажиллуулах арга, программын ашиглалт, ярилцлага хийх арга зүй, мэдээлэл цуглуулагч нарын болон судалгаанд хамрагдагчдын ёс зүй, аюулгүй байдлын талаарх сэдвүүдийг тусгасан.


Сургалтын явцад цаасан асуулгыг туршиж дадлагажих, программыг туршиж, таблет дээр дадлагажих зорилгоор 2 удаа нийт 200 өрхөд туршилтын судалгаа хийв.

Сургалтын төгсгөлд бүх оролцогчдоос шалгалт авч, амжилттай дүн үзүүлсэн нийт 93 эмэгтэйг сонгож, мэдээлэл цуглуулагчаар ажиллуулав. Шалгалтад өндөр оноо авсан болон сургалтын явцад идэвхтэй, манлайлан оролцож байсан оролцогчдоос багийн ахлагч нарыг сонгож, багийн ахлагч нарт тусгайлан нэмэлт сургалт хийж, судалгааг хэрхэн зохион байгуулж явуулах талаар арга зүйн зөвлөгөө, заавар өгч, тусгай гарын авлагаар хангасан.

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг тус бүр таван гишүүн, нэг ахлагч, хоёр жолоочоос бүрдсэн нийт 15 баг хийсэн ба 21 аймаг, 9 дүүргийн статистикийн хэлтсийн ажилтан, баг, хороодын засаг дарга, хэсгийн ахлагч, хөдөө, орон нутгийн удирдлага, сумдын засаг даргын тамгын газрын ажилтнууд, хөтөч зэрэг олон хүний бүрэлдэхүүнтэйгээр 60 хоногийн турш тасралтгүй зохион байгуулсан. Зураг 2.2-т мэдээлэл цуглуулалтын багийн хуваарь болон чиглэлийг харуулав.

Зураг 2.2. Судалгааны мэдээлэл цуглуулах багийн хуваарь, чиглэл



Мэдээлэл цуглуулалтад зөөврийн компьютер /таблет pc/ ашигласан бөгөөд энэ нь мэдээллийг оруулах үеэс эхлэн мэдээллийг баталгаажуулж, мэдээллийн чанарыг сайжруулав. Мэдээлэл цуглуулах явцдаа мэдээллийг тасралтгүй шууд дамжуулж байсан нь мэдээллийн чанарыг тогтмол хянах боломж олгож, мэдээллийг гараар шивж оруулахаас зайлсхийснээр мэдээлэл боловсруулах цагийг хэмнэв.

ЁС ЗҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Мэдээлэл цуглуулагч болон судалгаанд хариулагч эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах нь чухал бөгөөд судалгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгаанд зориулж ДЭМБ-аас гаргасан ёс зүй, аюулгүй ажиллагааны зөвлөмжүүдийг¹² дагаж мөрдлөө. Тухайлбал:

Бусдын анхааралд өртөхгүй нэр: Судалгааны сэдвийг нийтэд болон өрхийн гишүүдэд мэдэгдэхээс зайлсхийж “Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлага” гэсэн бусдын анхааралд өртхөөргүй нэрийг ашиглав. Сонгогдсон эмэгтэйгээс нууцлал өндөртэйгээр зөвхөн ганцаарчилсан байдлаар ярилцлага авсан. Сургалтын үеэр мэдээлэл цуглуулагчдад хүнд нөхцөл байдлыг даван туулах чадвар, тухайлбал нөхөр эсвэл өөр хэн нэгэн орж ирж ярилцлагыг тасалдуулах үед хэрхэх талаар заасан.

Судалгаанд хариулагчийн зөвшөөрөл: Судалгаанд хариулах эмэгтэйг сонгож судалгааны зорилгыг тайлбарласны дараа судалгааг үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хариулагчийн гарын үсгээр баталгаажуулж, мэдээллээ цуглуулсан. Мөн хариулагч судалгааг үргэлжлүүлэхээс татгалзах бүрэн эрхтэйг тайлбарлаж байв.

Нууцлалыг хангах гэрээ: Ярилцлага авч, мэдээлэл цуглуулах бүх хүн сургалтын үед мэдээллийн нууцлалыг хангах гэрээнд гарын үсэг зурав.

Ярилцлага авч, мэдээлэл цуглуулагчдад туслах: Өрхөд зочилж байх үед ярилцлага авагч нарт хүчирхийлэл, түрэмгийлэл үзүүлэх зэрэг аюултай нөхцөл байдал үүсэхээс сэргийлэн тухайн өрхийн харьяалагдах засаг захиргааны байгууллага, ажилтнууд хянаж байлаа. Ярилцлага авагч нар өдөр бүр хүчирхийллийн тухай сонсч, уг судалгаа нь тэдний сэтгэл зүйд хүндээр нөлөөлдөг онцлогтойг харгалзан үзэж, ахлагч нарыг ярилцлага авагчдын сэтгэл санааны байдлыг хянаж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэхэд сургав.

Судалгаанд хариулагчдад туслах: Ярилцлагын үеэр тусламж хүссэн эмэгтэйчүүдийг зохих тусламж үйлчилгээнд холбон зуучлах, шаардлагатай арга хэмжээ авах журмыг дагаж ажиллаа. Мөн тусламж, үйлчилгээ (цагдаа, эмнэлэг, дэмжих үйлчилгээ гэх мэт)-ний газруудтай холбоо барих утасны дугаар бүхий картыг ярилцлагын эцэст ярилцлагад оролцож, хариулсан бүх эмэгтэйд өгсөн.

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны анхдагч мэдээллийг шалгах ажлыг 2017 оны 7 дугаар сараас эхлэн хийж, нэгж тус бүрээр шалгаж, хүлээн авах, нэгтгэх, нэгтгэсэн анхдагч мэдээлэлд логикийн болон шивэлтийн алдааг шалгах, түүврийн жинг тооцох ажлуудыг хийв. Тоон мэдээ, мэдээллийг таблет ашиглан компьютерт шивж оруулахад CSPro программыг ашигласан ба нэгтгэсэн тоон мэдээ, мэдээлэлд анализ, шинжилгээ хийхэд SPSS, STATA программыг ашиглав.

Судалгааны анхдагч мэдээллийг нэгтгэж, үндсэн үзүүлэлт болон хүснэгтүүдийг боловсруулж, үндсэн үр дүнг НҮБ-ын Хүн амын сангийн олон улсын зөвлөхөөр хянуулж, 2017 оны 8–10 сард урьдчилсан тооцоог үндэсний түвшинд хийж, оролцогч талуудад танилцуулж, хэлэлцүүлэн, баталгаажуулав.

¹² WHO. Putting women first: Ethical and safety recommendations for research on domestic violence against women. Geneva, World Health Organization (WHO/FCH/GWH/01.1), 2001. http://whqlibdoc.who.int/hq/2001/WHO_FCH_GWH_01.1.pdf

2.3 ЧАНАРЫН СУДАЛГАА

Чанарын судалгааны хүрээнд тоон судалгаанаас гарах боломжгүй байсан нэмэлт мэдээллийг цуглуулахын тулд 392 иргэнтэй 64 зорилтот бүлгийн ярилцлага (ЗБЯ), 87 гүнзгийрүүлсэн ярилцлага, 59 мэргэжилтнүүдийн ярилцлагыг зохион байгуулав.

Зохион байгуулалт, түүвэрлэлт

Чанарын судалгаагаар эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ЛГБТ буюу бэлгийн цөөнх иргэд, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, тэдэнд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын ажилтнуудтай ярилцлага хийв. Тоон судалгааны урьдчилсан үр дүнд үндэслэн чанарын судалгаанд хамрагдах аймаг, дүүргийг түүвэрлэн сонгов.¹³

Хамтрагчийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдтэй гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн бөгөөд ярилцлагад хамрагдсан эмэгтэйчүүдийг шүүлтүүр асуулгаар сонгов. Ингэхдээ хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, аймгийн статистикийн хэлтсийн ажилтнуудтай хамтран ажиллав. Эдгээр өгүүлэл, мэдээлэл нь тоон судалгааны үр дүнг дэмжих, асуудлыг бүрэн үнэлж, танилцуулахад ашиглагдахаас гадна дараагийн судалгааны асуулга, арга зүйг сайжруулахад чухал ач холбогдолтой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, ЛГБТ бүлгийн 7 хүн, хүчирхийлэгч 6 эрэгтэй, хүчирхийлэлд өртсөн 3 эрэгтэйтэй тус тус гүнзгийрүүлсэн ярилцлага хийв.

¹³ Хэнтий аймгийн Хэрлэн, Бор-Өндөр; Дархан-Уул аймгийн Дархан; Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ; Завхан аймгийн Улиастай, Тосонцэнгэл сум тус тус сонгогдсон. Мөн Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг /Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан/-ийг хамруулсан.



БҮЛЭГ 3.

СУДАЛГААНД ХАМРАГДАЛТ, ХАРИУЛТЫН ТҮВШИН

СУДАЛГААНЫ ХАМРАЛТ

Судалгааны түүврийн хэмжээ, хамрагдсан өрхийн тоо

- Судалгааны түүврийн хэмжээ – 7860
- Судалгааны асуулгад хариулсан өрх – 7810

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд

- Судалгаанд хамрагдах боломжтой эмэгтэйчүүдтэй өрх – 7467
- Судалгаанд хамрагдаж бүрэн хариулт өгсөн эмэгтэй – 7319

Судалгаанд хамрагдаж, бүрэн хариулт өгсөн эмэгтэйчүүд

- Эмэгтэйчүүдийн 49.5 хувь нь хот суурин газар амьдардаг
- Урьд нь хамтрагчтай байсан/одоо хамтрагчтай эмэгтэйчүүд – 6914

Урьд нь хамтрагчтай байсан/одоо хамтрагчтай эмэгтэйчүүдийн гэрлэлтийн байдал

- Гэрлэсэн – 70.5 хувь
- Хамтран амьдрагчтай – 2.5 хувь
- Бэлэвсэн – 2.1 хувь


Нийт эмэгтэйчүүдийн боловсролын түвшин

- Дээд боловсролтой – 26.8 хувь
- Бүрэн дунд боловсролтой – 27.4 хувь
- Бага болон боловсролгүй – 11.8 хувь

Гүнзгийрүүлсэн ярилцлагыг зохион байгуулахдаа ярилцлагын дараа оролцогчийг сэтгэл зүйн зөвлөгөөнд зуучлах, нууцлалыг хадгалах, ярилцлагыг өөдрөгөөр дуусгаж, эмэгтэйчүүдийн тэвчээр, зоригийг магтах, тайлан бичсэний дараа бичлэгийг устгах зэрэг ёс зүй, аюулгүй байдлын зарчмуудыг баримталж ажиллах нь нэн чухал байв.

Насны бүлэг болон нийгмийн ялгаатай бүлгийн хүмүүсийн гэр бүлийн хүчирхийллийн талаарх бодол, хандлагыг олж мэдэх зорилгоор зорилтот бүлгийн ярилцлагуудыг зохион байгуулав. Бүлэг тус бүр судалгаанд сайн дураараа хамрагдсан ижил хүйсийн 4–10 хүнээс бүрдэж байв. Нээлттэй ярилцлагад 2 судлаач удирдан чиглүүлэгч, ажиглагчийн үүрэг гүйцэтгэсэн. Судалгаанд нийгмийн бүлгийн бүхий л төлөөллийг оролцуулахын тулд 4 оролцогчтой ЗБЯ болон 8 оролцогчтой ЗБЯ гэсэн төрлүүдийг сонголоо. Зорилтот бүлэг тус бүрийн хэлбэрийг оролцогчдоор нь ангилж Зураг 2.3–т үзүүлэв.

Зураг 2.3. Зорилтот бүлгийн ярилцлагын оролцогчид



Орон нутгийн удирдлага, эмч, цагдаагийн хэлтсийн гэр бүлийн хүчирхийлэл хариуцсан мэргэжилтэн, хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг байгууллагын мэргэжилтнүүдтэй ярилцлага зохион байгуулав. Энэ ярилцлагуудаар орон нутагт гардаг хүчирхийллийн хэлбэр, төрөл, түүний шалтгаан, хүчирхийлэлд өртөгчдөд үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийг цуглуулав.

Мэдээлэл цуглуулалт, дүн шинжилгээ

Чанарын судалгааны мэдээлэл цуглуулах багийг бүрдүүлэхдээ тоон судалгаанд мэдээлэл цуглуулагчаар ажилласан сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудаас сонгон шалгаруулсан. Тэдний ярилцлага хийх ур чадварыг хөгжүүлж, шалгах зорилгоор 2017 оны 8 дугаар сарын 7–14–ний өдрүүдэд 4 хоног сургалт зохион байгууллаа. Энэ үйл явцын эцэст ур чадвар, гүйцэтгэлийг нь харгалзан 28 судлаачаас 16 судлаачийг сонгон авсан. Судлаачид 2017 оны 8 дугаар сарын 20 хүртэлх хугацаанд туршилтын судалгааны мэдээлэл цуглуулалт, 10 дугаар сарын 4–ний өдрөөс эхлэн чанарын судалгааны ярилцлага, зорилтот бүлгийн ярилцлагуудыг хийж эхэллээ. Мэдээлэл цуглуулалтыг 4 багийн бүрэлдэхүүнтэй явуулсан ба баг тус бүрт нэг сэтгэл зүйч, нэг нийгмийн ажилтан бүхий 2 эмэгтэй, 2 эрэгтэй ажиллав.

Зорилтот бүлгийн ярилцлага, гүнзгийрүүлсэн ярилцлага, мэргэжилтнүүдийн ярилцлагын аудио бичлэгийг мэдээлэл цуглуулах багаас хүлээн авч, өгөгдлийн санд мэдээлэл оруулах багийн 8 операторт хуваарилж өгсөн. Ярилцлага/хэлэлцүүлгийн төрөл, оролцогчид, сэдэв, онцлогуудыг тодорхойлох зорилгоор коджуулж, дүн шинжилгээ хийсэн. Чанарын судалгаанаас олж авсан мэдээлэл нь тоон судалгааны мэдээллийг дэмжихэд ашигласан ба энэхүү тайланд тусгагдсан болно.

СУДАЛГААНЫ ХАРИУЛТЫН ТҮВШИН БОЛОН ТҮҮВРИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлэгт судалгааны хариултын түвшин, тоон судалгааны түүврийн зарим статистикийг танилцуулна. Мөн судалгааны түүвэр нь нийт эмэгтэй хүн амыг хэрхэн төлөөлж байгаа болон судалгаанд хамрагдагчид ярилцлагад хэр сэтгэл ханамжтай байсныг тайлбарлана. Энэ бүлэгт чанарын судалгааны түүвэртэй холбоотой мэдээллийг дурдахгүй болно.

3.1 ХАРИУЛТЫН ТҮВШИН

Энэ судалгаа нь эмэгтэйчүүдийн нарийн төвөгтэй асуудлыг хөндсөн түүвэр судалгаа боловч судалгааны агуулгын эмзэг байдлаас үл хамаарч хариултын түвшин өндөр байлаа. Судалгааны түүвэрт 7860 өрхийг сонгосон хэдий ч судалгааны мэдээлэл цуглуулах явцад нийт 7930 өрхийг хамарчээ. Энэ нь тухайн хугацаанд сонгогдсон өрх нь удаан хугацаагаар эзэнгүй байх (тухайн өрх түр болон урт хугацаагаар нүүсэн), тухайн байршил нь газарт орсон, тухайн өрхөд уй гашуу тохиолдсон байх, өрхийн бүх гишүүд гадаад хэлээр ярьдаг зэрэг шалтгааны улмаас түүвэрт сонгогдсон өрхийг хамруулахгүйгээр дахин өөр өрхийг сонгосонтой холбоотой. Зорилтот түүврийн 7860 өрхөөс 7810 нь судалгааны ярилцлагад бүрэн хамрагдаж, хариултын түвшин 99.4 хувь ($100 \times 7810 / 7860$) байж, 7467 нь судалгаанд хамрагдах боломжтой эмэгтэйчүүдтэй өрх байлаа.

Судалгааны түүвэрлэлтээр сонгосон нийт өрхөөс 15–64 насны эмэгтэйчүүдтэй 7467 (түүвэрт сонгогдсон нийт өрхийн 95.0 хувь) өрх байсан бөгөөд эдгээр эмэгтэйчүүдээс 7319 эмэгтэй судалгаанд оролцож, асуулгад бүрэн гүйцэд хариулсан байна. Эндээс тооцоход хувь хүний асуулгад хариулсан түвшин 98.0 хувь байна (Хүснэгт 3.1-ээс дэлгэрэнгүйг авч үзнэ үү).

Хүснэгт 3.1. Хувь хүний асуулгад хариулсан түвшин

	Үр дүн, шалтгаан	Давтамж	Хувь
Хувь хүний асуулгын үр дүн	Хувь хүний асуулгыг бүрэн нөхсөн	7319	93.7
	Хувь хүний асуулгад татгалзсан	23	0.3
	Судалгаанд сонгогдсон хүн эзгүй/хойшлуулсан/ ярилцлага өгөх чадваргүй	124	1.6
	Өрхөд судалгаанд хамрагдах боломжтой эмэгтэй хүн байхгүй	343	4.4
	Ярилцлагыг дундаас нь үргэлжлүүлэхээс татгалзсан	1	0
Сонгогдсон нийт өрхийн тоо		7810	100.0
Хувь хүний асуулгын хариултын түвшин	Судалгаанд сонгогдсон хүн татгалзсан/эзгүй/ бөглөгдөөгүй	148	2.0
	Хувь хүний асуулгын хариултын түвшин	7319	98.0
Түүвэрт сонгогдсон судалгаанд хамрагдах боломжтой эмэгтэйчүүдийн тоо		7467	100.0

Судалгааны мэдээлэл цуглуулж эхэлснээс хойш Улаанбаатар хотод судалгаанд оролцохоос цааргалах тохиолдлууд гарч, зарим эмэгтэй ярилцлагын цаг, товыг байнга хойшлуулах эсвэл ярилцлага өгөхөөс зайлсхийж байв. Эдгээр эмэгтэйчүүдийн араас нэхэж судалгаа авах оролдлогууд хийсэн боловч ихэнх нь бүтэлгүйтэв. Нэг эмэгтэй амьдралдаа хэзээ ч ярилцлага өгөхгүй гэж хэлж байв.

Улаанбаатар хотод нийт 46 эмэгтэй судалгаанаас татгалзсан, хойшлуулсан, эзгүй байсан, ярилцлага өгөх чадваргүй байсны ердөө найман эмэгтэй нь алслагдсан буюу Багануур, Багахангай, Налайх дүүргийн иргэд байв.

Хөдөө, орон нутагт нийт 148 эмэгтэй ярилцлага өгөөгүй бөгөөд тэдний 23 нь татгалзсан, 124 нь бусад шалтгаантай байлаа.

3.2 СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ШИНЖ БАЙДАЛ

Судалгаанд оролцож, асуулгад хариулсан эмэгтэйчүүдийн засаг захиргаа, газар зүйн байршил, насны бүлэг, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт, хамтрагчийн хамаарлыг Хүснэгт 3.2–д үзүүлэв. Хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийг дотор нь “одоо хамтрагчтай эмэгтэйчүүд”, “өмнө нь хамтрагчтай байсан эмэгтэйчүүд” гэж хоёр бүлэгт ангилав.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн бараг тал (46.9 хувь) нь Улаанбаатар хотод харьяалагдаж, 53.1 хувь нь хөдөө, орон нутгийн иргэд байна. Түүнчлэн судалгаанд оролцогч арван хүн тутмын долоо нь аймгийн төв, нийслэлд, үлдсэн гурав нь хөдөө амьдардаг.

Судалгаанд оролцогчдын 9.8 хувь нь огт хамтрагчтай байгаагүй бол үлдсэн 90.1 хувь нь (6914 эмэгтэй) одоо ямар нэгэн хамтрагчтай эсвэл өмнө нь хамтрагчтай байсан байна. Хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн 66.6 хувь нь гэрлэсэн, 2.9 хувь нь хамтран амьдрагчтай, 6.0 хувь нь өмнө нь гэрлэж байсан болон одоо бэлэвсэн, 6.0 хувь нь болздог, 2.8 хувь нь салсан/тусгаарласан байна. Судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн 66.7 хувь нь хотод, 33.3 хувь нь хөдөө амьдардаг.

Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 8.7 хувь нь бага боловсролтой эсвэл боловсролгүй, 17.0 хувь нь суурь боловсролтой, 29.7 хувь нь бүрэн дунд, 13.7 хувь нь техник мэргэжлийн, 30.8 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна.

Хүснэгт 3.2. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд, байршил, насны бүлэг, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт болон хамтрагчийн хамаарлын байдлаар

Үзүүлэлт	Эмэгтэйчүүдийн тоо					
	Нийт		Хамтрагчтай байсан/байгаа		Бусад	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Бүгд	7319	100.0	6914	100.0	3	100.0
Байршил						
Нийслэл	1401	46.9	1318	46.8	1	82.6
Аймгийн төв	2262	20.4	2103	20.0	1	11.1
Сумын төв	1653	14.2	1580	14.4	1	6.3
Хөдөө	2003	18.5	1913	18.9	0	0.0
Насны бүлэг						
15–19	411	11.1	140	4.4	1	82.6
20–24	447	12.0	392	11.3	0	0.0
25–29	920	14.7	901	15.8	0	0.0
30–34	1043	13.0	1032	14.3	0	0.0
35–39	1030	11.3	1025	12.5	0	0.0
40–44	914	10.4	902	11.5	0	0.0
45–49	800	9.0	783	9.9	2	17.4
50–54	775	8.1	769	8.9	0	0.0
55–59	599	6.3	593	6.9	0	0.0
60–64	380	4.0	377	4.4	0	0.0
Боловсрол						
Боловсролгүй	374	3.9	357	4.1	1	6.3
Бага	489	4.8	467	5.0	0	0.0
Суурь	1361	17.0	1171	13.9	0	0.0
Бүрэн дунд	2008	29.7	1890	29.0	2	93.7
Техникийн, мэргэжлийн	1122	13.7	1103	14.9	0	0.0
Дээд	1965	30.8	1926	33.0	0	0.0
Хөдөлмөр эрхлэлт						
Цалинтай ажил	4227	49.0	4169	53.4	1	11.1
Ажилгүй	1074	15.8	1010	16.2	1	6.3
Гэрийн эзэгтэй	745	13.5	745	15.0	0	0.0
Оюутан	432	13.0	161	5.9	1	82.6
Тэтгэвэрт	841	8.7	829	9.5	0	0.0
Хамтрагчийн статус						
Хамтрагчгүй	402	9.8				
Хамтрагч байсан/байгаа	6914	90.1				
Бусад	3	0.1				

3.3 ТҮҮВРИЙН ТӨЛӨӨЛӨХ ЧАДВАР


Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн нийт 15–64 насны эмэгтэйчүүдийн эх олонлогийг төлөөлөх чадварыг хоёр аргаар үнэлсэн болно.

Нэгдүгээрт түүвэрт сонгогдсон эмэгтэйчүүдийг хот/хөдөө, бус, боловсролын түвшин, нас гэсэн үндсэн шинж чанаруудыг нийт 15–64 насны эмэгтэйчүүдтэй харьцуулсан. Харьцуулалтыг хийхэд Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн (ХАӨМС) 2017 оны байдлаарх мэдээллийг ашигласан. Хүснэгт 3.3–д харуулсанаар түүвэрт сонгогдсон эмэгтэйчүүдийн тоог (жинлэсэн болон жинлээгүй) дээр дурдсан шинж чанаруудаар ангилж нийт 15–64 насны эмэгтэйчүүдийн эх олонлогийн мэдээлэлтэй харьцуулахад жинлэсэн болон жинлээгүй тоон мэдээлэл нь нийт эх олонлогоос маш бага зөрүүтэй байна.

Хоёрт, Зураг 3.1–т хариулагчдын болон болон нийт хүн ам дахь 15–64 насны эмэгтэйчүүдийн (ХАӨМС–ийн мэдээлэлд суурилсан) насны бүлгийн тархалтыг харуулав. Мөн энд өрхүүдээс судалгаанд хамрагдах боломжтой бүх эмэгтэйчүүдийн насны бүлгийн тархалтыг үзүүлснээр түүвэрлэлтийн хазайлт, тухайлбал хамрагдалтын хазайлт үүссэн эсэхийг шалгах боломжтой юм

15–64 насны эмэгтэй хүн ам (шар болон улбар шар шугам) –д 15–39 насныхан зонхилж байгаа бөгөөд насны бүлэг нэмэгдэх тусам 39–64 насныхны хувийн жин нь буурч байна. Түүврийн төлөөлөх чадвар өндөр үед судалгаанд оролцох боломжтой бүх эмэгтэйчүүдийн хувийн жингийн тархалт (ногоон шугам) нь эх олонлогийн тархалттай (улбар шар шугам) ижил байх ёстой. Сонгогдсон өрхийн судалгаанд оролцох боломжтой эмэгтэйчүүдийн дотор залуу эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байсан бөгөөд харин нас ахисан эмэгтэйчүүдийн төлөөлөл илүү байсан. Судалгаанд оролцогчдын тархалт (цэнхэр шугам) нь түүврийн зохиомжоос шалтгаалан тухайн өрх дэх судалгаанд оролцох боломжтой эмэгтэйчүүдтэй (ногоон шугам) харьцуулахад судалгаанд залуу эмэгтэйчүүд (25 хүртэлх насны) дутуу хамралттай, 30–39 насны эмэгтэйчүүд илүү хамралттай байна.

Зураг 3.1. Судалгаанд оролцогчдын насны тархалт (жигнэсэн болон жигнээгүй), түүвэрт сонгогдсон өрхөд байсан судалгаанд хамрагдах боломжтой 15–64 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь



Энэ нь судалгаанд ашигласан түүврийн зохиомж буюу аюулгүй байдлыг хангах үүднээс өрх бүрийн зөвхөн нэг эмэгтэйгээс ярилцлага авсантай холбоотой. Тодорхойлбол судалгаанд хамрагдах боломжтой буюу шалгуурт нийцсэн цөөн эмэгтэй гишүүн бүхий өрхөөс ярилцлага авахад тухайн гишүүдийн сонгогдох магадлал өндөр учраас төлөөлөх чадвар хэтрэх хандлагатай байдаг. Дунд эргэм насны эмэгтэй гишүүн бүхий өрхөд судалгаанд хамрагдах боломжтой гишүүд дунджаар харьцангуй цөөн (охин нь бага насны, ээж нь өндөр настай) учир өөрөө сонгогдох магадлал өндөр, харин өсвөр насны эмэгтэй гишүүнтэй өрхүүдийн хувьд эгч, дүү, ээж нь судалгаанд хамрагдах боломжтой насны хүмүүс байх учир сонгогдох магадлал бага байна. Энэ зэрэг шалтгаанаар өрх тус бүрт сонгогдох магадлал ялгаатай байгаа нь хариулагчдын насны бүтцэд нөлөөлөх юм. Дээрх зурагт жинлэсэн насны бүтэц нь нийт эх олонлогт илүү дөхсөн байгаагаас харвал Монгол Улсын хувьд уг нөлөө үүссэн гэж үзэж болно.

Хүснэгт 3.3. Түүвэрт багтсан судалгаанд оролцогчдын мэдээлэл (жинлэсэн, жинлээгүй) болон нийт хүн ам дахь 15–49 насны эмэгтэй хүн ам (2017 оны Хүн ам, өрхийн бүртгэлийн сан)

Үзүүлэлт	Жигнээгүй		Жигнэсэн*		Бүртгэлтэй өрх, хүн ам	
	Нийт эмэгтэйчүүд		Нийт эмэгтэйчүүд		Хүн ам	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
БҮГД	7319	100.0	7319	100.0	1066259	100.0
Байршил						
Хот	3663	50.0	4926	67.3	749263	70.3
Хөдөө	3656	50.0	2393	32.7	316996	29.7
Бүс						
Улаанбаатар	1401	19.1	3429	46.9	501369	47.0
Зүүн	867	11.8	484	6.6	70429	6.6
Төв	2015	27.5	1140	15.6	166400	15.6
Хангай	1703	23.3	1376	18.8	198344	18.6
Баруун	1333	18.2	890	12.2	129717	12.2
Насны бүлэг						
15–19	411	5.6	813	11.1	113702	10.7
20–24	447	6.1	877	12.0	120721	11.3
25–29	920	12.6	1076	14.7	154072	14.4
30–34	1043	14.3	953	13.0	142328	13.3
35–39	1030	14.1	829	11.3	122330	11.5
40–44	914	12.5	764	10.4	112132	10.5
45–49	800	10.9	661	9.0	98070	9.2
50–54	775	10.6	591	8.1	86227	8.1
55–59	599	8.2	461	6.3	71068	6.7
60–64	380	5.2	293	4.0	45609	4.3
Боловсролын түвшин						
Сургуульд сурч байгаагүй	162	2.3	109	1.5	33250	3.1
Бага	489	6.9	355	5.0	86848	8.2
Суурь	1361	19.2	1245	17.4	187164	17.6
Бүрэн дунд	2008	28.3	2174	30.5	377602	35.6
Техникийн болон мэргэжлийн	526	7.4	458	6.4	28454	2.7
Тусгай мэргэжлийн дунд	596	8.4	546	7.6	55747	5.3
Дипломын болон бакалаврын дээд	1718	24.2	1957	27.4	284360	26.8
Магистр	230	3.2	272	3.8	7713	0.7
Доктор	17	0.2	23	0.3	620	0.1
Хамтрагчийн статус						
Гэрлэсэн, хамт амьдарч байгаа	4931	67.4	4136	56.5		
Гэрлэсэн, хамт амьдардаггүй	225	3.1	256	3.5		
Гэрлээгүй, эрэгтэй хамтран амьдрагчтай	558	7.6	686	9.4		
Хамт амьдардаггүй ч найз залуутай	183	2.5	354	4.8		
Гэрлээгүй, найз залуугүй	1417	19.4	1882	25.7		
Эмэгтэй хамтран амьдрагчтай	5	0.1	5	0.1		

Тайлбар: * – Сонгогдсон өрхийн судалгаанд оролцох боломжтой эмэгтэйчүүдийг өрхийн хувьд сонгогдох магадлалын ялгаатай байдлыг засварлах зорилгоор жинлэх аргыг ашигласан. Гэрлэлтийн байдал нь Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сан дахь ангиллаас ялгаатай байсан тул 15–64 насны эмэгтэйчүүдийн гэрлэлтийн байдлын талаарх мэдээллийг хүснэгтэд оруулаагүй.

3.4 ХАМРАГДАЛТЫН ТҮВШИН

Судалгаанд сонгогдсон болон сонгогдоогүй байх түүврийн стратегиас хамааран боломжит хазайлт бий болдог. Түүнчлэн судалгаанд оролцохоос татгалзсан эмэгтэйчүүдийн хувийн жингээс үүдэн хазайлт үүснэ. Энэ нь жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаанд тодорхой ач холбогдолтой бөгөөд хүчирхийлэлтэй нөхцөлд амьдарч байгаа эмэгтэйчүүд судалгаанд оролцох сонирхолгүй байдагтай холбоотой юм. Мөн хүчирхийлэгч хамтрагчтай эмэгтэйчүүд хялбар олдохгүй байх магадлалтай бөгөөд өөрөөр хэлбэл, тухайн эмэгтэй түр хугацаагаар гэрээсээ явсан байх тохиолдол гардаг. Эдгээр шалтгааны улмаас энэ төрлийн судалгаанд эмэгтэйчүүдийн хамралтыг ихэсгэх зорилгоор хамрагдах эмэгтэйчүүдийн шалгуурыг өргөтгөж авч үздэг. Тодорхойлолтоор судалгаанд хамрагдах боломжтой эмэгтэйд зөвхөн тухайн өрхийн гишүүнээс гадна судалгааны мэдээлэл цуглуулахаас өмнө хамгийн багадаа 4 долоо хоногийн хугацаанд тухайн өрхөд зочилж байгаа эмэгтэйчүүд, өрхөд хамгийн багадаа 7 хоногийн 5 өдөрт нь хонодог гэрийн ажилчдыг хамруулдаг. Цаашилбал, хэрэв сонгогдсон эмэгтэй гэртээ байхгүй тохиолдолд ярилцлага авагчид хэд хэдэн удаа тухайн өрхөд очих замаар судалгаанд хамрагдалтын түвшинг хамгийн их байлгах стратеги ашигласан байна. Хувь хүний буюу эмэгтэйчүүдийн асуулгын хариултын түвшин үндэсний хэмжээнд өндөр байгаа бөгөөд хамрагдалтын хазайлтын нөлөөг доогуур түвшинд байсан гэж үзэж болохоор байна.

3.5 СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Ярилцлага авагч болон хариулагчийн аль алинд нь ярилцлагын үйл явц амаргүй байсан бөгөөд тоон мэдээллийн баримтуудаас харахад ярилцлага нь хүчирхийллийг илчлээгүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад хүчирхийллийг илчилсэн эмэгтэйчүүдэд илүү тав тухтай, таатай байжээ. Тухайлбал, ярилцлага дунджаар 30–90 минут үргэлжилсэн бөгөөд судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс “Та энэ ярилцлагыг хэр удаан үргэлжилсэн гэж бодож байна вэ?” гэж асуухад ихэнх нь 30–40 минут үргэлжилсэн байх гэж хариулжээ.

Эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртсөнөө ярих дургүй гэж ихэнх хүмүүс боддог. Иймд ярилцлага авагч нар ярилцлагын төгсгөлд бүх эмэгтэйчүүдээс “Эдгээр зүйлийн талаар ярихад танд ямар мэдрэмж төрсөн бэ?” гэж асуун, Сайн/маш сайн, Муу/маш муу, Ижил/ялгаагүй гэсэн хариултуудаас сонгуулж, тодорхой хариултуудыг тэмдэглэж авч байв. Энэ асуултын хариулт маш чухал юм. Судалгаанд хариулсан нийт эмэгтэйчүүдийн 73.3 хувь нь ярилцлагыг “Сайн/маш сайн мэдрэмж төрсөн” гэсэн бол 23.0 хувь нь судалгаанаас өмнөх үетэй “Ижил/ялгаагүй, сэтгэл санааны хувьд өөрчлөлтгүй” гэж, 3.7 хувь нь “Муу/маш муу” гэсэн хариултыг сонгосон байна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь өөрсдийнх нь хүндрэл бэрхшээлийг хэн нэгэн сонсож, тэдний өгсөн хариулт судалгаанд хувь нэмэр оруулсанд баяртай байлаа.

БҮЛЭГ 4.

ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭЖ БУЙ ХҮЧИРХИЙЛЭЛ

Хамтрагчийн зүгээс хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийллийн хэлбэрээр, дүнд эзлэх хувиар

■ Амьдралдаа

■ Сүүлийн 12 сар



Энэ бүлэгт нөхөр эсвэл эрэгтэй хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн төрөл бүрийн хүчирхийллийн тархалтын талаарх тоон мэдээ, мэдээг танилцуулна. Тухайлбал, бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийлэл болон хянах зан үйлийн талаарх мэдээллийг энд танилцуулна.


Судалгаагаар 15–64 настай эмэгтэйчүүдийг эрэгтэй хүнтэй ойр дотно харилцаатай байсан эсэх, хэрэв хамтрагчтай байсан бол хамтрагчийн ямар нэг хүчирхийллийн үйлдэлд өртөж байсан эсэхийг сайтар бодож боловсруулсан багц асуулт асууж тодрууллаа (Хүчирхийллийн хэлбэр тус бүрийн тодорхойлолт, дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 3-аас үзнэ үү). Эдгээр асуултуудыг гагцхүү эрэгтэй хамтрагчтай байсан/одоо хамтрагчтай байгаа 6914 эмэгтэйгээс асуув.

ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ЭМЭГТЭЙЧҮҮД

Зураг 4.1–д харуулснаар хамтрагчтай байсан/байгаа нийт эмэгтэйчүүдийн 29.7 хувь нь амьдралдаа хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн бол 11.9 хувь нь сүүлийн 12 сард хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна. Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь үүнээс бага буюу эмэгтэйчүүдийн 8.0 хувь нь амьдралдаа хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол 3.0 хувь нь сүүлийн 12 сард өртжээ. Эмэгтэйчүүд хүчирхийллийн аль нэг хэлбэрт эсвэл хүчирхийллийн олон хэлбэрт давхар өртдөг байна. Тухайлбал, бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн ихэнх нь бие махбодын хүчирхийлэлд давхар өртдөг (эмэгтэйчүүдийн 31.2 хувь нь амьдралдаа давхар хүчирхийлэлд өртсөн бол 12.7 хувь нь сүүлийн 12 сард өртжээ) болохыг Зураг 4.1–д харуулав.

Хүчирхийллийн хэлбэрүүд дотроос хянах зан үйл хамгийн түгээмэл бөгөөд хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн 41.6 хувь нь амьдралдаа энэ хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн бол сүүлийн 12 сард бараг дөрөвний нэг (23.8 хувь) нь өртсөн байна. Хүчирхийллийн хэлбэр тус бүрийн шалтгаан, үр дагаварыг дараах хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлав.

Зураг 4.1. Хамтрагчийн үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийллийн хэлбэр, хугацаагаар, 2017 он (N=6914)




Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Хамтрагчийн үйлдсэн хүчирхийллийн тархалт аймаг, нийслэлд харилцан адилгүй байна. Зураг 4.2–т үзүүлсэнээр хамтрагчийн үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Дархан–Уул (41.0%), Өмнөговь (39.7%), Говьсүмбэр (39.1%) аймагт хамгийн өндөр байна.

Харин сүүлийн 12 сарын байдлаар харахад хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь харилцан адилгүй байгаа бөгөөд энэ үзүүлэлт Өвөрхангай (19.4%), Дундговь (15.3%), Өмнөговь (15.3%) аймагт хамгийн өндөр байна. Хүчирхийллийн хэлбэр тус бүрийн тархалтын хувийг газар зүйн байршлаар дэлгэрэнгүй тооцсон мэдээллийг Хавсралт 4–өөс үзнэ үү.

Зураг 4.2. Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймаг, нийслэл, хугацаагаар, 2017 он (N=6914)




Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

4.1 ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ

Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийллийн тархалт 29.7 хувь байгаа нь бараг гурван эмэгтэй тутмын нэг нь амьдралдаа дор хаяж нэг удаа хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн гэсэн үг юм. Хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн 12.0 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна. Хот, хөдөөгийн хувьд эдгээр үзүүлэлтүүд ойролцоо байна (Зураг 4.3).


Зураг 4.3. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь насны бүлгээр харилцан адилгүй байна. Энэ үзүүлэлт 40–44 насны эмэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр буюу энэ насны таван эмэгтэй тутмын хоёр нь (40.7 хувь) амьдралдаа хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд дор хаяж нэг удаа өртсөн байна. Харин хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд сүүлийн 12 сарын хугацаанд 30–34 насныхан хамгийн их өртсөн буюу 16.6 хувь байна. Хүүхэд төрүүлж, өсгөх 25–49 насны эмэгтэйчүүд сүүлийн 12 сард болон амьдралдаа хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд хамгийн их өртсөн байна (Зураг 4.4).

Зураг 4.4. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлэг, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Ойр дотно хамтрагчийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн тухайгаа ярихдаа 15–34 насны эмэгтэйчүүд зөөллөсөн үг болох “гар хүрэх” гэсэн үгийг хэрэглэж, нэрэлхэнгүй, ичиж, санаа нь зовонгуй өнгөөр хүчирхийллийн бодит төрхийг зөөллөн илэрхийлж байв. Харин 35–аас дээш насны эмэгтэйчүүд хүчирхийллийн нөхцөл байдал, бодит дүр

төрхийг илэн далангүй ярихад бэлэн байсан бөгөөд энэхүү хандлага ялангуяа хамтрагчаасаа салсан эмэгтэйчүүдэд түлхүү ажиглагдлаа.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Айхтар сүртэй биш ч хааяа нэг гар хүрч байсан. Эмэгтэй хүн нүд ам нь хөхөрсөн явахад наад зах нь гоо сайханд муухай. Сэтгэлийн шархтай болно. Архи уусан үед нь айж чичрээд яах вэ гэж боддог. Өөрчлөгдөх байх гэж бодож байна. Өдөр бүр архи уугаад зовоогоод байдаг биш.

20–24 настай эмэгтэйн ярианаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Би 10 гаруй жил сүг болтлоо зодуулсан. Шүүх хурлын танхимд надаас дахиж би хэзээ ч ингэхгүй гээд сөгдөж, мөргөөд гуйгаад байсан. Гэвч гарч ирээд л хаалгаа түгжиж аваад “Чи намайг ялын өмнө зогсоодог хэн бэ?” гээд зодсон. Тэгэхээр тэр хүн хэзээ ч засрахгүй. Би хэнд ч хэлдэггүй, нуудаг байсан. Мөн унтахгүй гэвэл зоддог байсан. Би амьд гарья гээд зугтааж энд ирсэн.

35–64 насны эмэгтэйн ярианаас

Бие махбодын хүчирхийллийн үйлдлүүд

Судалгаагаар бие махбодын хүчирхийллийн үйлдлүүдийг судалж үзсэн бөгөөд хамгийн түгээмэл үйлдэлд алгадах, юм шидэх орж байна. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 23.6 хувь нь амьдралдаа дор хаяж нэг удаа энэ хэлбэрийн үйлдэлд өртөж (Зураг 4.5), бараг таван эмэгтэй тутмын нэг нь амьдралдаа (18.8%) зангидсан гараар/юмаар цохисон гараар эсвэл юмаар цохиулсан бол сүүлийн 12 сард энэ үзүүлэлт 7.0 хувь байна.


Зураг 4.5. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, хүчирхийллийн үйлдэл, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн тоо.

Бие махбодын хүчирхийллийн үйлдлийг хүнд болон дунд зэрэг гэж ангилсан бөгөөд алгадах, түлхэх зэрэг үйлдлийг дунд зэрэгт оруулж, бусад үйлдлийг хүнд хэлбэрт оруулав. Бие махбодын хүчирхийллийн үйлдлийн хүнд болон дунд зэргээс үл хамааран эмэгтэйн авсан бэртэл, гэмтэл нь эдгэрэхгүй байгаа тохиолдолд хүнд хэлбэрийн үйлдэлд хамруулна. Судалгаагаар эмэгтэйчүүдийн 72.1 хувь нь амьдралдаа хамтрагчийн үйлдсэн хүнд хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн бол сүүлийн 12 сард 69.5 хувь нь өртжээ (Зураг 4.6).

Зураг 4.6. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, хүчирхийллийн зэрэг, хугацаагаар, 2017 он (N=2109)




Тайлбар: N=2109 – Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцсон эмэгтэйчүүд салсан эсвэл хамт амьдарч буй ойр дотны хамтрагчийн зүгээс нэгэн зэрэг олон төрлийн үйлдлээр бие махбодод нь халддаг тухай өгүүлсэн. Дотны хамтрагчийн зүгээс үйлдэж буй бие махбодын хүчирхийлэл нь түлхэх, алгадах, чимхэх, цохихоос эхлээд нүүрэн дээр дэвсэх, өшиглөх, шалны мод, ганжин, плитканы залгуур зэрэг гарт тааралдсан зүйл ашиглан цохих, хутга, заазуур ашиглан гэмтээх, духаараа мөргөж унагах, ор, цонх, машин мөргүүлэх, үсдэж чирэх зэрэг харгис хэрцгий 40 гаруй төрлийн үйлдэл хийдэг байна.

Бие махбодын хүчирхийллийн давтамж

Бие махбодын хүчирхийллийг хүн ганц удаа үйлдээд зогсдоггүй. Судалгаанаас үзэхэд хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь (45.5 хувь) олон удаа (5–аас дээш) хүчирхийлэлд өртжээ. Харин тал (49.6 хувь) нь сүүлийн 12 сарын хугацаанд хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд хэд хэдэн удаа өртсөн байна (Зураг 4.7).

Зураг 4.7. Бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, давтамж, хугацаагаар, 2017 он (N=2109)




Тайлбар: N=2109 – Амьдралдаа хамтрагчийн зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тоо

Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн онцлог

Ойр дотно хамтрагчийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн онцлогийг хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдтэй харьцуулах зорилгоор ярилцлага авсан эмэгтэй бүрийн нийгэм, хүн ам зүйн өргөн хүрээний мэдээллийг өрхийн асуулга ашиглан цуглуулав. Газар зүйн байршил, насны бүлгээр хийсэн харьцуулалтыг дээр танилцуулсан. Энэ хэсэгт тэдний боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт, өнөөгийн хамтрагчийн харьцааны байдлыг авч үзнэ.

Боловсролын түвшнээс үл хамааран эмэгтэйчүүд хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртөж байна. Техник, мэргэжлийн боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд амьдралдаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн хувь хамгийн их буюу 35.4 хувь байна (Зураг 4.8). Мөн сургуульд сурч байгаагүй эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртсөн хувь (31.4 хувь) дундажаас өндөр байна. Энэ үзүүлэлтийг сүүлийн 12 сарын байдлаар авч үзэхэд хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн сургуульд сурч байгаагүй эмэгтэйчүүдийн хувь харьцангуй өндөр буюу 16.0% байгаа нь дундаж үзүүлэлт болох 11.9 хувиас их байна.


Зураг 4.8. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, боловсролын түвшинээр, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Зураг 4.9–д харуулснаар бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар ангилж үзэхэд, гэрийн эзэгтэй, ажилгүй болон цалин, хөлстэй хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн дунд хамтрагчийн зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртөх нь их буюу ойролцоогоор 32.0 хувь байна. Харин тэтгэвэрт гарсан эмэгтэйчүүд (23.1%) болон оюутнууд (7.1%) бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал нь дээрх эмэгтэйчүүдтэй харьцуулахад бага байна. Энэ нь хүчирхийлэлд өртсөн байдлыг насны бүлгээр ангилсан үзүүлэлттэй ойролцоо байна.

Зураг 4.9. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Хамтрагчийн статусаар нь авч үзэхэд урьд нь гэрлэж байгаад салсан, тусгаарласан эмэгтэйчүүд (64.6% нь хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд амьдралдаа дор хаяж нэг удаа өртсөн) хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд хамгийн их өртсөн байна (Зураг 4.10). Хамтран амьдрагч байгаад салсан, тусгаарласан эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт бас өндөр (48.0 хувь) байна. Харин одоогоор хамт амьдардаггүй ч найз залуутай (12.2%), болздог найз залуутай байсан (15.3%) эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртсөн хувь хамгийн бага байна. Сүүлийн 12 сарын байдлаар харахад бэлэвсэн эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртсөн байдал хамгийн бага (1.1 хувь) байна.

Зураг 4.10. Бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн статус, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Салсан, тусгаарласан эмэгтэйчүүдийн дунд хүчирхийлэлд өртсөн хувь хэмжээ өндөр байгаа нь тэд хамтрагчийн үйлдсэн хүчирхийллийн улмаас салсан, тусгаарласан байж болзошгүйг илтгэж байна. Чанарын судалгаанд оролцсон олон эмэгтэй хамтрагчаасаа салах болсноо хүчирхийлэл, дарамт улам даамжирч, харгис хэрцгий, тэвчих аргагүй болсонтой холбон тайлбарлаж байв.

Бие махбодын хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлсөн хүчин зүйл

Судалгаагаар бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдээс хүчирхийллийн шалтгааныг асуусан бөгөөд энэ асуултын хариулт нь олон сонголтой байлаа. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бараг гурван эмэгтэй тутмын хоёр нь (62.2%) тэдний хамтрагч архи ууж, согтуу байсан нь хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлсөн гэж хариулжээ (Зураг 4.11). Түүнчлэн эмэгтэйг хардсан үедээ хүчирхийлэл үйлддэг гэж гурван эмэгтэй тутмын нэг нь (36.2%) хариулсан байна.

Зураг 4.11. Хамтрагчийн зүгээс бие махбодын хүчирхийлэл үйлдэх болсон шалтгаан, уг хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2017 он (N=2109)



Тайлбар: N=2109 – Амьдралдаа хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Эрэгтэйчүүд ихэвчлэн архидан согтуурсан үедээ эхнэр, найз охиныхоо эсрэг бие махбодын хүчирхийлэл үйлддэг байна. Ярилцлага өгсөн эмэгтэйчүүдийн ярианд “архинаас л болж байгаа юм, архи уухаараа хүнээ байдаг, архи уухаараа эхнэр, хүүхдээ алах шахдаг, архи ууж орж ирээд” гэх үгс олон удаа давтагдаж байлаа. Олон жил хүчирхийллийн орчинд амьдарч буй зарим эмэгтэйчүүд уурыг нь хүргэвэл “эрүүл үедээ ч зоддог болсон” гэж ярьж байв. Цөөн тооны залуу эмэгтэйчүүд нөхөр, найз залуу нь “оройтлоо, үгэнд ороогүй гэж санаатайгаар архи ууж ирээд” агсам тавьж, зоддог тухай өгүүлж байв.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: *Архи уухаараа зоддог өшиглөдөг, нуруу руу цохьдог. Эрүүл байсан ч сэтгэл санаагаар дарамталдаг. Би байраа өөрийнхөө нэр дээр авсан. Нөхөр өөрийнх нь нэр дээр болгоогүй гээд л дарамталдаг.*


35–64 насны эмэгтэй бүлгийн ярилцлагаас

4.2 ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийг 3 төрлийн үйлдлээр (хүсээгүй байхад хүч хэрэглэн бэлгийн харьцаанд оруулсан, айсан учраас хүсээгүй үедээ бэлгийн харьцаанд орсон, эмэгтэйн хувьд гутамшигтай, зүй бус ямар нэг бэлгийн үйлдэл хүчээр хийлгэсэн) тодорхойлсон.

Хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн 8.0 хувь нь бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа дор хаяж нэг удаа өртсөн байна. Амьдралдаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь хөдөө орон нутагтай (6.7 хувь) харьцуулахад хот суурин газар (8.7 хувь) өндөр байна. Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн 3 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртжээ (Зураг 4.12).

Зураг 4.12. Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухай мэдээллээ хуваалцсан эмэгтэйчүүд цөөхөн байсан бөгөөд тэдгээрийн дийлэнх нь 35–аас дээш насны эмэгтэйчүүд байв. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн дунд ийм төрлийн хүчирхийлэлд өртөх тохиолдол бас илрэв. Хамтрагч бэлгийн хүчирхийллийг ямагт бие махбодын хүчирхийлэлтэй хамт үйлддэг байна. Хосуудын хоорондын бэлгийн хүчирхийллийг дараах хэв шинжид хувааж болно. Үүнд:

- Согтуу үедээ хүчээр бэлгийн харилцаанд орохыг шаардах;
- Хүүхдийн дэргэд (унтаагүй байхад) бэлгийн ажил хийхийг шаардах;
- Бие махбодод халдаж хүчирхийлсний дараа бэлгийн ажил хийх;
- Тамлаж, харгис хэрцгий байдлаар бэлгийн ажил хийх (бэлгийн ажил нь бие махбодын хүчирхийллийн шинжтэй) гэх мэт


Гүнзгийрүүлсэн ярилцлага: Бие өвдөөд маш хүнд байхад бэлгийн ажил хийнэ гээд зүтгэнэ. Би өвдсөн байна, ядарсан байна гэхийг сонсохгүй, миний хань юм байгаа биз дээ гэнэ. Унтахгүй гэвэл уурлана, зодно. Залуудаа хань юм чинь хийе дээ гэж боддог байсан.

35–64 насны эмэгтэй бүлгийн ярилцлагаас

Бэлгийн хүчирхийллийн үйлдэл, давтамж

Эмэгтэйчүүдийн хувьд хамгийн их өртсөн бэлгийн хүчирхийллийн үйлдэл нь “айсандаа бэлгийн харьцаанд орж байсан” явдал бөгөөд эмэгтэйчүүдийн 6.3 хувь нь амьдралдаа дор хаяж нэг удаа, 2.2 хувь нь сүүлийн 12 сард энэ төрлийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Эмэгтэйчүүдийн 5.5 хувь нь хамтрагчийн зүгээс хүч хэрэглэсэн бэлгийн харьцаанд орж байсан бол 2.2 хувь нь сүүлийн 12 сард ийм үйлдэлд өртжээ. Түүнчлэн эмэгтэйчүүдийн 1.5 хувь нь хамтрагчийн шахалтаар эмэгтэйн хувьд гутамшигтай, зүй бус бэлгийн үйлдэл амьдралдаа дор хаяж нэг удаа хийсэн бол 0.6 хувь нь сүүлийн 12 сард хүчирхийллийн энэ төрлийн үйлдэлд өртсөн байна.


Зураг 4.13. Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, бэлгийн хүчирхийллийн хэлбэр, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд үүнийг нэг бус хэд хэдэн удаа үйлдэх хандлагатай байна. Зураг 4.14–аас харахад хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь (54.1 хувь) сүүлийн 12 сарын хугацаанд хэд хэдэн удаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн байхад 45.5 хувь нь амьдралдаа хэд хэдэн (2–5) удаа хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртжээ.

Зураг 4.14. Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, давтамж, хугацаагаар, 2017 он (N=498)




Тайлбар: N=498 – Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тоо

4.3 ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН БИЕ МАХБОДЫН БОЛОН/ЭСВЭЛ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн тархалтыг олон улсын судалгаанд хамтрагчийн үйлдсэн хүчирхийллийн стандарт харьцуулагдахуйц үзүүлэлт болгон ашигладаг. Хүчирхийлэгч бие махбодын болон бэлгийн хүчирхийллийг ихэвчлэн зэрэг үйлддэг учраас хүчирхийллийн энэ хоёр үйлдлийг хамтад нь авч үзэх боломжтой.

Монголд хамтрагчтай байсан/байгаа нийт эмэгтэйчүүдийн бараг гурван эмэгтэй тутмын нэг нь буюу 31.2 хувь нь амьдралдаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна (Зураг 4.15). Бараг 13.0 хувь нь бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд сүүлийн 12 сард өртсөн байна. Байршлаар харахад эзлэх хувь ойролцоо байгаа бөгөөд хот, хөдөө болон бүсийн хувьд төдийлөн ялгаа харагдсангүй. Сумын төв болон Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртсөн хувь аймгийн төв болон хөдөөгийн эмэгтэйчүүдээс бага зэрэг их байна. Түүнчлэн, бүс нутгаар харахад, энэ хоёр төрлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд Төвийн бүсэд хамгийн их буюу 34.8 хувь, Баруун бүсэд хамгийн бага буюу 27.2 хувь байна.

Зураг 4.15. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, бүс нутаг, хугацаагаар, 2017 он (N=6914)




Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Амьдралдаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг насны бүлгээр харахад энэ төрлийн хүчирхийлэлд 40–44 насныхан хамгийн их буюу 42.0 хувь нь өртсөн байхад 30–34, 35–39 насны бүлгийн эмэгтэйчүүдийн 36.0 орчим хувь нь өртсөн байна. Энэ үзүүлэлт 15–19 насныхны хувьд хамгийн бага буюу 9.0 хувь байна (Зураг 4.16).

40–44 насны эмэгтэйчүүд амьдралдаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд хамгийн их өртсөн хэдий ч сүүлийн 12 сарын байдлаар харахад 25–29 болон 30–34 насны эмэгтэйчүүд хамтрагчийн үйлдсэн хүчирхийлэлд хамгийн их өртсөн байна. Эндээс харахад нас ахих тусам эмэгтэйчүүд хүчирхийллийг таслан зогсоох, эсвэл хүчирхийлэл бүхий харилцааг орхих чадвартай болдог байна.

Зураг 4.16. Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлэг, хугацаагаар, 2017 он (N=6914)




Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

4.4 СЭТГЭЛ САНААНЫ ХҮЧИРХИЙЛЭЛ

Сэтгэл санааны хүчирхийлэл, зарим тохиолдолд сэтгэл зүйн гэж дурьдагдах хүчирхийллийг тодорхойлохын тулд тухайн эмэгтэйг хэл, амаар доромжилж байсан, бусдын өмнө доромжилж, эвгүй байдалд оруулж байсан, эмэгтэйг айлгахын тулд хашгирах, эд зүйлс эвдэх, үг хэлээр айлган сүрдүүлэх зэрэг үйлдлийг шалгуур болгон авч үзсэн. Судалгаанд хамрагдсан хамтрагчтай байсан / байгаа таван эмэгтэй тутмын хоёр (40.3%) нь амьдралдаа дор хаяж нэг удаа сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байна. Харин сүүлийн 12 сарын байдлаар таван эмэгтэй тутмын нэг (22.4 хувь) нь сэтгэл санааны хүчирхийлэлд өртжээ. Байршил болон бүс нутгаар харахад, хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувьд онцын ялгаа ажиглагдахгүй байгаа боловч нийслэл (42.1 хувь) болон сумын төвийн (41.9 хувь) эмэгтэйчүүдийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хувь хамгийн өндөр байна (Зураг 4.17).


Зураг 4.17. Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, бүс нутаг, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийг насны бүлгээр харахад, 30–34 (49.9%) болон 35–39 насныхан (47.4%) хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд хамгийн ихээр өртсөн байна (Зураг 4.18). Амьдралдаа болон сүүлийн 12 сарын хугацаанд хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь 15–19 болон 60–64 насны бүлэгт хамгийн бага байна.

Зураг 4.18. Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлэг, хугацаагаар, 2017 он (N=6914)




Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Сэтгэл санааны хүчирхийллийн давтамж

Сэтгэл санааны хүчирхийлэл нь нэг үйлдэгдээд зогсдоггүй, дахин давтагддаг. Судалгаанаас харахад хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн 58.8 хувь нь уг хүчирхийлэлд олон удаа (5–аас дээш) өртсөн байна.

Зураг 4.19. Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, давтамж, хугацаагаар, 2017 он (N¹=2746, N²=1473)



Тайлбар: N¹=2746 – Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн тоо, N²=1473 – Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд сүүлийн 12 сард өртсөн эмэгтэйчүүдийн тоо

Хамтрагчийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн байдал

Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь боловсролын түвшингээр бага зэрэг ялгаатай байна (Зураг 4.20). Энэ үзүүлэлт техник, мэргэжлийн боловсролтой (44.3%) болон сургуульд сурч байгаагүй эмэгтэйчүүдийн (43.6%) хувьд хамгийн өндөр байгаа бөгөөд сүүлийн 12 сарын байдлаар бүрэн дунд боловсролтой (23.2 хувь), болон дээд боловсролтой эмэгтэйчүүд (23.9 хувь) хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд хамгийн их өртжээ.


Зураг 4.20. Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, боловсролын түвшин, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харахад ажилгүй эмэгтэйчүүд (44.5 хувь), цалин, хөлстэй хөдөлмөр эрхлэгч болон гэрийн эзэгтэй эмэгтэйчүүд (42.8 хувь) хамгийн их хувийг эзэлж байна. Сүүлийн 12 сарын байдлаар ажилгүй эмэгтэйчүүд (26.5%), гэрийн эзэгтэй (24.6%) нар хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд хамгийн их өртсөн байна. Эдгээр эмэгтэйчүүд өөрийн гэсэн орлогын эх үүсвэргүй байгаа нь хамтрагчийн хүчирхийлэлд өртөхөд хүргэж байж болзошгүй.

Зураг 4.21. Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо. Оюутнуудын тоо хэтэрхий бага байгаа тул хассан (20-иос бага).

Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд гэрлэж байгаад салсан/тусгаарласан эмэгтэйчүүд хамгийн их (74.0 хувь) өртсөн байна (Зураг 4.22). Энэ үзүүлэлт мөн хамтран амьдарчтай байсан эмэгтэйчүүдийн дунд өндөр (51.5 хувь) байна. Сүүлийн 12 сараар авч үзвэл энэ үзүүлэлт гэрлээгүй хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн хувьд (32.7 хувь) хамгийн өндөр байна.

Зураг 4.22. Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн дүнд эзлэх хувь, хамтрагчийн статус, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцсон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд сэтгэл санааны хүчирхийлэл нь бие махбодын хүчирхийллийн дараа 2–рт орох хүчирхийллийн түгээмэл хэлбэр байлаа.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: “Манай нөхөр сүүлдээ би эрэмдэг хүнтэй амьдарч чадахгүй” гэж хэлдэг болсон. 2008 оноос манай нөхөр нууц амрагтай болсон. “Чи өөр хүнтэй унтсан, чи хуурч байгаа тул” гэж гүтгээд “би хэзээ ч энэ хүүхнээс болихгүй” гэдэг. Миний дэргэд “би эхнэрээсээ залхаж байна” гээд нөгөө хүүхэнтэйгээ утсаар ярина. Хүүхдүүддээ “ээж чинь шулаач учраас гэрээсээ би хол явлаа” гээд байсан.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн ярианаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Аав ээжийг маань гуйлгачин түүлгэчингээр нь дуудна. Хаа нэг ирэхээр нь ад үзнэ, дорд үзнэ, хэрүүл хийж ална, хядна гэж айлгана.

15–34 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Би 2 хүүхэдтэй нөхөртэйгээ суусан юм. Хүүг толгой руу нь зөндөө л цохиж байсан, охиныг бол гар хүрэхгүй, элдвээр л хэлнэ, хөөнө, ад үзнэ.

35–64 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Архинаас л болж агсам тавих, хэрүүл маргаан гарна. Зодож нүдэх асуудал байхгүй. Намайг хардаад шинэ жил, баяр ёслолын үйл ажиллагаанд оруулдаггүй, би ч тэгээд тоохгүй хаячихдаг, ямар нэгэн арга хэмжээнд ордоггүй, гэртээ л сууж байдаг байсан даа.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн ярианаас

Чанарын судалгаагаар тодорхойлсон сэтгэл санааны хүчирхийллийн төрлүүд:

- Дорд үзэх, өөртөө итгэх итгэлийг нь үгүй хийх (зандрах, хүйтэн хөндий хандах, үл хайхрах, хөөж туух, залхаж байгааг байн, байн хэлэх, асуудлыг ганцаараа шийдэх, муухай нэр хочоор дуудах, хэнд ч хэрэггүй гичий, шулаач, банзал гэж доромжлох)
- Үл итгэх/хардах (хүнтэй утсаар болон биечлэн яриулахгүй байх, мөшгих, хүмүүстэй уулзуулахгүй байх г.м)
- Хүүхдүүдийг дарамтлах (хүүхдүүдийг зодох, гоочлох, шүүх, гэрээсээ хөөх, шатаана, ална гэж заналхийлэх, хойд урдах хүүхдүүдийн талаар хэрүүл гаргах)

- Доромжлох, гутаах, хамаатан саданд заналхийлэх (аав, ээжийг нь гуйлгачин гэх, заналхийлэх, өсөрхөх, үзэн ядах, элдэв муу үгээр хэлэх, бүгдийг нь хядаж голомтыг чинь самарна гэж заналхийлэх)
- Заналхийлэх, (цонх хагалах, агсам тавих, “сална, үхнэ, орон гэрийг шатаана, хүүхдийг чинь уулзуулахгүй” гэж айлган сүрдүүлэх)
- Байнга дарамтлах (үглэх, өмнөх залууг нь ярих, байнга уурлах, хэрүүл өдөх, загнах, дуугай хураагаад таг болох, алга болох, шөнө унтуулахгүй байх)
- Гэрийн ажлаа хийхгүй байна гэж шүүмжлэх (анхиагүй, арчаагүйгээр нь дуудах)
- Архи байнга ууж бухимдуулах (юмаа зараад архи уух, архи уугаад алга болох)
- Араар тавих (нууц амрагаас нь дарамталсан зурвас ирэх, нууц амрагийнхаа тухай нээлттэй ил тод ярих)


Эрэгтэйчүүд мөн дээрх төрлийн сэтгэл санааны хүчирхийллээс хүүхдүүдийг заналхийлэх, араар тавихаас бусдад нь өртсөн байна.

4.5 ХЯНАХ ЗАН ҮЙЛ

Эмэгтэйчүүд хянах зан үйлд өртсөн эсэхийг тодорхойлохоор судалгаанд хэд хэдэн асуулт оруулсан бөгөөд ингэхдээ хамтрагч нь эмэгтэйчүүдийг найз нөхөд, ар гэрийнхэнтэй нь уулзуулахгүй байхыг оролдох, хаана байгааг нь байнга асууж, шалгаах, өөр эрэгтэй хүнтэй яриа өрнүүлэхэд уурлах, үнэнч биш гэж хардсан эсэхийг асуув.

Хамтрагчтай байсан / байгаа таван эмэгтэй тутмын хоёр нь (41.6 хувь) амьдралдаа нэг болон түүнээс олон төрлийн хянах үйлдэлд өртсөн байна (Зураг 4.23). Харин сүүлийн 12 сард ойролцоогоор дөрвөн эмэгтэй тутмын нэг нь (23.8 хувь) энэ төрлийн хүчирхийлэлд өртжээ. Энэ үзүүлэлт хөдөөтэй харьцуулахад хотод ялангуяа Улаанбаатарт хамгийн өндөр (47.7 хувь) байна. Амьдралдаа дор хаяж нэг удаа хянах үйлдэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь баруун бүсэд хамгийн бага буюу 31.3 хувь байсан бөгөөд сүүлийн 12 сарын байдлаар энэ үзүүлэлт Хангайн бүсэд хамгийн бага (20.3 хувь) байна.


Зураг 4.23. Хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, бүс нутаг, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Хамтрагчтай байсан / байгаа 15–19 насны эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь (54.7 хувь) хамтрагчийн хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байна (Зураг 4.24). Энэ үзүүлэлт 25–29 насны эмэгтэйчүүдийн дунд ч мөн өндөр (49.3 хувь) байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн нас ахих тутам хамтрагчийн хяналтанд өртөх явдал буурч байна. Энэ үзүүлэлтээс эрчүүд, ялангуяа залуу эрэгтэйчүүдийн хандлага, зан үйлийг өөрчлөх хэрэгтэй байгааг харж болно.

Зураг 4.24. Хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлэг, хугацаагаар, 2017 он (N=6914)




Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн байдал

Амьдралдаа хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл техник, мэргэжлийн боловсролтой эмэгтэйчүүд (45.3 хувь) дээд боловсролтой эмэгтэйчүүдээс (42.6 хувь) арай илүү хянах зан үйлд өртөж, дундаж үзүүлэлтийг давсан байна. Энэ үзүүлэлтийг сүүлийн 12 сарын байдлаар авч үзвэл дээд боловсролтой (26.6 хувь), бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүд (26.3 хувь) хянах зан үйлд хамгийн их өртсөн байна.


Зураг 4.25. Хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, боловсролын түвшин, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Ихэвчлэн ажилгүй эмэгтэйчүүд (49.1 хувь) одоо байгаа эсвэл өмнө нь байсан хамтрагчийнхаа хянах зан үйлд амьдралдаа дор хаяж нэг удаа өртсөн байна. Энэ үзүүлэлт тэтгэвэрт гарсан эмэгтэйчүүдийн дунд хамгийн бага (29.0%) байгаа ч, тэтгэвэрт гарсан дөрвөн эмэгтэй тутмын нэг нь амьдралдаа энэ төрлийн хүчирхийлэлд өртсөн байна. Харин сүүлийн 12 сард энэ үзүүлэлт оюутан эмэгтэйчүүдийн дунд хамгийн их буюу 31.5 хувь байна.

Зураг 4.26. Хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Эмэгтэйчүүдийг хамтрагчийн статусаар ангилж Зураг 4.27-д харуулсан бөгөөд хамтран амьдарч байгаад салсан, тусгаарласан мөн гэрлэж байгаад салсан, тусгаарласан эмэгтэйчүүдийн хянах зан үйлд (амьдралдаа) өртөж байсан хувь хамгийн их (73.0 хувь), мөн хамтран амьдрагчтай байж байгаад салсан эмэгтэйчүүд (72.0 хувь) байна. Гэрлэж байсан/ хамтран амьдарч байсан эсвэл бэлбэсэрсэн эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт нь хамгийн бага (26.7%) хувьтай байгаа бөгөөд бэлэвсэн эмэгтэйчүүдийн 3.1 хувь нь амьдралдаа энэхүү хүчирхийлэлд өртсөн байна.

Зураг 4.27. Хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн статус, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Хамтрагчийн хүчирхийлэлд өртсөнөө ярьсан эмэгтэйчүүд хардалтын асуудлыг ахин дахин хөндөж байлаа. Ойр дотны хамтрагчийн хүчирхийлэлд өртсөн олон эмэгтэй хардалтан дор амьдардаг тухайгаа хуучилжээ. Хардуулж, сэрдүүлэн амьдардаг гэж хариулсан эмэгтэйчүүдийн насны бүлгүүдийн хувьд ялгаа ажиглагдсангүй.

Эмэгтэйчүүдийн хэлсэнээр хардалт нь дараах нөхцөлд үүсдэг байна. Үүнд:

- Хэн нэгэн хүнтэй утсаар ярих;

- Хаа нэг газар хэн нэгнийг харах, ярилцах;
- Найз нөхөдтэйгээ уулзахаар гадагш гарах;
- Тогтсон хугацаанаас оройтож ирэх, ажлаасаа оройтож ирэх;
- Ажлын газрынхан, найз нөхөдтэйгээ баяр тэмдэглэх, зугаалах, аялах;
- Ажлын шугамаар томилолтоор явах зэрэг тохиолдолд хамтрагчийн зүгээс харддаг байна.

Өмнө нь гэр бүлтэй байсан, дагавар хүүхэдтэй эмэгтэйчүүдийг хардах явдал түлхүү ажиглагдаж байна.

Хамтрагчийн зүгээс хардаж, хянахдаа эмэгтэйчүүдийг найз нөхөд, хамт олноос нь хөндийрүүлж, гадагш харьцах (телефон утас, сошиал медиа болон бусад хэлбэрээр хүмүүстэй харилцах г.м) аргыг нь хязгаарладаг байна. Үүний улмаас эмэгтэйчүүд бие даасан байдал, эрх мэдлээ алдаж, хосуудын харьцаан дахь эрх мэдлийн тэнцвэртэй бус байдал гүнзгийрч, зарим тохиолдолд хамтрагчаас бүрэн хамааралтай болж, улмаар өөр бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртөх эрсдэл ихэсдэг байна.

Чанарын судалгаанаас үзэхэд эхнэрийн зүгээс өөр эмэгтэйтэй болсон тухай нөхөр, хамтрагчид гомдоллож, хэрэлдэх нь хүчирхийлэл гарахад хүргэдэг байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Манай нөхөр уурхай руу 3-р сард яваад 9-р сард эргэж ирдэг. Тиймээс намайг маш их харддаг. Би саяхан нэг ажилд орсон юм, орой айлуудаар явж захиалга авдаг, гэтэл “дарга чинь мэдэхгүй, эрт ир” гээд байнга шаардана, айл амьтнаар яваад 20 цагт орж ирэхэд оройтлоо гээд эрүүл байж зодсон. Би эндэхийн хүн биш болохоор ярих ч хүн олдохгүй, үнэхээр хэцүү байдаг.

15–34 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Аягүй их хардана. Хэдэн 7 хоногийн өмнө би найзтайгаа уулзаад, 2 цаг хоол идээд ирэхэд “хаачаад ирсэн, хэнтэй явсан, яасан ийсэн” гээд архи ууж байгаад л зодсон. Нөхрөөсөө айгаад, санаа зовоод би гарч орж ч чаддаггүй.

31–35 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: “Чи бисексуаль, тиймээ” гээд л эрэгтэй хүнтэй ч хардана, эмэгтэй хүнтэй ч хардана.


ЛГБТ эмэгтэйн ярианаас

4.6 ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Хамтрагчийн үйлддэг эдийн засгийн хүчирхийллийн тархалтыг энэ хэсэгт судаллаа. Эмэгтэйг ажилд орох, аливаа орлого олох үйл ажиллагаанд оролцохыг хориглох, эмэгтэйн олсон мөнгийг дур мэдэн авах, гэр бүлдээ зарцуулах мөнгө өгөхгүй атлаа өөрөө архи, тамхинд мөнгө зарцуулах зэрэг нь хамтрагчийн үйлдэж буй эдийн засгийн хүчирхийлэл юм.

Хамтрагчтай байсан/байгаа таван эмэгтэй тутмын нэг нь (19.9%) амьдралдаа эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байна. Энэ үзүүлэлт тус улсын бусад хэсэгтэй харьцуулахад Улаанбаатар хотод хамгийн өндөр (22.9 хувь) байна. Улсын дунджаар сүүлийн 12 сард эмэгтэйчүүдийн 12.0 хувь нь эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байхад энэ үзүүлэлт Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 13.2 хувь байна.

Зураг 4.28. Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, бүс нутаг, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо


Чанарын судалгаа: Зорилтот бүлгийн ярилцлагад оролцсон, ойр дотно хамтрагчийн хүчирхийлэлд өртдөг эмэгтэйчүүдийн тал орчим хувь нь эдийн засгийн дарамт, хүчирхийлэлд амьдарч байна.

Эдийн засгийн дарамт нь нөхрөөсөө эдийн засгийн хувьд хамааралтай тул мөнгө зарцуулах эрхгүй, өөртөө болон үр хүүхдэдээ мөнгө зарцуулахыг “дэмий зүйлд зарцууллаа”, “мөнгө яаж олдогийг мэдрүүлнэ” хэмээн загнуулах, занх зэргээр илэрч байна.

Бие даан орлого олдог эмэгтэйчүүд мөн эдийн засгийн хүчирхийлэлд өртдөг байна. Тухайлбал, нөхөр нь эхнэрийн олсон орлогыг хэрхэн зарцуулдагийг ярих эрхгүй байх, гэр бүлийн орлогод оруулж буй хувь нэмрийг нь үл тоох, “хүний хийдэггүй юмыг хийж байгаа юу” гэх зэргээр ажлыг нь дорд үзэх, авсан орон байраа “өөрийн нэр дээр” болголоо гэх зэргээр дарамталдаг байна.

Судалгааны үр дүнгээс харахад эдийн засгийн хүчирхийлэлд 20–44 насны эмэгтэйчүүд хамгийн ихээр өртсөн байна. Нас ахих тусам эдийн засгийн дарамтанд өртөх хувь буурч байна.

Зураг 4.29. Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлгээр, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо.

Чанарын судалгаа: Хамтрагчийн зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртдөг олон эмэгтэй эдийн засгийн хувьд хамтрагчаас хамааралтай эсвэл хүчээр эдийн засгийн хамааралтай болсон байна. Эдийн засгийн хамааралтай байдал 35-аас дээш насны эмэгтэйчүүдэд түлхүү ажиглагдлаа.

Эрэгтэй хамтрагчид эмэгтэйчүүдийг өөрөөсөө хамааралтай болгож, хяналтандаа оруулахын тулд эмэгтэйчүүдийг ажил хөдөлмөр эрхлэхийг хориглож, эдийн засгийн хувьд бие даах боломжгүй болгодог байна.

Эдийн засгийн хүчирхийлэл насны бүлгүүдээр бага зэрэг ялгаатай байна. Тухайлбал, мөнгө гуйх, мөнгө зарцуулах эрхгүй байх явдал залуу эмэгтэйчүүдэд гэхээсээ 35-аас дээш насны эмэгтэйчүүдийн ярианд түлхүү ажиглагдав. Мөн “орон байраа өөрийн нэр дээр бүртгүүлээ, мөнгөгүйдээ ичлээ” гэсэн шалтгаантай хүчирхийлэл 35-64 насныхны ярианд гарчээ. Мөн архинаас хамааралтайн улмаас өрөнд оруулах, эд зүйлээ үрэн таран хийх зэргээр эдийн засгийн дарамтад оруулдаг тухай яриаг мөн энэ насныхан өгүүлсэн болно. Харин ажил хийлгэхгүй гэсэн дарамт нь 15-34 насны эмэгтэйчүүдийн ярианд түлхүү илрэв.


***Гүнзгийрүүлсэн ярилцлага:** Манай нөхөр намайг ажил хийлгэх дургүй, ээжийнхээ дэлгүүрт л туслуулж байхыг хүсдэг. Нэг ажилд ороод оройн 8 цагт гэртээ ирэхэд оройтлоо гээд хөх няц болтол зодсон. Зодчихоод уучлал гуйхгүй байж, би уучлал гуйдаг, хохь чинь шүү гэж дарамталдаг.*

15-34 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн байдал

Амьдралдаа эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн үзүүлэлтийг харахад сургуульд сурч байгаагүй эмэгтэйчүүд эдийн засгийн хүчирхийлэлд хамгийн их (24.7 хувь) өртсөн байна. Сүүлийн 12 сард бусад эмэгтэйчүүдтэй харьцуулахад бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүд эдийн засгийн хүчирхийлэлд хамгийн их (14.5% хувь) өртжээ.


Зураг 4.30. Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн дунд эзлэх хувь, боловсролын түвшин, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Хөдөлмөр эрхлэлтийн байдлаар харахад, гэрийн эзэгтэй (23.0%) болон ажилгүй (25.2%) эмэгтэйчүүд эдийн засгийн хүчирхийлэлд хамгийн ихээр өртсөн байна (Зураг 4.31). Өөрийн гэсэн орлогын эх үүсвэргүй эмэгтэйчүүд эдийн засгийн хүчирхийлэлд өртөх магадлал их байна.

Зураг 4.31. Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Эмэгтэйчүүд амьдралдаа эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдлыг хамтрагчийн статусаар харахад, гэрлэж байгаад салсан, тусгаарласан эмэгтэйчүүд (55.1 хувь), хамтран амьдрагчаас салсан, тусгаарласан эмэгтэйчүүд (48.4 хувь) эдийн засгийн хүчирхийлэлд хамгийн их өртсөн байна. Бэлэвсэн эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт хамгийн бага буюу 12.6 хувь байна. Энэ үзүүлэлтийг сүүлийн 12 сарын байдлаар авч үзэхэд хамтран амьдарчтай байгаад салсан/тусгаарласан эмэгтэйчүүд эдийн засгийн хүчирхийлэлд хамгийн их (24.9 хувь) өртжээ.

Зураг 4.32. Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн статус, хугацаагаар, 2017 он (N=6914)




Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо.

4.7 ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН АЛЬ НЭГ ХЭЛБЭРТ ӨРТСӨН БАЙДАЛ

Энэ хэсэгт хамтрагчийн үйлдсэн хүчирхийллийн таван хэлбэр (бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн болон хянах зан үйлийн хүчирхийлэл)–ийн аль нэгд нь, эсвэл хэд хэдэн хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн байдлыг судаллаа.

Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн талаас илүү (57.9 хувь) нь хамтрагчийн үйлдсэн нэг болон түүнээс олон хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн байна. Эмэгтэйчүүдийн гуравны нэг гаруй (35.0 хувь) нь сүүлийн 12 сард хамтрагчийн үйлдсэн ямар нэг төрлийн хүчирхийлэлд өртжээ (Зураг 4.33). Хот суурин газрын эмэгтэйчүүд хамтрагчийн үйлдсэн хүчирхийлэлд ихээр өртсөн бөгөөд энэ үзүүлэлт Улаанбаатарт амьдардаг эмэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр буюу 62.1 хувь байна. Харин Баруун бүсийн эмэгтэйчүүдийн дунд хамгийн бага (47.6%) байна.

Зураг 4.33. Хамтрагчийн үйлдсэн хүчирхийллийн аливаа хэлбэрт өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, байршил, бүс нутаг, хугацаагаар, 2017 он (N=6914)




Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Хамтрагчийн хүчирхийллийн тархалт нь хүчирхийллийн хэлбэр тус бүрийг аймгаар харахад харилцан адилгүй байна. Өмнө дурдсанчлан Увс аймагт хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн 22.4 хувь нь хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн нь бусад аймаг болон нийслэл хоттой харьцуулахад хамгийн бага хувийг эзэлж байна. Харин Дархан–Уул аймгийн эмэгтэйчүүдийн 41.0 хувь нь хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн буюу хамгийн их хувийг эзэлж байна. Хянах зан үйлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Хэнтий аймагт хамгийн өндөр бөгөөд эмэгтэйчүүдийн тэн хагас нь өртсөн бол энэ үзүүлэлт Завхан аймагт хоёр дахин бага буюу эмэгтэйчүүдийн 22.8 хувь нь хянах зан үйлд өртсөн байна. Хэнтий аймагт хамтрагчийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь мөн хамгийн өндөр (49.8 хувь) бол Увс (29.5 хувь), Завхан (30.6 хувь) аймгийн хувьд энэ хэлбэрийн хүчирхийллийн тархалт хамгийн бага байна. Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь аймаг, нийслэлээр харахад хамгийн багадаа Завхан аймагт 7.3 хувь, хамгийн ихдээ Өмнөговь аймагт 25.5 хувь байна.

Эрэгтэй хүнтэй дотно харилцаатай байсан/байгаа эмэгтэйчүүдийн тэн хагасаас илүү нь (57.9 хувь) нь амьдралынхаа туршид хамтрагчийн хүчирхийллийн аль нэг (нэг болон түүнээс олон) хэлбэрт өртөж байжээ. Хэнтий аймагт хамтрагчийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр (68.6 хувь) байна. Мөн Дархан–Уул аймаг, Өмнөговь аймаг, Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн хувьд амьдралдаа аль нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртөж байсан тохиолдол их байна. Сүүлийн 12 сарын хугацаанд хамтрагчийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Хэнтий (45.4 хувь), Баян–Өлгий (40.5 хувь) аймгуудад хамгийн өндөр байна.


Зураг 4.34. Хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймаг, нийслэлээр, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Хамтрагчийн үйлдсэн хүчирхийллийн аль нэг хэлбэрт амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн үзүүлэлт 30–34 насныханы бүлэгт хамгийн өндөр буюу улсын дунджаас даруй 8 пунктээр их байна. Түүнчлэн 40–44 нас хүртэлх эмэгтэйчүүдийн хувьд сүүлийн 12 сар болон амьдралдаа хүчирхийлэлд өртсөн хувь өндөр байна. Эмэгтэйчүүд хамтрагчийн зүгээс ямар нэгэн хүчирхийлэлд өртөх явдал нь 50 наснаас эхлэн нас ахих тусам буурсан дүнтэй байна. Эмэгтэйчүүд нас ахих тусам амьдралдаа өртсөн хүчирхийлэл нь хуримтлагдаж өсөх хандлагатай байдаг. Гэтэл Монгол Улсын хувьд нас ахих тусам хүчирхийлэлд өртсөн байдал буурсан дүнтэй байгаа нь сүүлийн жилүүдэд хамтрагчийн зүгээс хүчирхийлэл үйлдэх нь ихсэж байгаа, эсвэл ахмад настай эмэгтэйчүүд олон жилийн өмнөх үйл явдлыг санахгүй, мэдээлэхгүй байж болзошгүйг илтгэж байна.

Зураг 4.35. Хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлэг, хугацаагаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо


4.8 ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗҮГЭЭС ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛ

Энэ судалгааны үндсэн зорилго нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээлэл цуглуулах явдал байсан боловч эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар зарим нэг мэдээллийг цуглуулаа.

Ингэхдээ тоон судалгааны асуулгад тухайн эмэгтэй хамтрагч эрэгтэйтэйгээ хэрхэн харьцдаг, хамтрагч нь түүнд гар хүрээгүй байхад хамтрагчаа цохиж зодож байсан эсэх тухай асуулт оруулж, холбогдох мэдээллийг цуглуулав. Бас чанарын судалгаагаар эрэгтэйчүүд, хүчирхийлэл үйлдэгч эрчүүд, хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдтэй ярилцлага хийх замаар эмэгтэйчүүд эрэгтэй хамтрагчидтай хэрхэн харьцдагийг судлав.

Өөрт нь гар хүрээгүй байхад хамтрагчаа цохиж, зодсон эмэгтэйчүүд нийт хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн бараг арван хувийг эзэлж байна (Зураг 4.36). Эдгээр эмэгтэйчүүдийг газар зүйн байршлаар харахад, ихэнх нь Улаанбаатар хот (11.6% хувь нь хамтрагчаа цохиж, зодсон) болон Төвийн бүсэд (11.1%) төвлөрсөн байна.


Зураг 4.36. Өөрт нь гар хүрээгүй байхад хамтрагчаа цохиж, зодсон эмэгтэйчүүд, байршил, бүс нутгаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Өөрт нь гар хүрээгүй байхад эмэгтэйчүүд хамтрагчаа зодож, цохисон тохиолдлын тал хувь нь (49.7 хувь) ганц удаагийн тохиолдол бол гуравны нэгээс илүү хувь нь (38.1 хувь) 2–5 удаагийн тохиолдол, 12.2 хувь нь тав ба түүнээс олон удаагийн тохиолдол байв (Зураг 4.37).

Зураг 4.37. Өөрт нь гар хүрээгүй байхад хамтрагчаа цохиж, зодсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь, давтамжаар, 2017 он (N=609)



Тайлбар: N=609 – Хамтрагчаа цохиж, зодсон эмэгтэйчүүдийн тоо


Чанарын судалгаа: Зорилтот бүлгийн ярилцлагад оролцсон эрэгтэйчүүд өмнөх эсвэл одоогийн эмэгтэй хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртжээ. Эмэгтэйчүүд эрэгтэй хамтрагчийнхаа эсрэг юм шидэх, алгадах, маажих, чимхэх, өшиглөх, үснээс нь зулгаах, ямар нэг юм ашиглан цохих үйлдлүүдээр бие махбодын хүчирхийлэл үйлддэг байна.

Судалгаанд оролцсон хүчирхийлэл, дарамтад өртдөг эрэгтэйчүүдийн зөвхөн нэг нь харилцан зодолддог бол бусад нь эхнэртээ гар хүрдэггүй гэжээ. “Эхнэртээ гар хүрдэггүй” гэж хариулсан эрэгтэйчүүд бараг бүгд “миний өссөн гэр бүл, манай эхнэрийнхээс өөр, хэрэлддэггүй, зодолддоггүй” гэж яриагаа эхлүүлсэн байв.


Тэд эхнэрийн бие махбодын хүчирхийллийн шинжтэй үйлдлийг гарыг нь барих, тэврэх, тэврээд дарж хэвтэх зэргээр зогсоодог байна. Мөн бүх оролцогчид гарч явдаг, цаашлаад архи, шар айраг уух, тамхи татах зэргээр тайвширдаг гэж хариулжээ. Нэгээс хоёр оролцогчид уурыг нь хүргэхгүйн тулд ярианы сэдвээ даруй өөрчлөх, хошин юм ярьж инээлгэдэг байна. Цөөн тооны хүн оролцсон тул харьцуулан жишихэд учир дутагдалтай ч, 15–34 насны эрэгтэйчүүд гэр бүлийн хүрээнд тулгамдаж буй хүчирхийлэл, дарамтын асуудлыг илэн далангүй хуваалцсанаараа онцлог байв.

БҮЛЭГ 5.

БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛ




Эмэгтэйчүүдийн эсрэг бие махбодын хүчирхийлэл үйлдэгч (амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн дүнд эзлэх хувь)



Бусдын зүгээс үйлдсэн хүчирхийллийн түвшин аймаг хооронд харилцан адилгүй байна. Амьдралдаа бусдын зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Улаанбаатар хотод хамгийн их буюу 22.1 хувь байгаа бол Ховд аймагт хамгийн бага буюу 5.1 хувь байв. Сүүлийн 12 сард бусдын зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Говьсүмбэр (7.3 хувь) болон Архангай (6.8 хувь) аймагт харьцангуй өндөр байгаа бол Ховд аймагт хамгийн бага буюу 1.1 хувь байна.


Зураг 5 а. Бусдын зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймаг, нийслэл, хугацаагаар, 2017 (N=7319)



Тайлбар: N=7319 – Судалгаанд хамрагдсан 15–64 насны эмэгтэйчүүдийн тоо

Орхон аймгийн эмэгтэйчүүдийн 18.1 хувь нь бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртөж байжээ. Мөн амьдралдаа бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Дорнод, Өмнөговь, Хэнтий, Дундговь болон Улаанбаатар хотод улсын дунджаас дээгүүр байгаа бол хамгийн бага нь Баян-Өлгий аймагт 6.1 хувь байна. Сүүлийн 12 сард бусдын зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Архангай аймагт хамгийн бага буюу 1.2 хувь байгаа бол Дорнод аймагт хамгийн өндөр буюу 5.4 хувь байсан.

Зураг 5 б. Бусдын зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймаг, нийслэл, хугацаагаар, 2017 (N=7319)



Тайлбар: N=7319 – Судалгаанд хамрагдсан 15–64 насны эмэгтэйчүүдийн тоо


Бусад (өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн хамтрагч байгаагүй, одоо ч хамтрагч бус этгээд)–ын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн хүчирхийллийн тархалтыг судалж, тодорхойлох нь судалгааны үндсэн зорилтуудын нэг байсан. Судалгаанд ярилцлага өгсөн нийт 7319 эмэгтэйгээс бусдын зүгээс хүчирхийлэлд өртөж байсан эсэхийг асуусан бөгөөд бусад гэдэгт гэр бүлийн гишүүд (эцэг, эх, ах, дүү, хадам ах, эгч, гэр бүлийн бусад гишүүд), найз нөхөд, танил тал, эрх мэдэл бүхий албан тушаалтан (цагдаа, багш, шашны удирдагч гэх мэт), эсвэл огт танихгүй хүнийг хамааруулав.

5.1 БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ

Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 17.3 хувь нь амьдралдаа (15 наснаас хойш), 4.5 хувь нь сүүлийн 12 сард бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна (Зураг 5.1). Өөрөөр хэлбэл таван эмэгтэй тутмын нэг нь амьдралдаа, хорин эмэгтэй тутмын нэг нь сүүлийн 12 сард хамтрагчаас бусад хүмүүсийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртжээ.

Хөдөө орон нутагтай харьцуулахад хот, суурин газар амьдардаг эмэгтэйчүүд бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд илүү их өртсөн байна. Хот суурин газар амьдардаг таван эмэгтэй тутмын нэг (20.1 хувь) нь амьдралдаа, 4.6 хувь нь сүүлийн 12 сард бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн ба хөдөө орон нутагт энэ үзүүлэлт тус бүр 11.6 хувь болон 3.6 хувь байна.

Зураг 5.1 Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, байршлаар, 2017 он (N=7319)



Тайлбар: N=7319 – Судалгаанд ярилцлага өгсөн нийт эмэгтэйчүүдийн тоо

Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд амьдралдаа (15–аас дээш насанд) наад зах нь нэг удаа өртсөн эмэгтэйчүүдийн хувь 15–19 насны залуу эмэгтэйчүүдийн дунд хамгийн их (24.8 хувь) байхад 60–64 насны эмэгтэйчүүдийн дунд хамгийн бага (9.8 хувь) байна. Сүүлийн 12 сард мөн 15–19 насны эмэгтэйчүүдийн хувьд хамгийн их (16.7 хувь), 30–34 насны эмэгтэйчүүдийн хувьд хамгийн бага буюу 3.1 хувь байлаа.


Зураг 5.2 Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, насны бүлгээр, 2017 он (N=7319)



Тайлбар: N=7319 – Судалгаанд ярилцлага өгсөн нийт эмэгтэйчүүдийн тоо 45–49, 50–54, 55–59 болон 60–64 насны бүлгийн эмэгтэйчүүд дотор сүүлийн 12 сард энэ төрлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдол ажиглагдаагүй, ажиглагдсан ч бодитой тооцоолол хийхэд хүрэлцэхээргүй хэт цөөн (өөрөөр хэлбэл 20–иос цөөн тооны хүн) байсан тул хасав..

Ихэвчлэн гэр бүлийн бусад гишүүд энэ төрлийн бие махбодын хүчирхийллийг үйлддэг бөгөөд сүүлийн 12 сарын байдлаар бусдын зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн 5 эмэгтэй тутмын нэг (21.7 хувь) нь төрсөн ах эсвэл эгчийнхээ үйлдсэн хүчирхийлэлд өртсөн бол 20.6 хувь нь эцэг, эхийнхээ үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна. (Зураг 5.3). Энэ төрлийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн үзүүлэлтийг харахад найз нөхөд, танилуудынхаа хүчирхийлэлд өртөх нь түгээмэл байна.

Зураг 5.3 Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн мэдээлснээр, хүчирхийлэл үйлдэгчид болон хугацаагаар, 2017 он (N=7319)



Тайлбар: N=7319 – Судалгаанд ярилцлага өгсөн нийт эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцсон 15–19 насны охидын хувьд төрсөн болон хойд эцэг, эх, өвөө, ах, эгч, дүү, үл таних хүн зэрэг бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд бусад насныхнаас илүү өртсөн байв. Түүнчлэн 35 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүд нөхөр, хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртөхөөс гадна хадам тал буюу нөхөр, хамтрагчийн талын ураг төрлийн холбоотой хүмүүсийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд давхар өртөх явдал цөөнгүй байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Манай ээж намайг аяга хагалсан ч зодно, юм хум авч шиднэ, аавд уурласан уураа надад гаргаж байнга үхтэл минь зоддог байсан. Тэр бас миний хамрыг минь хүртэл хугалж байсан.

15–19 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Манай гэр бүлийн хувьд эдийн засгийн байдал тэгш бус байсан болохоор аав минь ээжид уурласан уураа надад гаргадаг байсан. Би аавдаа эмнэлэгт хэвтэх хүртлээ зодуулж байсан.

15–34 настай ЛГБТ хүний ярианаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Би эгчээс нуугдаж сургуульдаа явдаг, намайг үйлчлэгч хий гээд байдаг юм. Сургуульдаа явж байгаад, баригдаад эгчдээ зодуулсан.

15–34 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас


Гүнзгийрүүлсэн ярилцлага: Ач (зээ) маань гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн. Үүнээс болж би хүргэндээ зодуулж, гэрээсээ хөөгдөж, 2–3 жил дарамтад амьдарсан. Цагдаад өгсөн гээд гэрийг маань хүртэл буулгаж байсан. Тэтгэвэрээр минь тэжээлгүүлж байсан атлаа п... гэж дуудаж, дарамталдаг. Охин маань биднийг өмөөрөөд зодуулна, сүүлдээ охин маань нөхөртөө захирагдаад намайг п..... гэж дууддаг болсон.

Тэтгэврийн насны эмэгтэйн ярианаас

Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийллийн хамгийн түгээмэл үйлдэл нь алгадах, цохих, зодох, өшиглөх эсвэл ямар нэгэн байдлаар өвтгөх зүйл хийх бөгөөд энэ үйлдэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүд 14.6 хувь, сүүлийн 12 сард өртсөн эмэгтэйчүүд 3.0 хувьтай байна (Зураг 5.4).

Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийллийн бусад хэлбэрүүд нь гэмтэж бэртэхээр ямар нэгэн юм шидэх, түлхэх, үснээс нь зулгаах бөгөөд энэ хэлбэрийн хүчирхийлэлд эмэгтэйчүүдийн 7.8 хувь, хутга эсвэл бусад зэвсгээр сүрдүүлэх хүчирхийлэлд 2.0 хувь, хоолой боох эсвэл санаатайгаар түлэх хүчирхийлэлд 1.7 хувь нь амьдралдаа өртсөн байна.

Зураг 5.4 Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, үйлдлээр, 2017 он (N=7319)




Тайлбар: N=7319 – Судалгаанд ярилцлага өгсөн нийт эмэгтэйчүүдийн тоо

Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн онцлог

Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд сүүлийн 12 сард өртсөн эмэгтэйчүүдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл хамгийн их буюу 8.4 хувь нь суурь боловсролтой эмэгтэйчүүд, хамгийн бага буюу 2.8 хувь нь дээд боловсролтой эмэгтэйчүүд байна. Үүнээс үзвэл суурь боловсролтой залуу эмэгтэйчүүдийн ихэнх нь ажилгүй байж болзошгүй бөгөөд эцэг, эх, ах дүү, багш нарын зүгээс авсан сахилгын арга хэмжээнд өртсөн байх магадлал их байна. Дээд боловсролтой

эмэгтэйчүүд энэ төрлийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн хувь нь сүүлийн 12 сард өртсөн эмэгтэйчүүдээс их байна.


Зураг 5.5 Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, боловсролын түвшин, хугацаагаар, 2017 он (N=7319)



Тайлбар: N=7319 – Судалгаанд ярилцлага өгсөн нийт эмэгтэйчүүдийн тоо

Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл ажилгүй дөрвөн эмэгтэй тутмын нэг (24.3 хувь) нь энэ төрлийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн байхад тэтгэвэрт гарсан эмэгтэйчүүдийн 10.3 хувь нь өртсөн байна. Энэ үзүүлэлт нь насны бүлгээр ялгаатай бөгөөд бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд хамгийн их өртсөн гэх залуу эмэгтэйчүүд нь ажилгүй эсвэл оюутан байх магадлал их юм.

Зураг 5.6. Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хугацаагаар, 2017 он (N=7319)



Тайлбар: N=7319 – Судалгаанд хамрагдаж ярилцлага өгсөн нийт эмэгтэйчүүдийн тоо

5.2 БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд долоон эмэгтэй тутмын нэг (14.0 хувь) нь амьдралдаа наад зах нь нэг удаа өртсөн байхад сүүлийн 12 сард 2.6 хувь нь өртсөн байна.

Бэлгийн хүчирхийллийн үйлдлүүдийг дунд болон хүнд гэж хоёр ангилсан. Дунд хэлбэрийн хүчирхийлэлд хүсээгүй байхад бэлгийн хавьталд хүчээр оруулахыг завдах, хүсээгүй байхад биед нь хүрэх, өөрийн нууц хэсэгтээ хүчээр хүргүүлэх зэрэг үйлдлүүдийг хамааруулна. Хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд хүчээр бэлгийн харьцаанд орох, архи, мансууруулах

бодис хэрэглэсэн үед бэлгийн харьцаанд орох, нэгээс дээш хүнтэй нэгэн зэрэг бэлгийн харьцаанд хүчээр орох зэрэг үйлдлүүдийг хамааруулсан юм.

Хүснэгт 5.1–д харуулснаар амьдралдаа дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд нийт эмэгтэйчүүдийн 12.5 хувь нь өртсөн байхад хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд 3.1 хувь нь өртсөн байна.

Бусдын зүгээс үйлдсэн дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийг үйлдлээр нь авч үзэхэд 8.1 хувь нь хүсээгүй байхад биед нь хүрсэн, 6.6 хувь нь хүсээгүй байхад бэлгийн хавьталд хүчээр оруулахыг завдсан, 1.2 хувь нь өөрийн нууц хэсэгтээ хүчээр хүргүүлсэн гэж тус тус хариулжээ.


Хүснэгт 5.1 Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (15–аас дээш насандаа) өртсөн эмэгтэйчүүд, хүчирхийллийн хэлбэр, үйлдлээр, 2017 он (N=7319)

Амьдралдаа	
Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд	14.0
Хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд	3.1
Хүчээр бэлгийн харьцаанд орсон (хүчин)	2.6
Согтуу эсвэл мансуурсан үед бэлгийн хавьталд хүчээр орсон	1.0
Олон хүнтэй нэгэн зэрэг бэлгийн хавьталд хүчээр орсон	0.2
Дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн	12.5
Хүсээгүй байхад бэлгийн хавьталд хүчээр оруулахыг завдсан	6.6
Хүсээгүй байхад биед хүрсэн	8.1
Өөрийн бэлэг эрхтэндээ хүчээр хүргүүлсэн	1.2

Тайлбар: N=7319 – Судалгаанд ярилцлага өгсөн нийт эмэгтэйчүүдийн тоо.

Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (15–аас дээш насандаа) өртсөн эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзэхэд залуу эмэгтэйчүүд түлхүү өртсөн байна. Зураг 5.7–оос харахад нийт бэлгийн хүчирхийллийн ихэнхийг дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл эзэлж байна. Дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн нас ахих тусам буурч байгаа бол хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл нь бүх насны бүлэгт ойроцоогоор 3 хувь байна.


Зураг 5.7 Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (5–аас дээш насандаа) өртсөн эмэгтэйчүүд, насны бүлэг, хүчирхийллийн хэлбэрээр, 2017 он (N=7319)



Тайлбар: N=7319– Судалгаанд ярилцлага өгсөн нийт эмэгтэйчүүдийн тоо.

Амьдралдаа бусдын зүгээс үйлдсэн дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг давтамжаар нь авч үзвэл гуравны хоёр (64.1 хувь) нь нэг удаа, 30.7 хувь нь цөөн удаа, 5.2 хувь нь олон удаа өртсөн гэжээ. Бусдын зүгээс үйлдсэн хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 68.7 хувь нь нэг удаа, 21.8 хувь нь 2–5 удаа, 9.5 хувь нь 5–аас дээш удаа хүнд хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн байна.

Зураг 5.8 Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (15–аас дээш насандаа) өртсөн давтамж, хүчирхийллийн хэлбэрээр, 2017 он (N¹=723, N²=234)



Тайлбар: N¹=723 – Бусдын зүгээс үйлдсэн дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (15–аас дээш насандаа) өртсөн эмэгтэйчүүдийн тоо, N²=234 – Бусдын зүгээс үйлдсэн хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (15–аас дээш насандаа) өртсөн эмэгтэйчүүдийн тоо

Бусдын зүгээс үйлдсэн дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл нь гадаа гудамжинд (14.3%), ажил дээр (13.6%), өөрийн гэрт (12.6%), сургуулийн орчинд (12%) ихэвчлэн болдог байна. Харин хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл нь эмэгтэйн өөрийн гэрт (65.0%), хээр газар, ой мод, цэцэрлэгт хүрээлэнд (10.9%) болдог байна.

Хүснэгт 5.2 Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэл, үйлдсэн газар (байршлыг хувиар илэрхийлэв), хүчирхийллийн хэлбэрээр, 2017 он

Байршил	Хүнд хэлбэрийн (N=234)	Дунд хэлбэрийн (N=723)
Өөрийн гэрт	65.0	12.6
Хээр газар, ой мод, цэцэрлэгт хүрээлэнд	10.9	8.1
Зочид буудал/ амралтын газарт	4.7	7.8
Гадаа/гудамжинд	4.1	14.3
Ажил дээр	4.0	13.6
Өөр хүний гэрт	2.9	7.9
Түүний гэрт	2.5	6.6
Машинд	1.8	3.3
Баар, цэнгээний газарт	1.6	7.2
Сургуулийн орчинд	6.7	12.0
Буса	1.8	6.7
Бүгд	100.0	100.0

Тайлбар: N¹=723 – Бусдын зүгээс үйлдсэн дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (15–аас дээш насандаа) өртсөн эмэгтэйчүүдийн тоо, N²=234 – Бусдын зүгээс үйлдсэн хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (15–аас дээш насандаа) өртсөн эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Бэлгийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдийн цөөнх нь дунд хэлбэрийн хүчирхийллийн тухай ярьжээ. Дийлэнх нь хүнд хэлбэрийн хүчирхийлэл буюу бэлгийн хүчирхийлэлд өртөж, улмаар жирэмслэх, хүүхдээ авахуулах, мөн хүүхдээ төрүүлэхээс өөр аргагүй нөхцөлд орсон байна.

Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийллийг цагдаад мэдээлсэн байдал

Судалгаагаар хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдол 21 мэдээлэгдсэн бөгөөд тэдний зөвхөн 10.2 хувь нь хүчирхийлэлд өртсөн тухайгаа цагдаад мэдэгдсэн байна (Зураг 5.9).

Зураг 5.9 Бусдын зүгээс үйлдсэн хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүд уг хүчирхийллийг цагдаад мэдээлсэн байдал, 2017 он (N=234)



Тайлбар: N=234 –Бусдын зүгээс үйлдсэн хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа (15 наснаасаа хойш) өртсөн эмэгтэйчүүдийн тоо

Хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөнөө 21 эмэгтэй цагдаагийн байгууллагад мэдээлсэн байна. Үүнээс 9 нь хэрэг үйлдэгчийг баривчлаагүй, 8 нь хэрэгтнийг баривчилж, шийтгэсэн, 3 нь хэрэгтнийг баривчилсан гэхдээ шийтгээгүй гэж хариулсан байна.

Чанарын судалгаа: Бэлгийн хүчирхийллийн тохиолдол бүрийг цагдаа, хуулийн байгууллагад мэдээлж, хэрэг үйлдэгчдэд зохих шийтгэлийг оногдуулдаггүй байна. Архидан согтуурсанаас үүдэн гарсан бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг хохирогч эмэгтэй өөрийн болон гэр бүлийн нэр хүнд, хэрэгтний гэр бүлийн нэр хүндийг бодож тэр бүр цагдаад мэдээлдэггүй байна. Энэ хүчин зүйлүүд нь хэрэгтнүүдийг хуулийн хариуцлагаас зайлсхийх боломжийг олгож байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Хойд эцгийн хамаатан намайг бас манай ээжийг хүчиндсэн. Тэр намайг 2–3 удаа хүчиндсэн. Тэр манай ээжийг хэрцгийгээр зодож, намайг ч бас цохисон. Ээж түүнийг цагдаад мэдэгдсэн. Гэвч тэр мөнгө өгнө гэж амлан, ээж цагдаагаас гомдолоо татаж авсан. Тэгээд тэр 2–3 сая төгрөг өгөөд, дахиж мөнгө өгөөгүй. Би 4-р анги хүртэлээ сургуульд сурч байгаад сургуулиа орхисон.

15–19 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Хойд эцэг анх удаа хүчиндэхэд онгон хальс цоороогүй гээд цагдаагийн байгууллагаас гүтгэгдсэн гэсэн дүгнэлт гарсан. Тэгээд тэр намайг дахин хүчирхийлсэн. Ер нь долоо хоногийн давтамжтай хүчинддэг байсан. Эрүүл, согтуу, өдөр, шөнө хамаагүй хүчинддэг байсан. Ээжийг минь их зоддог. Хутга авч шиднэ. Анх би эмээ, өвөө хоёртоо хэлсэн бөгөөд тэд ээжид хэлсэн, тэгэхэд ээж яах учраа олохгүй сандарсан байж байхад нагац ах ирж таараад ярилцсан. Тэгээд цагдаа, шүүхээр явсан юм. Хэрэг нь шийдэгдээд 15 жилийн ял авсан. Хойд эцгийг өмнө нь хүчиндэх болгонд ээжид хэлэхээр намайг худлаа ярьсан гээд ээжид ойлгуулчихдаг байсан юм. Би эцэг ондоотой дөрвөн дүүтэй болохоор ээжийгээ өрөвддөг, анх хүчиндүүлсэн тухайгаа хэлэхэд хэцүү байсан.

15–19 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Анх тийм зүйл болоход би яахаа мэдэхгүй байсан. Аавын эгч нь чиний болон аавын чинь нэр хүнд унана, шоронд орно гэсэн. Тэгээд хэлээгүй тэвчиж өнгөрүүлсэн. Жирэмсэн болсон тул өсвөрийн эмч, сэтгэл зүйч нар надад зөвөлгөө өгөөд “цагдаад өг” гэсэн. Гэхдээ энд ээжийн дүү нар цагдаад өгч, гэр бүлээсээ хасуул гэсэн. Ээжийг улам дарамтална гэж айгаад ээждээ хэлж чадаагүй байсан юм. Энэ хэрэг явдал жилд таван удаа болдог байсан.

15–19 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Танилцах үдэшлэгээр би архи ууж, хянах чадвараа алдсан байсан юм. Биеэ хянах чадвараа алдсан байсныг баарны хамгаалагч олзлоод хүчиндсэн. Дараа нь биеэ харахад бие, гар хөлийн дотор тал хөх няц, одоо бодохоор хамаг бие салгалаад байдаг болсон.

15–19 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Би бол ээж аав дээрээ сардаа нэг л очдог. Нэг удаа гэртээ очиж хоносон. Би их бөх унтдаг. Шөнө манай аав намайг оролдоод унтаж байхад дотуур хувцас тайлчихсан байсан. Би сэрээд гайхаад аавыг болиоч гээд түлхсэн аав сонсохгүй болохоор ноцолдоод ээжийг дуудаж сэрээгээд ээж салгасан. Аав уурлаад над руу гутлаа чулуудсан. Би тэр шөнөө эмээгээ дуудаад эмээдээ болсон бүх явдлыг ярьсан, шууд цагдаад хандсан. Энэ явдал 2 жилийн өмнө болсон. Эхлээд үндэслэлгүй гээд буцаасан. Эмээ давж заалдаад гурван жил зургаа сарын ял өгсөн гэсэн. Тэгээд хоёр жил суугаад одоо гарчихсан байгаа. Сургуулиа солиод өөр сургуульд ирээд гайгүй болсон.

15–19 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

5.3 ХҮҮХЭД НАСАНД БУЮУ 15 ХҮРТЭЛХ НАСАНДАА ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ЭМЭГТЭЙЧҮҮД

Эмэгтэйчүүдээс 15 хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг асуулаа. Энэ нь маш эмзэг сэдэв учраас судалгааны асуулга хэлбэрээр асуух болон ярилцлагын төгсгөлд нууцлалыг хангасан карт өгч, хариулт авах гэсэн хоёр 2 өөр аргыг ашиглав (Зураг 5.10).

Зураг 5.10 Хүүхэд (15 хүрэлх) насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг тэмдэглэх карт, 2017 он

Гунигтай царайг тэмдэглэх тохиолдол


- Хөх эсвэл бэлэг эрхтэнд хүрэх
- Хүсээгүй байхад бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой зураг үзүүлэх
- Өөрийнхөө бэлэг эрхтэнд хүргэх
- Бэлгийн харьцаанд орох гэж оролдох эсвэл орох

Баяртай царайг тэмдэглэх тохиолдол

- Дээрх зүйлс тохиолдож байгаагүй бол баяртай царайг тэмдэглэх

Судалгаанд хамрагдсан арван эмэгтэй тутмын нэг (10.7 хувь) нь хүүхэд насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна (тэдний 3.4 хувь нь асуулгын дагуу мэдээлсэн болон 8.9 хувь картаар мэдээлэв). Хүүхэд насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж хариулсан эмэгтэйчүүдийн хувь хөдөө орон нутагт арай их байна (Зураг 5.11).


Зураг 5.11 Хүүхэд насандаа (15 хүртэлх насандаа) бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хот, хөдөөгийн байршлаар, 2017 он (N=7319)



Тайлбар: N=7319–Судалгаанд ярилцлага өгсөн бүх эмэгтэйчүүдийн тоо

Хүүхэд насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн гурван эмэгтэй тутмын нэг (29.5 хувь) нь тэдний гэр бүлийн бусад гишүүд, 19.0 хувь нь найз нөхөд, танил хүмүүс, 18.7 хувь нь танихгүй хүмүүс хүчирхийлсэн гэж хариулсан байна (Зураг 5.12).

Зураг 5.12 Хүүхэд насандаа (15 хүртэлх насандаа) бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж судалгааны үед мэдэгдсэн эмэгтэйчүүд, үйлдэгчээр, 2017 он (N=265)



Тайлбар: N=265 – Хүүхэд насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж судалгааны үед мэдэгдсэн эмэгтэйчүүдийн тоо

5.4 АНХНЫ БЭЛГИЙН ХАРЬЦАА

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн ихэнх (55.3 хувь) нь 18–21 насандаа анх бэлгийн харьцаанд орсон байна. Харин цөөнх буюу 0.8 хувь нь 15 нас хүрэхээс өмнө, 10 эмэгтэй тутмын нэг (10.2 хувь) нь 15–17 насандаа анх бэлгийн харьцаанд оржээ. Хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн анх бэлгийн харьцаанд орсон нас бага зэрэг зөрүүтэй байна. Эндээс үзвэл 15–17 насандаа анх бэлгийн харьцаанд орсон хөдөөгийн эмэгтэйчүүд (12.4%)–ийн хувь, хотын эмэгтэйчүүдийнхээс (9.1%) их буюу хөдөөний эмэгтэйчүүд хотын эмэгтэйчүүдээс түрүүлж бэлгийн харьцаанд орсон байна.

Зураг 5.13 Эмэгтэйчүүд анх бэлгийн харьцаанд орсон нас, байршлаар, 2017 он (N=7232)




Тайлбар: N=7232 –Бүлэгт хамаарах асуултанд хариулсан эмэгтэйчүүдийн тоо

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс анх бэлгийн харьцаанд өөрөө хүсч орсон уу эсвэл хүчээр орсон уу гэдгийг лавласан бөгөөд тэдний ихэнх (86.5 хувь) нь анх удаа бэлгийн харьцаанд орохдоо өөрөө зөвшөөрсөн гэж хариулжээ. Арван эмэгтэй тутмын нэг (10.2 хувь) нь хүсээгүй гэхдээ бэлгийн харьцаанд орсон, 2.9 хувь нь хүчээр бэлгийн харьцаанд орсон гэж хариулсан байна. Харин анх бэлгийн харьцаанд орсон насаар ангилан үзэхэд 15 хүртэлх насанд бэлгийн харьцаанд орсон эмэгтэйчүүдийн ихэнх нь хүчээр (61.0%) эсвэл хүсээгүй үедээ (14.3%) бэлгийн харьцаанд орсон байна. Тэдний

ердөө дөрөвний нэг нь л бэлгийн харьцаанд өөрөө хүсч орсон байна (Зураг 5.15). Анх хүчээр бэлгийн харьцаанд орсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 15–17 насны бүлэгт мөн өндөр (11.9 хувь) байна.

Зураг 5.14 Анх бэлгийн харьцаанд орохдоо хүсэж байсан эсэх, анх бэлгийн харьцаанд орсон насны бүлэгээр, 2017 он (N=6814)




Тайлбар: N=6814 – Судалгаанд хамрагдсан, бэлгийн харьцаанд орсон эмэгтэйчүүдийн тоо

5.5 ХАМТРАГЧ БОЛОН БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Хугацаанаас үл хамааран хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл нь бусдын зүгээс үйлдсэн хүчирхийллээс илүү түгээмэл байна. Зураг 5.16–д харуулснаар дотны хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд (29.7%) амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн хувь бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийллээс даруй 12.4 пунктээр илүү байна. Харин сүүлийн 12 сард энэ үзүүлэлт 7.4 пунктээр илүү байна.

Зураг 5.15 Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь (N=7319), хамтрагчийн үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь (N=6914), хугацаагаар, 2017 он




Тайлбар: N=7319 – Судалгаанд ярилцлага өгсөн эмэгтэйчүүдийн тоо
N=6914 – Судалгаанд хамрагдсан хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Дотно хамтрагч болон бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн 25 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн хувьд дотно хамтрагчийн үйлдсэн хүчирхийлэлд өртөх нь илүү их байна (Зураг 5.17). 40–44 насны таван эмэгтэй тутмын хоёр (40.7 хувь) нь хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн бол 15.0 хувь нь (15–аас дээш насандаа) бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртжээ.

Сүүлийн 12 сард хамтрагч болон бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь мөн зөрүүтэй байна. 15–19 насны эмэгтэйчүүд бусдын зүгээс үйлдсэн хүчирхийлэлд илүү өртсөн байхад 20 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүд нөхөр болон дотно хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд илүү өртжээ.


Зураг 5.16 Бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүчирхийлэл үйлдэгч болон насны бүлгээр, 2017 он (N¹=7319, N²=6914)



Тайлбар: N¹=7319 – Судалгаанд ярилцлага өгсөн эмэгтэйчүүдийн тоо
N²=6914 – Судалгаанд хамрагдсан хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн хувь хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувиас 6 пунктээр илүү байгаа бол сүүлийн 12 сард энэ үзүүлэлт бараг ойролцоо буюу хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэл нь бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийллээс 0.4 пунктээр их байна (Зураг 5.17).


Зураг 5.17 Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь (N¹=7319), хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь (N²=6914), хугацаагаар, 2017 он



Тайлбар: N¹=7319 – Судалгаанд ярилцлага өгсөн эмэгтэйчүүдийн тоо
N²=6914 – Судалгаанд хамрагдсан хамтрагчтай байсан / байгаа эмэгтэйчүүдийн тоо

Амьдралдаа болон сүүлийн 12 сард бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг насны бүлгээр харвал залуу эмэгтэйчүүдийн хувьд бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд илүү өртөж байхад 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн хувьд дотно хамтрагчийн үйлдсэн хүчирхийлэлд илүү өртөж байна.

Зураг 5.18 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, үйлдэгч, насны бүлэг, хугацаагаар, 2017 он



Тогтвортой Хөгжлийн Зорилтын шалгуур үзүүлэлтүүд

Тогтвортой хөгжлийн зорилтууд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар энэхүү судалгааны мэдээллээс гарган авах боломжтой хоёр шалгуур үзүүлэлтүүдийг багтаасан. Шалгуур үзүүлэлт 5.2.1 нь хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэлтэй холбоотой үзүүлэлт юм. Сүүлийн 12 сарын хугацаанд эмэгтэйчүүдийн бараг дөрөвний нэг нь (23.6 хувь) бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж байсан бол эдгээр хүчирхийлэлд 30–34 насны эмэгтэйчүүд хамгийн ихээр (32.5 хувь) өртсөн байхад 55–59 насны эмэгтэйчүүд хамгийн бага (10.1 хувь) өртсөн байна.

Хүснэгт 5.3 Одоогийн болон өмнөх хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэлд сүүлийн 12 сарын хугацаанд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлгээр, 2017 он

	ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭЛБЭР										
	Бие махбодын		Бэлгийн		Сэтгэл санааны		Бие махбодын/Бэлгийн		Бие махбодын/Бэлгийн/Сэтгэл санааны		Нийт хамтрагчтай эмэгтэйчүүд
Насны бүлэг	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
15–19	6	8.0	1	0.4	14	13.7	6	8.0	16	14.7	140
20–24	49	16.0	9	2.7	80	24.7	51	16.4	88	26.6	392
25–29	147	15.7	34	3.7	269	27.3	161	17.4	283	28.4	901
30–34	174	16.6	43	5.6	286	31.6	181	17.7	302	32.5	1032
35–39	147	12.4	35	3.8	267	25.8	150	12.7	284	27.2	1025
40–44	124	13.4	42	4.7	223	24.9	132	14.8	238	26.6	902
45–49	61	9.3	11	1.1	142	20.4	64	9.5	146	20.8	783
50–54	49	6.1	6	0.7	116	14.7	51	6.6	119	15.1	769
55–59	22	3.3	7	0.7	58	9.0	24	3.6	60	10.1	593
60–64	9	2.7	0	0.0	18	4.2	9	2.7	20	4.8	377
Нийт	788	11.9	188	3.0	1473	22.4	829	12.7	1556	23.6	6914
15–49	708	13.8	175	3.6	1281	25.5	745	14.7	1357	26.7	5175

ТХЗ-ын шалгуур үзүүлэлт 5.2.2 нь сүүлийн 12 сарын хугацаанд бусдын (хамтрагч бус этгээдийн) зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдлыг тодорхойлно. Сүүлийн 12 сарын хугацаанд эмэгтэйчүүдийн 2.6 хувь нь бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна (Хүснэгт 5.3). Үүнд залуу эмэгтэйчүүд, ялангуяа 15–19 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байна.

Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бараг гуравны хоёрт нь (65.0 хувь) хүчирхийлэл тэдний гэрт эсвэл хашаанд нь болсон, 10.9 хувь нь хээр газар, ой мод, цэцэрлэгт хүрээлэнд болсон байна.

Хүснэгт 5.4 Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд сүүлийн 12 сарын хугацаанд өртсөн 15 болон түүнээс дээш насны охид эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлгээр, 2017 он

Насны бүлэг	Тоо	Хувь	Нийт эмэгтэйчүүд
15–19	31	7.7	411
20–24	14	3.5	447
25–29	22	2.0	920
30–34	26	2.6	1043
35–39	21	2.3	1030
40–44	23	2.7	914
45–49	6	0.5	800
50–54	9	0.6	775
55–59	4	0.4	599
60+	3	1.1	380
Нийт	159	2.6	7319
15–49	143	3.1	5565

БҮЛЭГ 6.

ЖЕНДЭР БОЛОН ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ХАНДЛАГА

Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд
өртсөн эмэгтэйчүүдийн

55.4%

нь дараах тодорхойлолттой
санал нийлжээ



“Сайн эхнэр
нөхөртэйгээ санал
нийлээгүй ч үгийг нь
дагадаг”

6.1 ЖЕНДЭР БОЛОН ХАМТРАГЧИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХАНДЛАГА

Энэ бүлэгт жендэр болон хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд хандах эмэгтэйчүүдийн хандлага, түүнчлэн хүчирхийллийг Монголын нийгэмд хүлээн зөвшөөрөх хандлага хэр зэрэг байгааг судалсан болно. Хүчирхийлэлд хандах эмэгтэйчүүдийн хандлага болон ойлголтын талаарх мэдээллийг хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхээс үл хамааран бүх эмэгтэйчүүдээс цуглуулж, хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртөж байсан болон өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн хариултыг харьцуулан харуулсан.

Зарим эмэгтэйчүүд тодорхой шалтгаанаар нөхөр нь эхнэр/хамтрагчаа цохих буюу зодох явдал байж болно гэж үзсэн байна (Зураг 6.1). Тэдгээр шалтгаануудын дотроос “Нөхөр нь эхнэрээ өөр эрэгтэйтэй дотно харилцаа үүсгэснийг мэдвэл” цохиж, зодож болно гэх хариулттай бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагүй таван эмэгтэй тутмын хоёр нь (22.2 хувь) нь санал нийлсэн байна. Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүд энэ хандлагатай бүр илүү (35.5 хувь) санал нийлжээ. Хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүд нь асуулгад дурдагдсан цохих зодохыг зөвтгөх бүхий л шалтгаануудын хувьд хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүүтэй санал нийлж байв.

Зураг 6.1. Тодорхой шалтгаанаар нөхөр нь эхнэрээ цохиж, зодох нь зөв гэж үзсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N¹=5144, N²=2175)



Тайлбар: N¹=5144 – Амьдралдаа хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн тоо
N²=2175 – Амьдралдаа хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогч эмэгтэйчүүдийн ярилцлагаас жендэрийн үүргийн талаарх ойлголт, төсөөллийн хувьд дараах нийтлэг дүр зураг ажиглагдав. Энэ нь ерөнхийдөө, эрэгтэйчүүд (нөхөр, найз залуу) хамтрагчаа өөрийн хүссэнээр байх, тэдний шаардлага, хүлээлтэд нь нийцэж байхыг шаардах ёстой гэсэн хандлага байв. Энэ нь эцгийн эрхт ёсны үеийн хүлээлт, шаардлага бөгөөд хэрвээ эхнэр энэ шаардлага, хүлээлтийг биелүүлэхээс татгалзах, үл зөвшөөрөх нь гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж байна. Судалгааны явцад дараах түгээмэл хандлага байгаа нь ажиглагдлаа:

- Эрэгтэйчүүд дүрмийг зохионо: “Би чиний нөхөр учраас ажил хийх эсэх, найз нөхөдтэйгээ уулзах эсэх, оройтож болох эсэхийг нь шийднэ” гэх.
- Эмэгтэйчүүд нөхрөө дэмжихгүй байх: “Эхнэр нь нөхөртөө асуулт тавих, тавьсан шаардлагыг нь биелүүлэхгүй байх, хүчирхийлэл дарамтыг нь эсэргүүцэх, хүлцэнгүй биш байх, хэрэлдэх, нөхрөө буруутгах, зэмлэх, үглэх, загнах, хардаж мөрдөх, согтуу байхад нь аргадахын оронд уурлах,” зэргээр нөхрийн зан үйлд зохицохгүй, үл таашаагдах үйлдэл хийх.
- Нөхөр болон хадмуудын шүүмжлэл: “Арчаагүй, гэр орноо цэвэрлэдэггүй, ажлаасаа ирэхэд нь халуун хоол ундтай

угтдаггүй, амтгүй эсвэл дургүй хоолыг нь хийдэг, гэр орондоо нэмэр болдоггүй, гэртээ тогтдоггүй” гэх зэргээр сайн эзэгтэй байж чадахгүй.

- Эдийн засгийн асуудлууд: “Нөхрөөсөө асуухгүйгээр мөнгө зарцуулах, нөхрөөсөө илүү мөнгө олсноо гайхуулж буй мэт сэтгэгдэл төрүүлэх, орон байраа нөхрийнхөө нэр дээр бүртгүүлэхгүй байх” зэрэг эдийн засгийн асуудлууд.
- Эхнэрийнхээ үүргийг биелүүлэхгүй байх: “Нөхрийнхөө бэлгийн дур хүслийг биелүүлэхгүй байх, оройтож ирэх, өөр хүмүүстэй утсаар ярих, нөхрөөсөө нууцаар ямар нэгэн үйлдэл хийх” зэргээр үнэнч эхнэрийн үүргийг биелүүлэхгүй байх.
- “Нөхрөө (найз залуугаа) өөр эртэй явалдан хуурах, нөхрөө гомдоох зорилгоор нөхрийнхөө хажууд нууц амрагтайгаа ярих” зэргээр сэтгэлийг нь үл татах шалтгаанаар хуурах, мэхлэх, хуурч мэхэлж байгаагаа зөвтгөх, улмаар энэ талаар яриа өдлөө гэж хэрэлдэх.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Залуу хүмүүст хэлэхэд юуны түрүүнд салж болохгүй. Аль болох арга эвийг нь олж байх хэрэгтэй. Урдаас нь догшин авир гаргаж болохгүй. Ширүүлэхээр улам л болохоо байдаг. Тэгэхээр эвийг нь олж амьдрах хэрэгтэй. Би ширүүлж үзсэн. Янз бүрийн арга хэрэглэж үзсэн. Зөөлөн байж, арга эвийг нь олох нь илүү дээр байдаг. Би нөхрийгөө гараад явахад нь хориглоод байдаггүй. Өөрийнхөө дур зоргоор амьдарч байгаа хүн хүчрэгдэхгүй биз гэж боддог.

35–64 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гэр бүл дэх жендэрийн үүрэг ролийн талаархи эмэгтэйчүүдийн хэвшмэл ойлголт нь гэр бүлийн хосуудын хооронд зарим зан үйл хэрхэн хүлээн зөвшөөрөгддөг болохыг харуулж байна. Хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн бараг тал нь буюу 47.6 хувь, хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн талаас их буюу 55.4 хувь нь “Сайн эхнэр, нөхөртэйгөө санал нийлээгүй ч үгийг нь дагадаг” гэсэн ойлголттой санал нийлсэн байна. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин ахих тусам энэ хандлагатай санал нийлэх нь багасч байна (Зураг 6.2). Хүчирхийлэлд өртөж байгаагүй, дээд боловсролтой эмэгтэйчүүдийн 34.5 хувь нь, хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн 42.3 хувь нь үүнтэй санал нийлсэн бол хүчирхийлэлд өртөж байгаагүй, боловсролгүй эмэгтэйчүүдийн 70 орчим хувь, хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн 80 орчим хувь нь санал нийлжээ.

Зураг 6.2. “Сайн эхнэр, нөхөртэйгээ санал нийлээгүй ч үгийг нь дагадаг” гэсэн ойлголттой санал нийлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, боловсролын түвшнээр, 2017 он (N¹=5144, N²=2175)



Тайлбар: N¹=5144 – Амьдралдаа хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн тоо
 N²=2175 – Амьдралдаа хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тоо


Чанарын судалгаа: Хамтрагч (нөхөр, найз залуу)-ийн эхнэрээс шаардах эцгийн эрхт ёсны хүлээлт ба эхнэрийн зүгээс энэ хүлээлтийг үл зөвшөөрөх, үл биелүүлэх буюу хэрхэн хүлээн авч байгаа байдал гэр бүлийн хүчирхийлэлд шууд нөлөөлж байна. Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртдөг эмэгтэйчүүдийн ихэнх нь нөхрийн дээр дурдсан хүлээлтийг үл таашааж, хүчирхийллийг ямагт буруушааж байгаа боловч гэр бүлээ авч үлдэхийн тулд тэвчдэг. Гэхдээ дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд цаашид хүчирхийлэл давтагдвал салах буюу үл тэвчинэ гэсэн хариултыг өгсөн бол хүчирхийллийн улмаас тэвчишгүй нөхцөлд хүрч, эрүүл мэндээрээ хохирсон, нөхрөөсөө салж, тусдаа амьдарч буй эмэгтэйчүүд хүчирхийллийг тэвчих хэрэггүй гэжээ.

Зорилтот бүлгийн ярилцлага: *Хэн гэрт мөнгө олж байна, тэр давуу эрх мэдэлтэй болдог. Долгор гэртээ суун хүүхдээ асарч байна, энэ нь нөхөр нь өөрийнхөөрөө бүх зүйлийг шийдэхэд хүргэж байна. Дээр нь тэр 5 дугаар анги төгссөн учраас хаана, хэнд хандахаа мэдэхгүй, өөрийнхөө болон нөхрийнхөө нэр хүндийг бодоод тэвчиж байгаа нь буруу. Эмэгтэй хүн боловсролоо ахиулах хэрэгтэй.*

35–64 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн “Сайн эхнэр, нөхөртэйгээ санал нийлээгүй ч үгийг нь дагадаг” гэсэн үзэлтэй санал нийлж буй байдал насны бүлгийн хувьд ихээхэн ялгаатай байна. Залуу эмэгтэйчүүд ахимаг насны эмэгтэйчүүдээс илүүтэйгээр энэ хандлагыг үгүйсгэсэн байна (Зураг 6.3). Насны бүлэг бүрт хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдтэй харьцуулбал уг хандлагатай санал нийлэх нь илүүтэй байв. Залуу эмэгтэйчүүд энэхүү үзэлтэй санал нийлэх нь бага байгаа нь Монголын нийгэм дэх жендэрийн асуудалд хандах хандлага сүүлийн жилүүдэд ихээхэн өөрчлөгдөж буйн илрэл юм.

Зураг 6.3. “Сайн эхнэр, нөхөртэйгээ санал нийлээгүй ч үгийг нь дагадаг” гэсэн ойлголттой санал нийлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, насны бүлгээр, 2017 он (N¹=5144, N²=2175)



Тайлбар: N¹=5144 – Амьдралдаа хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн тоо
N²=2175 – Амьдралдаа хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тоо

Нийт эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар авч үзвэл, тэтгэвэрт гарсан хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагүй ахимаг насны эмэгтэйчүүд дээрх үзлийг хамгийн ихээр буюу 66.5 хувь нь хүлээн зөвшөөрчээ. Улмаар ямар нэгэн хөдөлмөр эрхэлдэггүй эмэгтэйчүүдийн 48.4 хувь, гэрийн эзэгтэй нарын 47.1 хувь нь энэ хандлагыг хүлээн зөвшөөрчээ. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан, мөн хөдөлмөр эрхэлддэггүй эмэгтэйчүүдийн хувь өндөр буюу 64.2 хувь байна. Харин ямар нэгэн ажил, хөдөлмөр эрхэлж мөнгө олдог эмэгтэйчүүдийн хувьд дээрх байдлыг хүлээн зөвшөөрөх нь харьцангуй бага

байна. Өөрөө мөнгө олдоггүй буюу гэртээ хүүхдээ асардаг, ямар нэг шалтгааны улмаас ажил хийж мөнгө олох боломжгүй эмэгтэйчүүд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэхдээ төдийлөн өөртөө итгэлтэй бус, нөхөр/хамтрагчийхаа үг, санаа бодлыг дагадаг нь эндээс ажиглагдаж байна. Тоон судалгааны үр дүн чанарын судалгааны үр дүнтэй ижил байна.

Зураг 6.4. “Сайн эхнэр, нөхөртэйгээ санал нийлээгүй ч үгийг нь дагадаг” гэсэн ойлголттой санал нийлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, 2017 он (N¹=5144, N²=2175)



*Тайлбар: N¹=5144 – Амьдралдаа хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн тоо
N²=2175 – Амьдралдаа хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тоо*

Олон эмэгтэйчүүд “Гэр бүлд нөхөр нь илүү эрх мэдэлтэй байх ёстой” гэсэн үзэлтэй санал нийлж байна. Энэ үзэл хандлагыг хүлээн зөвшөөрөх байдал нь хөдөө хотын хаана амьдарч байгаагаас хамааран ялгаатай байна (Зураг 6.5). Хөдөө орон нутагт амьдардаг эмэгтэйчүүдийн хувьд хүчирхийлэлд өртсөн эсэхээс үл хамааран ойролцоогоор тал хувь нь үүнтэй санал нийлж байв. Харин хот, суурин газарт амьдардаг эмэгтэйчүүдийн санал нийлэх хандлага бага байгаа ч хүчирхийлэлд өртөж байсан эсэхээс хамаарч ялгаатай байна. Улаанбаатар хотын хувьд хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн 36.8 хувь, хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн 26.0 хувь нь тус тус санал нийлжээ.

Зураг 6.5. “Гэр бүлд нөхөр нь илүү эрх мэдэлтэй байх ёстой” гэсэн ойлголттой санал нийлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, суурьшлаар, 2017 он (N¹=5144, N²=2175)



*Тайлбар: N¹=5144 – Амьдралдаа хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн тоо
N²=2175 – Амьдралдаа хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тоо*

Эмэгтэйчүүдээс тодорхой нөхцөлд хамтрагчтайгаа бэлгийн харьцаанд орохоос татгалзаж болох эсэх талаарх санал бодлыг нь тандсан. Арван эмэгтэй тутмын ес нь дор дурдсан аль ч тохиолдолд бэлгийн харьцаанд орохоос татгалзах нь зөв гэж үзжээ (Хүснэгт 6.1). Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүд эдгээр нөхцлүүдэд бэлгийн харьцаанд орохоос татгалзахыг зөвтгөх нь харьцангуй их байв.

Тухайлбал, хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн 88.4 хувь, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 90.0 хувь нь эхнэр нь хүсэхгүй бол бэлгийн харьцаанд орохоос татгалзах нь зөв гэж хариулжээ.

Хүснэгт 6.1. Тодорхой нөхцөлд бэлгийн харьцаанд орохоос татгалзаж болно гэж үзсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2017 он

Доорх нөхцөлд эхнэр нь бэлгийн харьцаанд орохоос татгалзах эрхтэй	Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэл			
	Хүчирхийлэлд өртөөгүй		Хүчирхийлэлд өртсөн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Эхнэр хүсэхгүй бол	4177	88.4	1980	90.0
Нөхөр нь согтуу бол	4329	89.9	2052	92.1
Эхнэр өвдсөн үед	4387	91.6	2073	93.0
Нөхөр нь эхнэрээ зовоож, дарамталдаг бол	4259	88.5	2031	92.0

Чанарын судалгаа: Гэр бүлийн хүчирхийллийг үүсгэж буй шалтгаан, өдөөгч хүчин зүйлийг Монголын нийгэм дэх эцгийн эрхт ёс гэж нийтлэг байдлаар тайлбарлаж болохоор байна. Гэр бүлийн хүчирхийлэл тэр дундаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан нь “сайн эхнэр” ямар байх ёстой талаарх уламжлалт төсөөлөл, нөхрийн зүгээс эхнэрийн оюун санаа, бие махбод, эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах гэсэн хандлага, давамгайлыг хүчирхийллийн үндсэн шалтгаан гэж үзэж байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын мэргэжилтнүүдийн хийсэн дүгнэлт юм. Мөн эцгийн эрхт ёс, эмэгтэйчүүдийн өрх гэр бүлд эзлэх байр суурь, оролцоо, нөлөө, зан төлөвт гарч байгаа өөрчлөлтүүдийг үл хүлээн зөвшөөрөх хандлага нь гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж байна гэж тэд үзсэн байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: “Бүх юм миний хүссэнээр байх ёстой” гэсэн хүний хэт давруу үзэл, эрх мэдлээ тогтоох гэсэн хандлага, эрх мэдлийн тэнцвэргүй байдал, жендэрийн эрх тэгш бус байдлаас үүдэлтэйгээр хүчирхийлэл үйлдэгдэж байна.

Мэргэжилтнүүдийн ярианаас

Чанарын судалгааны үр дүнгээс харахад гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нь:

- Нөхрийн эцгийн эрхт ёсны хандлага;
- Архидалт, архинаас хамааралт байдал;
- Улс орны нийгэм, эдийн засгийн байдал, эрэгтэйчүүдийн ажилгүйдэл, өрх гэр бүлийн амьжиргааны дорой эмзэг байдал, өр зээл, сургалтын төлбөрийн дарамт зэрэг;
- Эхнэрийн эдийн засгийн хувьд нөхрөөсөө хамааралтай байгаа байдал;
- Үр хүүхдээ бодож, өнчрүүлэхгүй гэсэн үзлээр тэвчих хандлага;
- Үнэнч бус байдал, хэт эрт, хэт богино хугацаанд гэрлэх;
- Дагавар хүүхэдтэйгээр гэрлэх;
- Хосуудын гэр бүлийн суурь хүмүүжил төлөвшил, харилцааны чадвар, бусдыг хүндэтгэх хандлага, уур бухимдлаа зохицуулах, стрессээ зохицуулах, тайлах зэрэг (сэтгэл хөдлөлийн чадвар) чадварууд дутмаг байдал;
- Гэр бүлийн гишүүдийн гэр бүлийн боловсрол, гэр бүлийн хүчирхийлэл гэж юу болох, хуулийн зохицуулалтыг мэдэхгүй байх;
- Хадмуудын зүгээс бэр, хүргэнд тавьдаг шаардлага, хүлээлт, гэр бүл дэх оролцоо, нөлөөлөл, мөн найз нөхөд, хүрээлж буй хүмүүсийн нөлөө, үнэн, худал үг, цуурхал;
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах, туслах, хохирогч хийгээд буруутай этгээдэд зөвлөгөө өгөх

байгууллага, мэргэжлийн үйлчилгээ байхгүй, дутмаг байгаа нь;

- Бэлгийн харилцааны тааламжгүй байдал зэрэг болно.

6.2 ЖЕНДЭР БОЛОН ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ХАНДЛАГА

Нэгдүгээр бүлэгт танилцуулснаар энэхүү судалгааны ажил нь эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийллийн асуудалд чиглэсэн. Тоон судалгааны аргачлал нь зөвхөн эмэгтэйчүүдээс ярилцлага авахад загварчлагдсан бөгөөд эрэгтэйчүүдийн жендэрт суурилсан хүчирхийллийн туршлага, хандлагын талаарх мэдээллийг цуглуулахад тохиромжгүй юм. Харин 15–64 насны 197 эрэгтэйтэй хийсэн гүнзгийрүүлсэн болон фокус бүлгийн ярилцлагаар мэдээлэл цуглуулсан чанарын судалгаа нь эрэгтэйчүүдийн хандлагыг нээн илрүүлэх боломжийг олгож байгаа юм. Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн 7 эрэгтэйтэй ярилцсан бөгөөд тэднийг мэргэжилтнүүдийн оролцоо, туслалцаатайгаар олж, судалгаанд хамруулсан болно. Хүчирхийлэл үйлдэгч 6 эрэгтэйтэй ярилцсан бөгөөд тэдний гурав нь хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд мөн өртдөг байсан.¹⁴

Эрэгтэйчүүдтэй хийсэн фокус бүлгийн болон гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр Долгор гэх эмэгтэйд тохиолдсон хүчирхийллийн тохиолдлын кейс жишээг танилцуулж, үргэлжлүүлэн чиглүүлэх асуултууд асууснаар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх эрэгтэйчүүдийн ойлголт, түүнд хандах хандлагыг тодруулсан юм.

Жишээ кейс:

Долгор нь нөхөр Самбуу, 3 настай хүү ба 5 настай охины хамт амьдардаг. Тэрээр бага сургуулийн 5 дугаар ангийг дүүргэсэн бөгөөд одоогоор гэрийн эзэгтэй. Тэр сүүлийн үед нөхрөө орхиж явахыг боддог болсон. Түүний нөхөр гэр бүлийн хэрэгцээнд бага мөнгө өгдөг атлаа өөрийг нь ажилд орохыг эсэргүүцэн хардаж дургүйцдэг. Заримдаа нөхөр нь согтуу ирж Долгорыг хэл амаар доромжилж, хааяа хүсээгүй байхад нь хүчээр бэлгийн харьцаанд оруулдаг. Долгор нөхөртэйгөө ярилцахыг хэд хэдэн удаа оролдсон боловч үр дүнгүй болсон. Ийм байдалтай 4 жил эвлэрч амьдарсан ч Долгор хэнд ч, юу ч хэлээгүй өнгөрөөдөг байсан. Долгор юу хийхээ мэдэхгүй байна....

Үндэс угсаа, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаанаас үл хамааран дээрх жишээтэй танилцсан бүх эрэгтэйчүүдийн хувьд Долгорыг хардаж, ажилд орохыг дургүйцэх, хэл амаар доромжлох, дургүй үед нь хүчээр бэлгийн харьцаанд орох, зодож, цохих зэрэг үйлдлүүдийг гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүд гэж үзжээ. Харин цөөн тооны эрэгтэйчүүд хамтрагч нь дургүй үед хүчээр бэлгийн харьцаанд орох нь бэлгийн хүчирхийлэл биш гэж үзсэн байна. Жирэмсэн хүнийг зодож, ялангуяа хүнд хэлбэрээр цохиж, зодож болохгүй, ганц нэг алгадах тохиолдол байж болох юм гэж хариулсан. Хамтрагчийн зүгээс хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд ямар арга хэмжээ авах нь зохистой тухай хэлэлцэх үед зарим оролцогчид ганц, хоёр алгадсаны төлөө цагдаа дуудах шаардлагагүй гэж тодотгон үзсэн.

Аль төрлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох, тооцохгүй байх талаар эрэгтэйчүүдийн хандлагыг тодруулахад:

Гэмт хэрэг гэж үзсэн нь:

- Байнга зоддог
- Амь насанд нь аюул учиртал зодох
- Долгорт тохиолдсон бүх үйлдэл хуулийнхаа хувьд гэмт хэрэгт тооцогдоно
- Ажил хийлгэхгүй, гэрээс гаргахгүй байвал

Гэмт хэрэг биш гэж үзсэн нь:

- Нэгэнт гэр бүл болсон бол тэдний харилцаан дахь хүчирхийлэл гэмт хэрэг биш
- Эмэгтэйчүүд өөрсдөө ихэвчлэн хүчирхийллийг өдөөдөг. Иймд гэмт хэрэг биш, цагдаад хандах шаардлагагүй, харин хоорондоо ярилцах хэрэгтэй гэсэн хандлагууд ажиглагдав.

¹⁴ Судалгааны арга зүйн бүлэгт тодорхойлогдсон фокус бүлэгт оролцогчдод тавигдах шаардлагын дагуу оролцогчдыг сонгосон. Нийтдээ 184 эрэгтэйг хамруулсан 33 бүлгийн ярилцлагад хот, хөдөөгийн хөгжлийн бэрхшээлтэй, бэлгийн цөөнхийн төлөөлөл хамрагдсан юм.

Эрэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагууд нь хүчирхийллийн шалтгааныг тодорхойлоход чиглэсэн байсан. Орлогчид Долгорын жишээг Монголын нөхцөлд “нийтлэг” гэж үзсэн ба үүнтэй холбоотой дараах дүгнэлтийг хийж байсан:

- “Жендэрийн тэгш бус байдлаас шалтгаалан нөхөр нь илүү орлого олж байдаг. Тиймээс эхнэрээ үл ойшоон харьцаж байна.”
- “Хүний эрхэд олон төрлөөр халдаж байна.”
- “Хүчирхийлэл далд хэлбэрт орчихоод байна. Ийм байдалтай байлгаж болохгүй.”
- “Гэр бүлээ авч үлдэх, үр хүүхдээ өнчрүүлэхгүйн тулд зодуулсан ч тэвчээд амьдарч байна.”
- “Нөхөр нь эхнэртээ ямар ч хайр халамжгүй, хөндий харьцаж байна. Хэн нэгэн Долгортой ярилцаж, зөвлөгөө өгөх, бодлоо цэгцлэхэд нь туслах хэрэгтэй”

Зорилтот бүлгийн ярилцлага: Гар хүрч, зодох бол гэмт хэрэг гэж үзнэ. Гэхдээ одоо манай нийгэмд түгээмэл байгаа. Гурав, дөрвөн гэр бүлийн нэгэнд нь байдаг асуудал болчихоод байна. Тийм болохоор манайд гэмт хэрэг гэхээсээ илүү гэр бүлд байдаг л нэг харилцаа болоод байна.

15–34 насны эрэгтэй.

Зорилтот бүлгийн ярилцлага: Хуульчийн хувьд ярья. Энэ гэмт хэрэг болчихсон юм алга, гэр бүлд байдаг бүдүүлэгдүү харилцаа байна.

Бусад төрлийн ХБ–тэй эрэгтэй.

Зорилтот бүлгийн ярилцлага: Нэгэнт гэр бүл болоод суучихсан болохоор цэвэр хүчирхийлэл. Гэмт хэрэг бол биш.

Бусад төрлийн ХБ–тэй эрэгтэй

Эрэгтэйчүүдтэй хийгдсэн ярилцлагад бусад чанарын судалгааны ярилцлагатай харьцуулахад хүчирхийлэл үйлдэх болсон шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг тодруулахад түлхүү анхаарсан. Тодруулбал, Долгорын жишээнд дараах дүгнэлтүүдийг хийж байсан.

Эхнэрийн үүргээ биелүүлээгүйгээс хүчирхийлэлд өртсөн байна гэж үзэх тайлбарууд:

- “Долгор өөрөө арчаагүй, нийгэмшээгүй, боловсролгүй хүн. Тэгээд л нөхрийгөө элдвээр хэлж, олж ирсэн мөнгийг нь үл ойшоож байна. Гэр бүлийн хүчирхийлэл гэхээр гол буруутан нь ихэвчлэн эрэгтэйчүүд болдог. Гэтэл эмэгтэйчүүд өөрсдөө зодуулах шалтгааныг бий болгодог ч зодож, цохиж байна гэж нөхрөө цагдаад өгдөг. Нөхөр нь улам хонзогнож үл ойлголцоно. Цагдаад хандахын оронд гэр бүлийн асуудлаа эхнэр, нөхөр хоорондоо ярилцаад ойлголцвол зөрчил үүсэх асуудал гарахгүй байх.”
- “Долгор зовж олсон хэдэн төгрөгийг нь зөв зарцуулдаггүй байж болох юм. Нөхөр нь тал цалингаа өгөөд талыг нь хадгалчихдаг хүн байж болох юм.”

Эхнэр/хамтрагчаа өөрийн бүрэн хяналтад байлгах, харддаг нөхрийн зан үйлтэй холбосон тайлбарууд

- “Самбуу өмнө нь амьдралтай байсан байх. Тэгээд өмнөх шигээ алдах вий гээд Долгорыг гаргахгүй байна.”
- “Долгор их хөөрхөн, тэгээд харамладаг байх.”
- “Долгор хөөрхөн ч жаахан хормой султай учраас ажил хийлгэхгүй байна.”

Эрт гэрлэсэн, сонголтоо буруу хийснээсээ болж хүчирхийлэл үйлдэх, бага боловсролтой эмэгтэйчүүдийг доогуур үнэлсэн тайлбарууд

- “Самбуу нэг удаагийн бэлгийн харилцаанаас болж Долгортой суусан нь буруу сонголт болсон, түүндээ харамсаж, ичдэг байх.”
- “Долгор боловсролгүй, ажил хийж чадахгүйг нь мэддэг.”

Өрхийн тэргүүний харах өнцгөөс авч үзсэн тайлбар

- “Самбуу муу ч гэсэн гэрийн эзэн хүн шүү дээ тэр талаас нь жаахан ойлгох гэж хичээж болохгүй гэж.”

Өрхийн гишүүдийн эдийн засгийн чадамжтай холбосон тайлбар

- “Долгор бага боловсролтой хэдий ч нөхрөөсөө илүү мөнгө олдог учраас нөхөр нь хардах, хаанаас яаж мөнгө олдог нь эргэлзэж, хардах асуудал үүсдэг байх.”

Хосуудын хоорондын хүчирхийллийг гэрлэгсдийн эрх болох талаас авч үзэх тайлбар

- “Хосуудын аль нэг нь хүсэлгүй байх үед бэлгийн харьцаанд орох нь хоёр хүний ойлголцоогүй асуудал болохоос хүчирхийлэл биш.”

Долгорын жишээг хэтрүүлэн хэлэлцсэн, тэр дундаа эмэгтэйчүүдийг буруутгах хандлага ахмад насны эрчүүд болон хөдөө орон нутагт амьдардаг эрэгтэйчүүдэд илүүтэй ажиглагдаж байна. Энэ нь тэдгээр эрчүүдийн гэр бүлийн талаарх уламжлалт ойлголт, хандлагатай шууд холбоотой байж болох юм. Тухайлбал ФБЯ–д оролцсон эрчүүд тэдний хаана амьдарч байгаа болон хэдэн настайгаас үл хамааран “эр хүн бол гэрийн эзэн, ноён нуруу”, “дээр үеэсээ уламжлагдаж ирсэн эцгийн эрхт ёс бий” гэх нэр томъёог илүүтэйгээр хэрэглэж байсан. Орон нутагт хийсэн ФБЯ–ын үеэр хоёр ч оролцогч “гэр бүлийн тухай хууль нь Монголын нийгэмд тохирохгүй” гэсэн хариулт өгсөн нь анхаарал татаж байна. Эрэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагуудаас харахад нийгмийн зүгээс бага боловсролтой эмэгтэйчүүдийг дорд үздэг болох нь харагдаж байна.



БҮЛЭГ 7.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД ХАМТРАГЧИЙН ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨЛӨӨЛӨЛ

Хүчирхийллийн улмаас бэртэж, гэмтсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь ▶ **42.8%**



Маажсан,
шалбалсан,
хөх няц болсон

65.2%



Яс хугарсан,
үйрсэн, цуурсан

20.1%

Толгойн гэмтэл
авсан, тархи
хөдөлсөн

49.4%



Чихний хэнгэрэг
цоорсон, нүд
гэмтсэн

19.8%




Энэ бүлгийн агуулга нь хамтрагчийн зүгээс үйлдэгдсэн аливаа хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн сэтгэл зүй, эрүүл мэндэд хэрхэн нөлөө үзүүлсэн талаарх мэдээллийг нэгтгэн танилцуулахад оршино. Энэ бүлгийн ихэнх хэсэгт хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийг хамтрагчийнхаа зүгээс үйлдсэн бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэхээр нь давхардсан төрлүүдэд ангилан харуулсан үр дүнг авч үзлээ. Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн шинж байдлыг хамтрагчийн үйлдсэн хүчирхийллийн төрлүүдээр харьцуулахдаа дараах дөрвөн бүлэгт хуваасан.

- a) Хамтрагчийн зүгээс бие махбодын эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд (N=4739)
- b) Хамтрагчийн зүгээс бие махбодын эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд (N=4739)
- c) Хамтрагчийн зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд (N=498)
- d) Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүд (N=432)

7.1 БИЕЙН ЕРӨНХИЙ ЭРҮҮЛ МЭНД

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд өөрсдийн эрүүл мэндийн ерөнхий байдлыг муугаас маш сайн хүртэл таван үнэлгээгээр тодорхойлсон. Судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн бараг 10 хүн тутмын нэг нь (9.0 хувь нь) өөрийнхөө эрүүл мэндийн ерөнхий байдлыг маш сайн, гуравны нэг нь (33.4 хувь нь) сайн, 47.7 хувь нь боломжийн гэж тодорхойлсон байна. Ойролцоогоор арван эмэгтэй тутмын нэг буюу 9.3 хувь нь муу, 0.6 хувь нь маш муу гэж тодорхойлжээ.


Зураг 7.1. Эрүүл мэндийн ерөнхий байдлаа үнэлсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2017 он (N=7319)



Тайлбар: N=7319–Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо

Хамтрагчийнхаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн ерөнхий байдал харьцангуй муу байна. Зураг 7.2–т үзүүлснээр хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн таван эмэгтэй тутмын нэг нь (20.6 хувь) өөрсдийн биеийн ерөнхий байдлыг муу, 0.5 хувь нь маш муу гэж тодорхойлсон байхад хамтрагчийн бэлгийн болон бие махбодын хүчирхийллийн аль алинд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн зөвхөн 8.0 хувь нь муу, 0.6 хувь нь маш муу гэж өөрсдийн эрүүл мэндийн ерөнхий байдлаа тодорхойлжээ. Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүд бие махбодын хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдээс илүүтэйгээр өөрсдийн эрүүл мэндийг тааруу гэж тодорхойлсон байна.


Зураг 7.2. Хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал, хамтрагчийнхаа бэлгийн болон/эсвэл биеийн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N=4739, N=2109, N=498, N=432)



Тайлбар: N=4739 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N=2109 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=498 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=432 –Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд зэрэг өртсөн эмэгтэйчүүд

Зураг 7.3–аас харахад хүнд болон маш хүнд өвдөлт хамтрагчийнхаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүдийн дунд илүү байна. Хамтрагчийн бэлгийн болон бие махбодын хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүдийн бараг гуравны нэг нь судалгаа эхлэхээс өмнөх 4 долоо хоногийн хугацаанд хүнд болон маш хүнд хэлбэрийн өвдөлттэй байсан байхад ийм хэлбэрийн хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн зөвхөн 15.3 хувь нь судалгааны өмнөх дөрвөн долоо хоногт хүнд буюу маш хүнд өвдөлттэй байсан байна.

Зураг 7.3. Сүүлийн 4 долоо хоногт хүнд буюу маш хүнд өвдөлттэй байсан хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N=4739, N=2109, N=498, N=432)



Тайлбар: N=4739 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N=2109 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=498 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=432 –Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүд

Чанарын судалгаа: Дотно хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдээс нэг нь ч эрүүл мэндийн байдлаа хэвийн гэж үзээгүй байна. Тэдгээрийн дийлэнх нь толгой өвддөг, зүрхний өвчтэй болсон, даралт ихэсдэг болсон, зарим хэсэг нь хүнд хэлбэгийн ядаргаанд орсон, бөөр өвддөг болсон, ходоодны шархтай болсон, цөөн тохиолдолд татаж унадаг болсон, хөл, гар янгинадаг болсон, элэг, ходоод, савны хавдартай болсон гэж хүчирхийллийн улмаас эрүүл мэндийн байдалд гарсан өөрчлөлтөө тодорхойлжээ.

7.2 АМИА ХОРЛОХ ТУХАЙ БОДОХ, ОРОЛДЛОГО ХИЙХ

“Танд хэзээ нэгэн цагт амиа хорлох тухай бодол төрж байсан уу” гэсэн асуултад хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 20.5 хувь нь, бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 35.5 хувь нь, бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүдийн 36.5 хувь нь “Тийм” гэж хариулсан байгаа нь хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдтэй (6.5 хувь) харьцуулахад харьцангуй өндөр байна (Зураг 7.4).

Зураг 7.4. Амиа хорлох бодол төрж байсан, амиа хорлох оролдлого хийсэн, амиа хорлох оролдлого хийснийхээ дараа эмнэлгийн тусламж авч байсан хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N=4739, N=2109, N=498, N=432)



Тайлбар: N1=4739 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N2=2109 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N3=498 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N4=432 –Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд зэрэг өртсөн эмэгтэйчүүд

Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүд хамгийн ихээр (10.0 хувь) амиа хорлох оролдлого хийж байсан байхад хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн 1.2 хувь нь амиа хорлох оролдлого хийж байсан байна.

Чанарын судалгааны тайланд дурдсанаар хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд ирээдүйгээ бодохоор сэтгэл хямардаг, мөн сэтгэл санаагаар унамтгай болсон гэж хариулсны зэрэгцээ зарим тохиолдолд хүчирхийллийн дараа бие өвдөж, зовж шаналж байгаагаа мэдэрч, гуньж гутрах үедээ “амиа хорлоё” гэж бодох, “үхмээр” санагдах үе гарч байснаа бидэнтэй хуваалцсан юм. Өөртөө итгэх итгэлгүй болсноор ирээдүйгээ төсөөлөх, бодох мэдрэмжээ алддаг болохыг судалгаанд оролцогчдын хариулт харуулж байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Мөрөөдөлдөө хөтлөгдөөд зорилготой амьдаръя гэж хүссэн ч ямар ч мөрөөдөлгүй болж байгаагаа мэдэрдэг.

15–34 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Залуу эмэгтэйчүүд ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд илүү ихээр амиа хорлох хүсэлтэй болдог байна (Хүснэгт 7.1). Хамтрагчийнхаа бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртөөгүй 25–34 насны эмэгтэйчүүдийн 7.0 хувьд нь амиа хорлох бодол төрж байсан байхад амьдралынхаа туршид хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн 25–34 насны таван эмэгтэй тутмын хоёрт (39.8 хувь) нь амиа хорлох бодол төрж байсан байна.

Хүснэгт 7.1. Амиа хорлох бодол төрж байсан хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийнхаа бэлгийн болон/эсвэл бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, насны ангиллаар, хувиар, 2017 (N=4739, N=2109, N=498, N=432)

Насны бүлгээр	Хүчирхийлэлд өртөөгүй	Хүчирхийлэлд өртсөн		
		Бие махбодын	Бэлгийн	Бие махбодын болон бэлгийн
15–24	15.3	35.3	*	*
25–34	7.0	24.5	38.9	39.8
35–44	4.3	19.1	28.8	30.6
45–54	1.8	14.1	30.6	31.4
55–64	3.3	7.9	20.2	20.1

Тайлбар: N=4739 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N=2109 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=498 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=432 –Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүд

* Ажиглалтын тоо хэт цөөн (хариултын тоо 20-оос бага) тул нарийвчлалтай тооцоо хийх боломжгүй.

7.3 ЭРҮҮЛ МЭНДИЙН САНАА ЗОВООСОН БУСАД АСУУДЛУУД

Хамтрагчтай байсан эсвэл байгаа эмэгтэйчүүдийн хувьд сүүлийн сард биеийн эрүүл мэндийн байдалтай нь холбоотойгоор санаа зовоосон асуудал хэр их гарч байсан болохыг асуусан. Биеийн эрүүл мэндийн байдалтай нь холбоотой санаа зовоосон асуудлууд гэдэгт толгой өвдөх, нойр муудах, хоолны дуршилгүй болох, сэтгэл түгших, хоолны шингэц муудах, аз жаргалгүй санагдах, их уйлах, үнэ цэнэгүй хүн болсон мэт санагдах, амиа хорлох тухай бодох, байнга ядрах мэдрэмж төрөх, сэтгэл санаа зовнисноос болж гэдэс эвгүйрхэх мэдрэмж төрөх, амархан ядардаг болох гэсэн 20 төрлийн зовиурыг оруулсан болно. Эдгээр шинж тэмдгүүдийг ашиглан биеийн байдалтай холбоотой санаа зовоосон асуудлыг нийт 20 оноогоор үнэлж тооцсон.

Сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэхдээ сэтгэлийн хямралын шинж тэмдэгийн талаарх тухайлбал “Таны гар чинь салганаж, чичирдэг байсан уу?”, “Та өөрийгөө ямар ч үнэ цэнэгүй хүн шиг мэдэрч байсан уу?” гэх мэт 20 багц асуулт бүхий “Тийм”, “Үгүй” гэсэн хариулт авах “Өөрийгөө тодорхойлох асуулга (SRQ-20)” гэсэн ДЭМБ-аас гаргасан стандарт арга зүйг ашигласан. 20 асуултын “Тийм” гэсэн хариултуудад 1 оноо, “Үгүй” гэсэн хариултуудад 0 оноо өгч дүгнэх ба хамгийн ихдээ (SRQ) 20 оноо авна. Өндөр оноотой бол сэтгэцийн болон биеийн эрүүл мэнд муу байгааг илэрхийлэх үзүүлэлт болно.

Хамтрагчийнхаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү өндөр оноотой байна (Зураг 7.5). Тухайлбал хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн 1.7 хувь нь 16–20 оноотой байхад бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүдийн 13.7 хувь нь 16–20 оноотой байна. Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 6.2 хувь нь өндөр оноотой байхад хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 11.9 хувь нь өндөр оноотой (16–20) байгаа нь сэтгэцийн эрүүл мэндийн хямралын шинж тэмдэг, бэлгийн хүчирхийллийн хооронд мэдэгдэхүйц уялдаа байдгыг харуулж байна.

Зураг 7.5. Хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн биеийн байдалтай нь холбоотой сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын тархалт, бэлгийн болон биеийн хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=4739, N=2109, N=498, N=432)




Тайлбар: N=4739 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N=2109 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=498 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=432 –Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүд

ЭМНЭЛЭГТ ХЭВТСЭН БА МЭС АЖИЛБАР ХИЙЛГЭСЭН БАЙДАЛ

Хамтрагчтай байсан/ байгаа эмэгтэйчүүдийн өнгөрсөн 12 сарын хугацаанд эмнэлэгт хэвтсэн болон мэс засалд орсон байдлыг сүүлийн 12 сарын хугацаанд хүчирхийлэлд өртсөн эсэхээр нь авч үзвэл эмэгтэйчүүдийн эмнэлэгт хэвтсэн байдал хүчирхийлэлд өртсөн эсэхээс үл хамааран ойролцоо үр дүнтэй байна. Харин сүүлийн 12 сарын хугацаанд бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 10.1 хувь нь мэс засалд (кесаров хагалгааг оруулаагүй) орсон байгаа нь хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдээс гурван пунктээр өндөр байна.

Зураг 7.6. Сүүлийн 12 сард мэс засалд орсон болон эмнэлэгт хэвтсэн хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, сүүлийн 12 сард бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N=4739, N=2109, N=498, N=432)




Тайлбар: N=4739 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N=2109 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=498 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=432 –Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүд

7.4 ЭМИЙН ХЭРЭГЛЭЭ

Дотно хамтрагчтай эмэгтэйчүүдийн сүүлийн 1 сарын хугацаанд эм уусан байдлыг хүчирхийлэлд өртсөн эсэхээр нь задалж харвал бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд эм илүүтэй хэрэглэдэг болохыг доорх зураг харуулж байна. Өвчин намдаах эм хэрэглэсэн тохиолдлыг авч үзвэл бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн 19.0 хувь нь хэрэглэсэн байхад бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 33.9 хувь нь өвчин намдаах эм хэрэглэсэн байна. Мөн тайвшрах, унтах зорилгоор эм хэрэглэх хандлага нь хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувьд харьцангуй өндөр байна.

Зураг 7.7. Сүүлийн сард эм хэрэглэсэн хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, эмийн төрлөөр, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=4739, N=2109, N=498, N=432)




Тайлбар: N=4739 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N=2109 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=498 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=432 –Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүд

7.5 АРХИ, ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ харьцангуй бага түвшинд байгаа ба цөөн тооны эмэгтэйчүүд согтууруулах ундааг тогтмол хэрэглэж байна (Зураг 7.8). Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн тэн хагас нь (49.6 хувь) согтууруулах ундаа огт хэрэглэдэггүй байхад хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 35.8 хувь нь согтууруулах ундаа огт хэрэглэдэггүй байна. Архи, согтууруулах ундаа хэрэглэдэг эмэгтэйчүүдийн дийлэнх нь ховорхон буюу онцгой тохиолдолд хэрэглэдэг гэж хариулсан байв.


Зураг 7.8. Согтууруулах ундаа хэрэглэдэг хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хэрэглээний давтамжаар, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=4739, N=2109, N=498, N=432)



Тайлбар: N=4739 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N=2109 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=498 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=432 –Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүд

Хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн дунд тамхи хэрэглэх хандлага мөн адил бага байгаа хэдий ч хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд болон хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн хооронд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байна. Тодруулбал хүчирхийлэлд өртөөгүй 10 эмэгтэй тутмын нэг хүрэхгүй хувь нь (7.9 хувь) одоогоор тамхи татаж байхад хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүдийн 24.2 хувь нь тамхи татаж байна. Мөн хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд (23.4 хувь) хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг (16.1 хувь) бодвол илүү их тамхи татдаг байна.

Зураг 7.9. Тамхи хэрэглэдэг хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хэрэглээний давтамжаар, бэлгийн болон/эсвэл бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=4739, N=2109, N=498, N=432)




Тайлбар: N=4739 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N=2109 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=498 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N=432 –Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүд

7.6 БЭРТЭЛ, ГЭМТЭЛ

Хамтрагчийнхаа бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 42.8 хувь нь ямар нэгэн байдлаар бэртэл, гэмтэл авсан байна (Зураг 7.10). Бэртэл гэмтэл гэдэгт хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөний улмаас биед учирсан хохирлыг буюу зүсэх, маажих, шалбалах, хөх няц болох, булчин шөрмөс сунах, тасрах, үе мултрах, түлэгдэх, яс хугарах, шүд унах/хугалах, чихний хэнгэрэг цоорох, дотуур цус алдалт, толгойн гэмтэл зэргийг оруулсан.


Зураг 7.10. Хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртсөний улмаас бэртэл, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2017 он (N=2174)



Тайлбар: N=2174– Хамтрагчийн үйлдсэн бэлгийн болон/эсвэл бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд

Бэртэл, гэмтэл авсан давтамжаар нь харвал, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн гурван эмэгтэй тутмын нэг буюу 32.1 хувь нь нэг удаа, таван эмэгтэй тутмын хоёр буюу 41.6 хувь нь 2–5 удаа, 26.3 хувь нь буюу дөрвөн эмэгтэй тутмын нэг нь 5–аас олон удаа хүчирхийллийн улмаас бэртэл, гэмтэл авсан байна.

Зураг 7.11. Хамтрагчийнхаа бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн гэмтэл авсан давтамжийн хувь, 2017 (N=911)



Тайлбар: N=911– Хамтрагчийн үйлдсэн бэлгийн болон/эсвэл бие махбодын хүчирхийлэлд өртөж, гэмтэл авсан эмэгтэйчүүд

Бэртэл, гэмтэл авсан эмэгтэйчүүдийг бэртэл, гэмтлийнх нь төрлөөр доорх зурагт харууллаа (Зураг 7.12). Эндээс харахад, гэмтэл бэртэл авсан эмэгтэйчүүдийн гуравны хоёр (65.2 хувь нь) хамгийн түгээмэл бэртэл, гэмтэл болох маажуулсан, шалбалсан, хөх няц болгосон гэмтэлийг авсан байна. Түүний дараагийн түгээмэл тохиолдож байгаа гэмтэл бэртэл бол толгойн болон тархи хөдөлсөн гэмтэл (49.4 хувь нь) байна. Харин бэртэл, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн 5.0 хувь нь шүд хугарсан, унасан, үйрсэн гэмтэл, 2.5 хувь нь түлсэн гэмтэлд өртсөн байгаа нь гэмтлийн төрлүүд дотор хамгийн бага хувийн жин эзэлж байна.

Зураг 7.12. Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь, гэмтлийн төрлөөр, 2017 (N=911)



Тайлбар: N=911 – Хамтрагчийн үйлдсэн бэлгийн болон/эсвэл бие махбодын хүчирхийлэлд өртөж, гэмтэл авсан эмэгтэйчүүд

Чанарын судалгаа: Дотно хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн бүх эмэгтэйчүүд хүчирхийллийн улмаас ямар нэгэн хэлбэрээр гэмтсэн. Тэдгээр эмэгтэйчүүд нүүр, нүд, биендээ хөхөрсөн буюу “цус хурах” хэлбэрийн гэмтэл авч байжээ. Мөн бараг бүх эмэгтэйчүүд толгой руугаа цохиулж “толгой, тархи өвддөг” болсон хэмээн ярьжээ.


Гүнзгийрүүлсэн ярилцлага: Уураа хүрэхээр зодож, нүүр хөх болгосон. Хүнээс нуух гэлээ ч нүднээ ил байгаа юм чинь. ... Нэг их аймаар зодоогүй, бие, нүүрийг жаахан хөхрүүлсэн байсан. ... Хүний нүднээс далд газрууд руу, гар, хөл, бие рүү цохьдог, хөх эрэн болдог. ... Орондоо орохоор гар, биеийг чимхэж хөх болгодог.

Хэд, хэдэн эмэгтэй

Хамтрагчаас учруулсан бэртэл, гэмтлийн хүндрэлийн зэргийг доорх зургаар харуулж байна. Зүссэн, хазсан, хатгасан болон маажсан, шалбалсан, хөх няц болгосон гэмтлийн зэргийг хөнгөн, булчин шөрмөс сунгасан, үе мулталсан болон түлсэн гэмтлийн зэргийг хүндэвтэр буюу дунд зэрэг, хүнд бэртэл гэмтэл, гүн зүсэлт, гүн шарх, чихний хэнгэрэг цоорсон, нүд гэмтсэн, яс хугарсан, үйрсэн, цуурсан, шүд хугарсан, унасан, үйрсэн, дотуур гэмтэл, толгойн гэмтэл, тархи хөдөлснийг хүнд хэлбэрийн гэмтлийн зэрэг гэж авч үзсэн болно.

Хамтрагчийнхаа бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртөж бэртэл, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн 21.0 хувь нь хөнгөн хэлбэрийн гэмтэл, 5.0 хувь нь хүндэвтэр буюу дунд зэргийн гэмтэл авсан байхад, 71.6 хувь нь буюу арван эмэгтэй тутмын долоо нь хүнд хэлбэрийн буюу ноцтой бэртэл, гэмтэл авсан байна.

Зураг 7.13. Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь, гэмтлийн хүндрэлийн зэргээр, 2017 (N=911)



Тайлбар: N=911 – Хамтрагчийн үйлдсэн бэлгийн болон/эсвэл бие махбодын хүчирхийлэлд өртөж, гэмтэл авсан эмэгтэйчүүд

Чанарын судалгаа: Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцсон ойр дотны хамтрагчийн хүчирхийлэлд өртдөг арван эмэгтэй тутмын дөрөв нь хүчирхийллийн улмаас хүнд хэлбэрийн гэмтэл авсан байна. Тодруулбал, гар хуруу, хөл, хавирга хугалах, хамраа чихүүлэх, толгойг нь хагалах, жирэмсэн байхад нь зодож, үр зулбуулсан, хэвтэрт орж олон хоногийн хугацаанд хэвтэж эмчлүүлэхэд хүрсэн, хөгжлийн бэрхшээлтэй болж, хөдөлмөр эрхлэх чадвараа алдсан зэргээр хүнд хэлбэрээр гэмтсэн байна. Ямар төрлийн гэмтлийг хүнд гэж ангилах вэ гэдгээс шалтгаалан зөрүүтэй үр дүн гарч байгаа хэдий ч эмэгтэйчүүдийн авсан гэмтэл ноцтой түвшинд үйлдэгдэж байгааг доорх жишээ харуулж байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50 хувиар алдсан. Ямар ч эмчилгээгүй, хоёр нүдний арын ухархай хугаралтай, нэг нүдний ухархай том хэмжээний, нэг нь жижиг хэмжээний хугаралтай, баруун нүдний торлог бүрхэвч цуурсан, зүүн нүдний хараа 20 хувь болж, групп тогтоолгосон.

ХБ-тэй эмэгтэй


Гүнзгийрүүлсэн ярилцлага: Мэс заслын тасагт хэвтээд нүүр, толгойндоо оёдол тавиулж байсан. Эмч нар “тун удахгүй чамд оёдол тавих газаргүй болох нь” гэж хэлж байсан. Хутга, сэрээ гээд гарт таарсан юу л байна хамаагүй түүгээрээ намайг гэмтээдэг байсан. Нэг том сэрээ байсныг аваад шууд хөл рүү, гар луу зоогоод цус гоожиж байхад хамар луу өшиглөсөн. Шүд хугартал цохисон. “Чи намайг алах юм байна, би эндээс амьд гаръя” гэхээр улам бүр зодсон. Тэгэхэд нь би юу ч дуугаралгүй ухаан алдсан хүн шиг хөдөлгөөнгүй дээшээ хараад хэвтсэн чинь дээрээс 10 литр хүйтэн ус асгасан. Одоо би элэг, ходоод, савны хавдартай болсон.

35–64 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас Women aged 35–64

Бэртэл гэмтэл авсан эмэгтэйчүүдээс эмнэлгийн тусламж шаардлагатай болох хэмжээний бэртэл, гэмтэл авсан эсэхийг тодруулахад, 58.1 хувь нь шаардлагагүй байсан гэж, 27.1 хувь нь 1 удаа шаардлагатай болсон, 11.1 хувь нь 2–5 удаа шаардлагатай байсан гэж, 3.7 хувь нь 5 ба түүнээс олон удаа эмнэлгийн тусламж авах шаардлагатай болсон гэж хариулсан байна (Зураг 7.14).

Бэртэл, гэмтэл авсны улмаас эмнэлгийн тусламж шаардлагатай эмэгтэйчүүдийн 28.8 хувь нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ огт авч байгаагүй, 63.5 хувь нь заримдаа авч байсан, 7.7 хувь нь эрүүл мэндийн тусламж байнга авч байжээ.


Зураг 7.14. Хамтрагчийн бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж, гэмтсэн эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусламж авсан тохиолдол, 2017



Тайлбар: N¹=911–Хамтрагчийн үйлдсэн бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртөж, гэмтэл авсан эмэгтэйчүүд, N²=415–Хамтрагчийн хүчирхийллийн улмаас эмнэлгийн тусламж авах хэмжээний бэртэл, гэмтэл авсан эмэгтэйчүүд

Гэмтэл авч, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан эмэгтэйчүүдийн тэн хагасаас бага хувь нь (43.2 хувь нь) эмнэлгийн ажилтанд өөрийн бэртэл, гэмтлийн жинхэнэ шалтгаанаа хэлсэн байна.

Зураг 7.15. Хамтрагчийнхаа хүчирхийллийн улмаас гэмтэл авч, эмнэлгийн тусламж авсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өөрийн бэртэл, гэмтлийн жинхэнэ шалтгаанаа эмнэлгийн ажилтанд хэлсэн эсэхээр, 2017 он (N=288)



Тайлбар: N=288– Хамтрагчийн хүчирхийллийн улмаас бэртэл, гэмтэл авч, эмнэлэгт хандсан эмэгтэйчүүд

7.7 НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД

Сүүлийн 5 жилийн хугацаанд жирэмсэлсэн хамтрагчтай байсан/ эсвэл байгаа эмэгтэйчүүдээс хамгийн сүүлд төрүүлсэн хүүхдээ олохдоо хүсэж байсан хүүхэд нь мөн эсэхийг тодруулж асуусан. Зураг 7.16–д үзүүлсэнчлэн хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртдөггүй эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд өртдөг эмэгтэйчүүдтэй харьцуулахад хүүхдээ хүсэж төрүүлсэн байх тохиолдол харьцангуй өндөр харагдаж байна. Энэ нь эмэгтэйчүүдийн өөрийнхөө нөхөн үржихүйн эрүүл мэндэд сонголт хийх боломж хэр байдгыг харуулах нэг үзүүлэлт болж болох юм.

Сүүлийн таван жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн бөгөөд хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүдийн 15.0 хувь нь хамгийн сүүлийн хүүхдээ төрүүлэхдээ хойшлуулахыг илүүд үзэж байсан бол 12.3 хувь нь дахин хүүхэд төрүүлэхийг хүсээгүй байжээ. Харин хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн 7.1 хувь нь төрөлтөө хойшлуулах бодолтой байсан бол 2.4 хувь нь тухайн үед хүүхэд төрүүлэх хүсэлгүй байсан байна.


Зураг 7.16. Сүүлийн 5 жилд жирэмсэлсэн хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамгийн сүүлийн хүүхдээ төрүүлэхдээ хүсч байсан эсэхээр, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он (N=1717)



Тайлбар: Судалгаанд хамрагдсан сүүлийн 5 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд: N1=1125 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N2=572 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N3=120 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N4=106 –Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүд

Хамгийн сүүлийн хүүхдээ тээж байхдаа согтууруулах ундаа хэрэглэж байсан тохиолдлыг хамтрагчийнхаа бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр нь задалж харвал, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ өндөр байна. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 11.1 хувь нь хүүхдээ тээж байхдаа согтууруулах ундаа хэрэглэсэн байгаа нь хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдтэй (2.5%) харьцуулахад 4 дахин өндөр байна.


Зураг 7.17. Сүүлийн 5 жилийн хугацаанд жирэмсэн байхдаа согтууруулах ундаа хэрэглэж байсан хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N 1717)



Тайлбар: Судалгаанд хамрагдсан сүүлийн 5 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд: N1=1125 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N2=572 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N3=120 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N4=106 –Хамтрагчийнхаа бие махбодын болон/эсвэлбэлгийн хүчирхийллийн аль алинд өртсөн эмэгтэйчүүд

Жирэмсэлж байсан, хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүд, хамтрагчийн хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийг бодвол үр хөндүүлэх тохиолдол элбэг байна (Зураг 7.18). Хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд зэрэг өртсөн эмэгтэйчүүдийн тал хувь нь (50.8 хувь) амьдралдаа үр хөндүүлж байсан бол хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн 29.5 хувь нь үр хөндүүлж байжээ.

Зураг 7.18. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн асуудал, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=6621)




Тайлбар: Судалгаанд хамрагдсан, хамтрагчтай, жирэмсэлж байсан эмэгтэйчүүд: N1=4479 –Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүд, N2=2077 –Хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N3=487 –Хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, N4=424 –Хамтрагчийнхаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийллийн аль алиндзэрэг өртсөн эмэгтэйчүүд

Чанарын судалгааны дүн энэхүү дүгнэлтийг бататгаж байна. Тодруулбал, жирэмсэн үедээ хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд цөөн бус байсан бөгөөд зодуулсны улмаас нэлээдгүй эмэгтэйчүүдийн ураг зулбаж байжээ. Мөн жирэмсэлтээс сэргийлэх эм хэрэгсэл хэрэглэдэггүй, гэр бүл төлөвлөлтийн мэдлэггүйн улмаас жирэмсэлж, хүчирхийлэл, дарамтын улмаас үр хөндөлтөд орохоос аргагүйд хүрсэн тохиолдол судалгааны явцад хэд хэд таарсан гэж тайланд дурьджээ.

Сүүлийн 5 жилийн дотор хүүхэд төрүүлсэн, хамтрагчтай байсан/ байгаа эмэгтэйчүүдийг хамгийн сүүлийн хүүхдээ төрүүлэхэд хамтрагчийн зүгээс ямар хүйсийн хүүхэд байгаад анхаарал хандуулж байсан эсэхийг доорх зурагт харууллаа. Хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн хамтрагчдын 33.1 хувь нь хамгийн сүүлийн хүүхдээ төрүүлэхэд хүү хүсч байсан гэсэн бол бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртөж байсан эмэгтэйчүүдийн хувьд хамтрагчдынх нь 42.1 хувь нь хүү хүсч байсан, 23.1 хувь нь охин хүсч байсан гэж хариулсан байгаа нь хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн хамтрагчдын хариултаас 5–9 пунктээр өндөр үзүүлэлт болж байна (Зураг 7.19). Хүчирхийлэл үйлддэггүй хамтрагчдын бараг тал хувьд (48.7 хувь) нь хамгийн сүүлд төрсөн хүүхдийн хүйс ямар байх нь хамаагүй байсан гэж хариулжээ. Эндээс харахад хүчирхийлэл үйлддэг хамтрагчид илүү их өөрийн хүссэн хүйсийн хүүхэдтэй болох сонирхолтой байдаг гэж дүгнэж болохоор байна.


Зураг 7.19. Сүүлийн 5 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн хамгийн сүүлийн хүүхдийн хүйс, хамтрагчийн хүссэнээр, хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 (N=1717)



Тайлбар: N=1717–Сүүлийн 5 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн тоо

Амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн талаас илүү хувь (54.5 хувь) нь одоогоор жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэж байна. Харин хамтрагчийнхаа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн аль алинд өртдөг эмэгтэйчүүдийн 44.0 хувь нь одоогоор жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийг хэрэглэж байна. Хамтрагчийнхаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хамтрагч нь жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглэхийг нь зогсоохыг оролддог эсвэл бэлгэвч хэрэглэхээс татгалздаг гэж хариулсан байгаа нь хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр байна.

Зураг 7.20. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэдэг болон хамтрагч нь жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглэхийг нь хориглодог хамтрагчтай байсан/эсвэл байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийлэлд өртсөн эсэхээр, 2017 он



Тайлбар: Хамтрагч нь бэлгэвч хэрэглэхээс татгалзаж байсан: Хүчирхийлэлд өртөөгүй (N¹=4000); Бие махбодын хүчирхийлэл (N²=1801); Бэлгийн хүчирхийлэл (N³=411); Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл (N⁴=357); Хамтрагч нь жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслэлийг зогсоохыг оролдсон: Хүчирхийлэлд өртөөгүй (N⁵=3781); Бие махбодын хүчирхийлэл (N⁶=1720); Бэлгийн хүчирхийлэл (N⁷=396); Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл (N⁸=342); Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэдэг: Хүчирхийлэлд өртөөгүй (N⁹=2726); Бие махбодын хүчирхийлэл (N¹⁰=1410); Бэлгийн хүчирхийлэл (N¹¹=339); Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл (N¹²=298)




БҮЛЭГ 8.

ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд ӨРТСӨН эмэгтэйн 6–12 насны хүүхдүүд



Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд ӨРТӨӨГҮЙ эмэгтэйн 6–12 насны хүүхдүүд



Энэ бүлэгт хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл хүүхдэд хэрхэн нөлөөлж буйг тодруулж судалсан. Хүүхэд насандаа гэр бүлийн орчинд хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлийг харах болон өөрийн биеэр мэдрэх нь уг хүчирхийллийг энгийн мэт хүлээж авах хандлагыг хүүхдэд бий болгодог.

Тоон судалгаа хүүхдүүдээс шууд мэдээлэл цуглуулахгүй харин хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртөж байсан болон байгаагүй 6–12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдтэй хүүхдүүдийнх нь ерөнхий зан байдал, сурлагын талаар ярилцан ялгааг гаргасан болно.


Үе дамжсан хүчирхийллийн хэв шинжийг тодорхойлохын тулд хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд болон тэдний эрэгтэй хамтрагчид хүчирхийлэлтэй гэр бүлд өссөн эсэхийг мөн судалсан.

8.1 ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХҮҮХДИЙН ЗАН БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Хамтрагчтай байсан/эсвэл байгаа нийт эмэгтэйчүүдийн 80.8 хувь нь наад зах нь нэг хүүхэдтэй байсан бөгөөд судалгааг авах үед эдгээр эмэгтэйчүүдийн 40.1 хувь нь 6–12 насны хүүхэдтэй байв. Бага насны буюу 6–12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдээс хүүхдийнх нь зан байдалын талаар хэд хэдэн асуулт асуух замаар хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн хүүхдийн зан байдлыг хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн хүүхдийн зан байдалтай харьцуулан үзсэн. Харьцуулалтын үр дүн бидэнд хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл болон хүүхдийн зан байдлын хоорондын уялдаа холбоотой болохыг харуулсан.

Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн хүүхдүүд (47.1 хувь) хамтрагчийн хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн хүүхдүүдтэй (29.5 хувь) харьцуулахад аймхай, зожиг зан ааштай байна. Хүчирхийлэлтэй гэр бүлд өсч байгаа хүүхдүүд илүү түрэмгий зан ааштай (43.0 ба 27.5 хувь), хар дарж зүүдэлдэг (23.7 хувь ба 14.2 хувь) ба энэ нь хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл хүүхдийн зан байдалд сөрөг нөлөөтэй болохыг харуулж байна.

Зураг 8.1. Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн, өртөөгүй 6–12 настай хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хүүхдүүдийнхээ зан байдалд хийсэн ажиглалт, 2017 он (N=1595), (N=985)



Тайлбар: N=1595–Судалгаанд хамрагдсан хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөөгүй, 6–12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн тоо, N=985–Судалгаанд хамрагдсан хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн, 6–12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн тоо

Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл болон хүүхдийн зан байдлын хоорондын хамаарал өндөр байна. Орондоо шээх зан байдлын хувьд (0.05–аас их) ялгаа байхгүй байгаа боловч аймхай, түрэмгий эсвэл хар дарж зүүдэлдэг зэрэг бусад зан байдлын хувьд 0.05–аас бага байгаа нь ээжийнх нь эсрэг үйлдэгдсэн хамтрагчийн хүчирхийлэл болон хүүхдийн зан

байдал, эрүүл мэндийн хооронд хамаарал байгааг харуулж байна (Хавсралт 4–ын Хүснэгт 19). Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэл нь хүүхдийн зан ааш, сэтгэл санаанд хэрхэн нөлөөлж байгааг чанарын судалгааны гүнзгийрүүлсэн ярилцлагын хэсгээс харж болно.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Хүү бага учраас мэдэгдэхгүй байна. Гэхдээ хааяа ингэж байхаар үхчихмээр санагддаг гэж хэлдэг. Охин өсвөр насан дээрээ байгаа. Ааш зан нь өөрчлөгдөж хурц болж байгаа. Би охиндоо ингэж болохгүй гэж захидаг. Охин минь ийм амьдралд тайван байж чадахгүй байна гэж хэлсэн. Мэдээж хүүхдүүдэд хэцүү байгаа.


25–39 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Хүүхдүүдийн сэтгэл санаанд маш их нөлөөлж байгаа. Манай хоёр охин их бүрэг. Би эрэгтэй хүүхдүүдийг харахаар уур хүрдэг гэж хэлдэг.

25–39 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гэр бүлийн орчинд хүчирхийлэл байгаа айлын хүүхдүүд анги улирах сургууль, завсардах нь бие махбод болон бэлгийн хүчирхийлэлд өртдөггүй ээжийн хүүхдүүдээс илүү өндөр байна. (Зураг 8.2).


Зураг 8.2. Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн, өртөөгүй анги улирсан болон сургууль завсардсан нэг болон түүнээс дээш хүүхэдтэй (6–12 насны) эмэгтэйчүүдийн хувь, 2017 он (N=1595), (N=985)



Тайлбар: N=1595–Судалгаанд хамрагдсан хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөөгүй, 6–12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн тоо, N=985–Судалгаанд хамрагдсан хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн, 6–12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн тоо

Хүүхдүүд хүчирхийлэлд өртөх, хүчирхийлэлтэй гэр бүлд өсөх зэрэг олон шалтгааны улмаас гэрээсээ зугтдаг байна. Манай судалгааны хувьд, гэрээсээ дайжсан цөөхөн хүүхэд байсан ба эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөж байгаа гэр бүлийн хүүхдүүд гэрээсээ дайжих, зугтах нь хүчирхийлэлгүй гэр бүлийн хүүхдүүдээс их байх хандлагтайг харуулж байна (Зураг 8.3).

Зураг 8.3 Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн, өртөөгүй, хүүхдүүд нь (6–12 насны) гэрээсээ зугтсан эмэгтэйчүүдийн хувь 2017 он (N=1595), (N=985)




Тайлбар: N=1595–Судалгаанд хамрагдсан хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөөгүй, 6–12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн тоо, N=985–Судалгаанд хамрагдсан хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн, 6–12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн тоо

8.2 ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭЖ БУЙГ ХАРЖ, СОНССОН ХҮҮХДҮҮД

Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодийн хүчирхийлэлд байдаг эмэгтэйчүүдээс хүүхдүүд нь хүчирхийллийг харж, сонсож байсан эсэх харж, сонсож байсан бол хэдэн удаа харсан, сонссон талаар асуусан.

Судалгаанаас харахад, хүүхэдтэйгээ амьдардаг бие махбодын хүчирхийлэлд өртсөн нийт эмэгтэйчүүдийн олонх буюу 91.6 хувь нь хүүхдүүд хүчирхийллийг харж, сонсож байгаагүй гэжээ. Харин 8.4 хувь нь хүүхдүүд ээжийгээ бие махбодын хүчирхийлэлд өртөж буйг 1.4 хувь нь нэг удаа, 3.1 хувь нь 2–5 удаа, 3.9 хувь нь 5–аас олон удаа харсан гэж хэлсэн байна.

Зураг 8.4 Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хүүхдүүд нь ээжийгээ хүчирхийлэлд өртөж буйг харсан, сонссон (хэдэн удаа) гэж мэдүүлсэн эмэгтэйчүүдийн хувь 2017 он (N=2043)




Тайлбар: N=2043 – Судалгаанд хамрагдсан хамтрагчийн зүгээс хүчирхийлэлд өртсөн 6–12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн тоо

Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувьд “Хүүхдүүд нь хүчирхийллийг харсан” гэж Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн харьцангуй их буюу 12.7 хувь нь, хөдөө, орон нутгийн эмэгтэйчүүд 4.7 хувь нь хариулжээ. Эхчүүд хүүхэддээ хүчирхийллийг харуулахыг хүсдэггүй боловч хүүхдүүд нь харж, сонсож байгааг мэдэлгүй өнгөрөх тохиолдол байдаг.

8.3 ҮЕ ДАМЖСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн гурван эмэгтэй тутмын нэгнийх нь (32.4 хувь) хамтрагч бага байхдаа цохиулж, зодуулж байсан бол хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн хамтрагчийн 16.3 хувь нь бага байхдаа цохиулж, зодуулж байсан байна (Зураг 8.5). Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн ээж нь нөхөртөө цохиулж, зодуулж байсан нь эдгээр эмэгтэйчүүд өөрсдөө хамтрагчийн хүчирхийлэлд өртөх магадлалтай болохыг нийт хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн дөрвөн эмэгтэй тутмын нэгнийх нь (22.2 хувь) ээж хамтрагчийн хүчирхийлэлд өртөж байсан бол хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн 12.6 хувийнх нь ээж хамтрагчийн хүчирхийлэлд өртөж байснаас харж болно. Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хамтрагчийн ээж нь нөхөртөө зодуулдаг байсан хувь хэмжээ нилээдгүй өндөр буюу 17.3 хувь байсан бол хэдийгээр нь ээж нь зодуулдаг байсан ч өөрөө хамтрагчаа хүчирхийлдэггүй эрчүүдийн хувь 3.4 байна. Үүнээс үзэхэд бага насандаа хүчирхийлэлд өртөх, хүчирхийллийг харж өсөх нь цаашид хүчирхийлэл үйлдэх нэг хүчин зүйл болж байна.

Зураг 8.5. Өөрсдийн болон хамтрагчийн хүүхэд байхдаа өссөн гэр бүлийн орчинд хүчирхийлэлтэй байсан гэж мэдүүлсэн эмэгтэйчүүдийн хувь, амьдралдаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн болон өртөөгүй байдлаар, 2017 он (N=6914)



Тайлбар: N=6914 – Судалгаанд хамрагдсан хамтрагчтай эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Хүчирхийллийг харж, мэдэрч өсөх нь насанд хүрсэн хойноо өөрөө хүчирхийлэгч болж төлөвшдөг болохыг ойлгуулахын тулд “Хүчирхийлэл хүчирхийлэгчийг төрүүлдэг” гэж олон мэргэжилтнүүд ярьдаг. Түүнчлэн, ЗБЯд оролцогчид гэр бүлийн хүчирхийлэлд өсөж буй хүүхдийн хүмүүжил доройтож, том болсон хойноо уураа барьж чаддаггүй, түрэмгий зан авиртай болж, хүчирхийлэгч болон төлөвших магадлал өндөр байдгийг онцолж байсан.

Мэргэжилтнүүдийн ярилцлага: 5 болон 7 настай хүүхэдтэй нэг эр хүүхдүүдээ байнга зоддог байв. “Та яагаад үргэлж хүүхдүүдээ зоддог юм бэ?” гэж асуухад тэрээр “Би тэдний насан дээр байхдаа тэдэн шиг жаргалтай байгаагүй. Энэ нь миний уурыг маш их хүргэдэг” гэж хариулсан юм.

Нийгмийн ажилтан

Мэргэжилтнүүдийн ярилцлага: Гэр бүлийн хүчирхийлэлтэй орчинд өсч буй хүүхдүүд сэтгэл зүйн эмгэгтэй, зан аашны хувьд өөрчлөлттэй болж төлөвшдөг.

Эмч

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Би өөрийгөө өнгөрсөн хүн гэж боддог. 3 хүүхдээ тайван байлгах юмсан. Хичээлийг нь тайван орчинд хийлгэх юмсан гэж боддог. Хамгийн сүүлийн процесс бол охиныгоо бодоод тусдаа гарсан. “Ээжээ одоо больё, 2 дүүгээ аваад айлын байр хөлслөөд тусдаа гарах хэрэгтэй. Энэ орчинд би хичээлээ хийж чадахгүй байна” гэсэн. Нүднээс нь нулимс гарч байсан. Би хүүхдээ буруу замаар оруулах гэж байна гэж ухаарсан.

40–64 насны бүлгийн эмэгтэйчүүд

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Том хүү маань хүнтэй харьцахдаа хэг ёг гээд ярьж, харьцдаг болсон. Хүмүүсийн өөдөөс ална, шулна гээд аавынхаа зан ариншин, муу аашийг нь дуурайсан. Тэгээд яадаг юм, ингээд яадаг юм гэж хүмүүстэй хэрэлдэх жишээтэй болсон.

25–39 насны бүлгийн эмэгтэйчүүд

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Хүүхдүүд ааваасаа айж орон доогуур ордог байсан. Хамгийн бага хүү маань бие муутай группт байдаг, надтай цуг амьдардаг. Нэг хүүхэд маань архи дарс ууж байна. Архи дарс ууж намайг зовоодог.


40–64 насны бүлгийн эмэгтэйчүүд




БҮЛЭГ 9.

ХҮЧИРХИЙЛЛИЙГ ДАВАН ТУУЛЖ БУЙ БАЙДАЛ


Хамтрагчийн хүчирхийллийн талаар бусдад хэлсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь




Найз, нөхөд




Эцэг, эх



Хадам, түүний
хамаатнууд




Хэнд ч хэлээгүй




Цагдаа


Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд тусалсан байдал




Эцэг, эх




Найз, нөхөд



Ах, эгч



Хадам, түүний
хамаатнууд



Хэн ч туслаагүй

Энэ бүлэгт хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд хүчирхийллийг хэрхэн тэвчиж, даван туулдаг, хаана, хэнд ханддаг, хэнээс тусламж хүсдэг болон авсан тусламждаа хэр сэтгэл хангалуун байсан талаарх мэдээллийг оруулав. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэй нэгээс илүү хамтрагчийн хүчирхийлэлд өртөж байсан тохиолдолд хамгийн сүүлийн хамтрагчийн хүчирхийллийн талаар тодруулан судалсан болно.

9.1 ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ҮЕДЭЭ ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА, ХЭНД ХАНДДАГ ВЭ?

Хамтрагчийнхаа зүгээс бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн дөрвөн эмэгтэй тутмын нэг буюу 26.5 хувь нь хүчирхийлэлд өртсөн тухайгаа “хэнд ч хэлээгүй” байна. Харин гурван эмэгтэй тутмын нэг буюу 36.0 хувь нь найз нөхөддөө, 32.9 хувь нь эцэг эхдээ, 31.4 хувь нь хадам болон хамтрагчийн хамаатнуудад хэлдэг байна. Анхаарууштай нь арван эмэгтэй тутмын нэгээс бага нь буюу 8.3 хувь нь л цагдаад ханджээ.


Зураг 9.1. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн хамтрагчийнхаа зан авир, үйлдлийн талаар хэн нэгэнд хэлж, мэдэгдсэн хувь, 2017 он (N=2175)



Тайлбар: N=2175 – Хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн тоо

Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 43.6 хувь нь хэн ч туслаагүй гэж хариулсан бол эцэг, эх нь тусалсан гэж 23.0 хувь нь, найз, нөхөд нь тусалсан гэж 18.1 хувь нь, ах, эгч нь тусалсан гэж 15.5 хувь нь, хадам болон хамтрагчийн хамаатнууд тусалсан гэж 15.4 хувь нь хариулсан байна. Эндээс үзвэл эмэгтэйчүүдийн тусламж авах тохиолдол нь хөдөө орон нутагт амьдарч буй эмэгтэйчүүдээс илүү хот, суурин газарт ажиглагдаж байна.

Зураг 9.2. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдэд тусламж үзүүлсэн хүмүүс, хот, хөдөө, хувиар, 2017 он (N=2175)



Тайлбар: N=2175 – Хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Чанарын судалгааны дүнгээс харахад эмэгтэйчүүд хүчирхийллийн улмаас хэн нэгнээс тусламж дэмжлэг эрэлхийлэх эсэх шийдвэр нь гол төлөв ойр хавьд нь дэмжин туслах хүмүүс байгаа эсэхээс хамааралтай байна. Эцэг, эх, ах, эгч, дүүтэйгээ нэг орон нутагт амьдардаг тохиолдолд гэр бүлийнхэндээ хүчирхийлэлд өртсөн тухайгаа хэлж, улмаар тусламж, дэмжлэг хүсдэг байна. Харин гэр бүлийнхнээсээ хол амьдардаг бол найз, нөхөд, хамт ажиллагч, хадам ээж, аав, хөрш айлын хүмүүстээ ханддаг байна.

Эмэгтэйчүүдийн дунд нөхрийн болон өөрийн нэр хүндийг бодож, хүчирхийлэлд өртдөг тухайгаа хэлэхгүй, нуудаг тухай яриа судалгааны үеэр цөөн бус удаа гарсан. Эдгээр эмэгтэйчүүд “хүчирхийллийг тэвчиж, зохицно” гэж үзэж, дийлэнх нь хүчирхийллийн талаар мэдээлэх, хэн нэгнээс тусламж хүсэхээсээ и лүү үүнийгээ нууж амьдардаг байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Би ээжтэйгээ илэн далангүй ярилцдаг байсан. Сүүлийн үед ээжийгээ зовоохгүй гэж бодоод энэ тухайгаа ярихгүй байгаа юм. Эхэндээ учраа олохгүй, хавийн амьтанд амьдралаа дэлгэж, бэрүүддээ ч ярьдаг байсан. Гэтэл хүмүүс тус болохын оронд харин хов жив болгоод, дэмий юм байна гэдгийг ойлгосон.

20–24 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Ажлын газрынхаа эгчид ханддаг байсан, сайхан сэтгэлтэй тэр эгч л намайг ойлгож, дэмждэг байсан.

40–64 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Нөхөр маань намайг зодсон тухай хадам ээждээ хэлэхэд юу ч дуугараагүй, хүүхдээ өмөөрдөг юм байна лээ.

20–24 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Хөрш айлын хүүхдүүд орж ирж, тусалдаг.

25–39 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

9.2 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХАНДСАН БАЙГУУЛЛАГА, ҮЙЛЧИЛГЭЭ

Хамтрагчийнхаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд тусламж авахаар хандаж болох хэд хэдэн байгууллага байдаг. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн ямар байгууллагад хандсан тухай судлахад дөрвөн эмэгтэй тутмын нэг буюу 23.9 хувь нь цагдаад, арван эмэгтэй тутмын нэг буюу 13.2 хувь нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад, 12.5 хувь нь лам, шашны тэргүүнд ханддаг гэж хариулсан бол хамгаалах байр болон бусад тусламж, үйлчилгээний байгууллагад маш бага буюу 1.5 хүртэлх хувь нь л ханджээ.

Зураг 9.3. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн тусламж хүсэхээр хандсан байгууллага, үйлчилгээ, хувиар, 2017 он (N=2175)



Тайлбар: N=2175 – Хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Эмэгтэйчүүд цагдаагийн байгууллагад мэдээлэх нь тус болдоггүй гэж үзэж байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Цагдаа дуудна, мэдээлнэ, цагдаа нь дургүйцэж, үл тооно. Цагдаа дуудахаар хашаа даваад зугтаасан. Цагдаа орж ирээд “ороод ирэхээр нь хэлээрэй” гэсэн. Гэхдээ ахиж ирээгүй. Нөхрөөсөө салсан ч цагдаа намайг хамгаалахгүй юм байна гэж ойлгосон. Одоогоор зодож нүдсэн ч арай гайгүй зодох байх гэж бодоод ахынхаа гадаа буусан.

35–64 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Цагдаад хэлэхээр улам их дарамт ирнэ гэж болгоомжилдог. Анх биед халдахад л мэдэгдэх ёстой юм байна лээ. Дараа нь байдаг л зүйл гээд байнга зоддог болох байх. Хамгаалдаг газар байвал хандах хэрэгтэй гэж боддог болсон. Гэхдээ хаана, хэрхэн хандахаа мэдэхгүй байна.

35–64 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Цагдаад хоёр, гурван ч удаа хэлсэн. Цагдаа 3–4 цаг байлгаад загнаж байгаад л явуулдаг. Тэгээд ирсэн хойноо “Чи цагдаад хэлдэг хэн бэ” гээд л загнаж, зоддог.

40–64 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Цагдаа үүнээс хойш зодох, янз бүрээр доромжлох, хөөж туувал шууд манайд ирээрэй гэсэн. Манайд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төв байдаг. Нүцгэн хөөж гаргасан ч хамаагүй ир, манайд орогнуулах газар байдаг, холбогдоорой гэсэн.

35–64 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Гүнзгийрүүлсэн ярилцлага: Би 3 хүүхдийн хамт Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хамгаалах байранд түр хугацаагаар байрлаж байна. Иргэний хэрэг үүсгэж, гэр бүлээ цуцлуулах, эд хөрөнгийн маргаан, хүүхдийн тэтгэвэр тогтоолгох зэргээр шүүхийн асуудлаа шийдэх гэж Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандсан. Тэсэхээ болиод, амьд л явъя гэж бодоод гэрээсээ гарсан. Тэгтэл намайг тэнэмэл амьдралыг сонгосон гэж нөхөр дүгнэж байгаа. 20.0 хувийн хараатай хүн хараагүй болчихвол би яаж амьдрах юм бэ, тэнэхтэй манатай байдалд орно. Нэг удаа зодоод группт оруулчихлаа, тэгээд болихгүй, нойтон устай алчуураар нүүр нүдгүй ороолгосон. Намайг Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд очсон гэхээр нөхөр “юу хийж тэнд очиж байгаа юм бэ, ухаан нь муудаа юу, солиорсон юмуу” гэж хэлж байсан. Өрхийн эмнэлэг, хороо, нийгмийн ажилтан, халамжийн хэлтэст очихоор миний яриад байгаад итгэдэггүй.

35–64 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

ЗАРИМ ЭМЭГТЭЙЧҮҮД ТУСЛАМЖ ХҮСЭЖ БАЙХАД ЗАРИМ НЬ ЯАГААД ТУСЛАМЖ ХҮСДЭГГҮЙ ВЭ?

Дараах зурагт хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд аль нэг байгууллага, үйлчилгээнд хандах болсон шалтгааныг харуулав (Зураг 9.4). Хариулагчид нэгээс олон хариултыг сонгох боломжтой байсан учир хариултуудын нийлбэр 100 хувиас өндөр гарна. Хүчирхийлэлд өртсөн гурван эмэгтэй тутмын хоёр буюу 68.7 хувь нь хүчирхийллийг тэвчих аргагүй болсны улмаас, 42.7 хувь нь бэртэл, гэмтэл авсны улмаас тусламж хүсэн ямар нэгэн байгууллага, үйлчилгээнд хандсан байна. Мөн 17.0 хувь нь хүчирхийлэл нь улам их болохоос айсан, 15.2 хувь нь хүүхдүүдээ зовж байгааг хараад тусламж хүссэн гэж хариулжээ.


Зураг 9.4. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн ямар нэгэн байгууллага, үйлчилгээнд хандсан шалтгаан, хувиар, 2017 он (N=647)



Тайлбар: N=647 – Тусламж авсан эмэгтэйчүүдийн тоо

Дөрвөн эмэгтэй тутмын гурав нь буюу 75.4 хувь нь ямар нэгэн байгууллага, тусламж үйлчилгээнд хандаж авсан үйлчилгээндээ сэтгэл хангалуун байсан ба үйлчилгээний төрлөөс шалтгаалан авсан сэтгэл ханамж ялгаатай байв. Ялангуяа эмэгтэйчүүдийн 91.6 хувь нь сэтгэл зүйн үйлчилгээнд, 80–аас илүү хувь нь нийгмийн үйлчилгээний газар, эмнэлэг/эрүүл мэндийн төвийн үйлчилгээнд сэтгэл хангалуун гэсэн үнэлгээг өгсөн бол эмэгтэйчүүдийн байгууллага, хуулийн зөвлөх үйлчилгээ, цагдаагийн байгууллага зэрэгт ихэнх нь сэтгэл хангалуун байсан хэдий ч харьцангуй бага үнэлгээ өгсөн байна. Энэ нь хууль эрх зүйн талын үйлчилгээнүүд нь ихэвчлэн хүчирхийлэл үйлдэгчдэд арга хэмжээ авдаг бол эрүүл мэнд болон нийгмийн үйлчилгээ нь илүү хохирогчийн хэрэгцээнд төвлөрсөн байдагтай холбоотой.

Зураг 9.5. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн байгууллага, үйлчилгээнд сэтгэл хангалуун байдал, үйлчилгээгээр, 2017 он (N=647)



Тайлбар: N=647–Тусламж авсан эмэгтэйчүүдийн тоо

Эмэгтэйчүүдээс ямар нэгэн байгууллага, үйлчилгээнд хандаагүй шалтгааныг тодруулж асуухад гэр бүлийн нэр хүнд унана гэдгээс сэргийлсэн гэж дөрвөн эмэгтэй тутмын нэг буюу 25.9 хувь нь хариулсан байна (Зураг 9.6). Харин таван эмэгтэй тутмын нэг буюу 20.9 хувь нь хүчирхийллийг ноцтой асуудал биш, байдаг л зүйл гэдэгтэй эвлэрсэн байна.

Зураг 9.6. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэлбэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн ямар нэгэн байгууллага, үйлчилгээнд хандаагүй шалтгаан, хувиар, 2017 он (N=1527)




Тайлбар: N=1527 – Хүчирхийлэлд өртсөн, тусламж хүсэхээр байгууллага, үйлчилгээнд хандаагүй эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцсон хамтрагчийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдээс хэн хэн нь ч хамтарсан багт хандаж тусламж хүсээгүй байна. Харин бэлгийн хүчирхийлэлд өртсөн охиныг өсвөр үеийнхний эмнэлэгт үзүүлэх үед нь эмч нар мэдсэнээр сэтгэл зүйчид хандаж түүний зөвлөснөөр цагдаад хандсан байна.

9.3 ХҮЧИРХИЙЛЛЭЭС ЗУГТАЖ ГЭРЭЭСЭЭ ДАЙЖИЖ БАЙСАН ЭСЭХ

Хамтрагчтайгаа нэг гэрт амьдардаг байсан бөгөөд хамтрагчийн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тал гаруй хувь буюу 51.2 хувь нь гэрээсээ нэг ба түүнээс олон удаа дайжиж байсан гэж хариулсан. Гурван эмэгтэй тутмын нэг буюу 35.0 хувь нь 1–5 удаа, 6.0 хувь нь 6–10 удаа гэрээ орхиж байсан бол 3.9 хувь нь 21–ээс дээш удаа гэрээ орхин явж байжээ (Зураг 9.7).

Зураг 9.7. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн гэрээ орхиж явсан давтамж, 2017 он (N=2175)



Тайлбар: N=2175 – Хамтрагчийн зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн тоо

Гэрээ орхиж, дайжиж байсан нийт эмэгтэйчүүдийн ойролцоогоор дөрөвний гурав нь буюу 72.4 хувь нь хүчирхийллийг тэвчих аргагүй болсон, 18.8 хувь нь бэртэл, гэмтэл авсан, 16.1 хувь нь гэрээсээ хөөгдсөний улмаас явсан гэж хариулжээ (Зураг 9.8). Эмэгтэйчүүдийн гэрээсээ дайжсан шалтгааны 15–аас дээш хувь нь хүүхдээс хамаарсан буюу 10.6 хувь нь хүүхдүүдээ зовж байгааг харсан, 4.8 хувь нь хүүхдүүдэд заналхийлсэн, эсвэл гар хүрсэн шалтгаантай байв.

Зураг 9.8. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн гэрээ орхиж явах болсон шалтгаан, хувиар, 2017 он (N=1008)



Тайлбар: N=1008 – Хүчирхийллийн улмаас гэрээ орхин явж байсан эмэгтэйчүүдийн тоо

Гэрээ орхин явж байсан нийт эмэгтэйчүүдийн 73.2 хувь нь гэрээ орхиж явахдаа өөрийн хамаатны гэрт очдог бол 12.9 хувь нь найз нөхөд болон хөршийнд очдог гэж хариулсан байна. Мөн 3.3 хувь нь зочид буудал, түр байрлах газарт, 2.8 хувь нь гудамжинд хоноглодог, 2.7 хувь нь хамтрагчийн хамаатны гэрт, 0.2 хувь нь сүм, хийдэд очдог гэжээ.

Зураг 9.9. Хамтрагчтай байсан/ байгаа эмэгтэйчүүдийн хамтрагчийнхаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийллийн улмаас гэрээсээ дайжсан эмэгтэйчүүдийн хувь, очсон газраар нь, 2017 он (N=1008)



Тайлбар: N=1008 – Хүчирхийллийн улмаас гэрээ орхин явж байсан эмэгтэйчүүдийн тоо

Гэрээсээ явсан хугацааны тухайд эдгээр эмэгтэйчүүдийн 58.6 хувь нь нэг сараас бага хугацаагаар, 17.4 хувь нь нэг сараас дээш хугацаагаар, дөрвөн эмэгтэй тутмын нэг буюу 24.1 хувь нь гэрээсээ бүр мөсөн явсан гэж хариулжээ.


Гэрээсээ явчихаад эргэж очсон эмэгтэйчүүдийн 34.4 хувь нь хамтрагчаа уучилсан, 33.0 хувь нь хамтрагч нь буцаж ирэхийг гуйсан, 33.0 хувь нь хүүхдүүдээ орхихыг хүсээгүй гэсэн шалтгаанаар эргэж очсон бол 25.6 хувь нь гэр бүлээ салгахыг хүсээгүй ба 24.5 хувь нь гэр бүлийн нэр төрийг бодож гэртээ буцаж очсон гэжээ (нэг хүн нэгээс дээш хариулт хэлэх боломжтой байсан). Харин 16.5 хувь нь хамтрагчаа засарч, өөрчлөгдөнө гэдэгт найдсан учраас гэртээ эргэн очдог байна. Мөн 14.7 хувь нь хүүхдүүдээ бодсон учраас, 6.7 хувь нь гэр бүлийнхэн оролцож гуйсан учраас, 5.5 хувь нь хамтрагчдаа сайхан сэтгэл гаргаж гэртээ буцаж очсон байна. Нийт эмэгтэйчүүдийн 10 хүрэхгүй хувь нь очсон газартаа удаан байх боломжгүй, хүчирхийлэл ноцтой асуудал биш, хүүхдэд заналхийлсэн гэх мэт шалтгааны улмаас эргэн очдог гэж хариулжээ.

Харин хүчирхийллийг тэвчиж, гэрээ орхиж яваагүй эмэгтэйчүүдийн 36.2 хувь нь хүүхдээ орхихыг хүсээгүй гэсэн шалтгааны улмаас гэрээсээ яваагүй гэж хариулсан байна. Улмаар 24.1 хувь нь гэр бүлээ салгахыг хүсээгүй, 21.0 хувь нь хамтрагчаа уучилсан, 17.1 хувь нь гэр бүлийн нэр төрийг бодсон, 10.7 хувь нь хүүхдүүдээ элэг бүтэн өсгөхийг хүссэн, 9.6 хувь нь хүчирхийлэл ноцтой асуудал биш, 8.9 хувь нь хамтрагчаа өөрчлөгдөнө гэж найдсан, 7.7 хувь нь хамтрагчаа хайрладаг, 4.1 хувь нь ганц бие байхыг хүсээгүй гэх шалтгааныг нэрлэжээ.

9.4 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ЭМЭГТЭЙ ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛСЭН ЭСЭХ

Эмэгтэйчүүдийн 63.7 хувь нь хамтрагчийн бие махбодын хүчирхийллээс өөрийгөө хамгаалан ямар нэгэн эсэргүүцэл үзүүлсэн байна. Тэдгээр эмэгтэйчүүдийн дөрвөн эмэгтэй тутмын нэг буюу 22.7 хувь нь эсэргүүцэл үзүүлснээр ямар нэгэн өөрчлөлт гараагүй гэж хариулжээ. Харин 34.0 хувь нь хүчирхийлэл нэмэгдсэн гэж хариулсан бол 31.7 хувь нь хүчирхийлэл багассан гэжээ. Харин бие махбодын хүчирхийлэлд өртөж байх үедээ өөрийгөө хамгаалан хариу үйлдэл үзүүлж байсан арван эмэгтэй тутмын нэг нь хамтрагчийн хүчирхийлэл зогссон гэж хариулжээ.

Зураг 9.10. Хамтрагчтай байсан/ байгаа, хамтрагчийн зүгээс үзүүлсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хариу эсэргүүцэл үзүүлснээр гарсан өөрчлөлт, 2017 он (N=1249)



Тайлбар: N=1249 – Бие махбодын хүчирхийлэлд өртсөн, хариу үйлдэл үзүүлсэн эмэгтэйчүүдийн тоо

Чанарын судалгаа: Эмэгтэйчүүд хамтрагч нь өөрт халдахад өөрийгөө хамгаалах үүднээс зодолдох, зугтаах болон өөрийгөө хамгаалж чаддаггүйн улмаас зодуулдаг гэж ганцаарчилсан ярилцлагын үед хариулсан байна. Хүчирхийлэгчийн зүгээс хаалга, пинг цоожлох, гар утсыг нь булаан авах зэрэг нь эмэгтэйчүүдэд өөрийгөө хамгаалах боломжгүй нөхцлийг бий болгодог. Цөөн тооны эмэгтэйчүүд хүүхдүүдээ хамгаалахын тулд өөрийгөө зодуулдаг, толгойгоо юун түрүүнд хамгаалдаг гэх зэргээр хариулсан. Өөрийгөө хамгаалах гол үйлдлүүдийг дурдахад:

- 1. Зугтаах.** Өөрийгөө, үр хүүхдүүдээ хамгаалах үүднээс ганцаараа болон хүүхдүүдтэйгээ хамт зугтаадаг гэсэн хариулт хамгийн олон давтамжтай хариулт байв. Хүчирхийлэлд өртөгч нь орон сууцанд амьдардаг бол оронд гарч тайвшрах, унтахыг нь хүлээх, гэр хороолол болон хөдөө амьдардаг бол гадаа гарч зугтаах, пин, вагончик, айлын жорлон, голын эргээр хонох (зуны цагт), айл руу зугтааж орох (орох дотны айлтай тохиолдолд) зэрэг үйлдлүүдийг ихэвчлэн хийдэг байна. Нэг талаас зугтааж орсон айл нь хүчирхийлэгчийн дарамт, заналхийлэлд өртдөг зэрэг шалтгаанаар зарим эмэгтэйчүүд айлд орохоос татгалздаг байна.
- 2. Цагдаа дуудах.** Хүчирхийлэлд өртсөн эмэгтэй бус түүний аав, ээж, хамаатан садан, хөрш айл, том болсон хүүхдүүд нь цагдаа дуудах арга хэмжээ авдаг байна. Цагдаагийн тусламж авах тухай хэд хэдэн ялгаатай хандлага судалгаагаар ажиглагдсан бөгөөд энэ талаар дээр дэлгэрүүлж авч үзсэн.
- 3. Аргадах, тайвшруулах.** Олон жил, удаа дараагийн хүчирхийлэлд өртсөн, тэвчиж амьдрахаас өөр боломжгүй гэж бодсон эмэгтэйчүүд хүчирхийлэгчийг аргадаад унтуулах, уучлал гуйх, уурыг нь хүргэхгүй, дуугарахгүй байх, гэр орныхоо ажлыг хийх, халуун хоолтой угтах, халамжлах зэргээр өөрийгөө болон үр хүүхдээ хамгаалдаг тухай яриув.
